

ЭГЭЭББ судалгааны төсөл, Монгол улс

Даланжаргалан сумын тайлан

2017 оны 7-р сар

Е.Далей, Я.Нарангэрэл, К.Ланз, Н.Лхамдулам, З.Дрисколл, Б.Сувд,
Б.Мөнхтүвшин, Ж.Грахам, Р.Эрдэнэбат



ЭГЭЭББ судалгааны төсөл, Монгол улс – Даланжаргалан сумын тайлан, 2017 оны 7-р сар,
цахим хувилбарыг дараах хаягаар авна уу: www.mokoro.co.uk/wolts.
Текст © ЭГЭЭББ төслийн баг. Бүх фото зураг © ЭГЭЭББ төслийн баг.

ЭГЭЭББ судалгааны төсөл, Монгол улс

Даланжаргалан сумын тайлан

2017 оны 7-р сар

Танилцуулга – ЭГЭЭББ судалгааны төслийн арга зүй	1
Байршил, хүн ам	2
Даланжаргалан сумын таван баг.....	3
Хүн ам, эдийн засгийн өөрчлөлтийн сүүлийн үеийн түүх	4
Амьжиргаа ба жендерийн харилцаа	5
Гэрлэлт, гэр бүлийн нөхцөл байдал	5
Боловсрол	7
Хөрөнгө чинээ, ядуурал	8
Орон сууц	8
Өмч хөрөнгө	10
Цахилгаан, ус, ариун цэврийн байгууламж	10
Тээврийн хэрэгсэл.....	11
Үндсэн амьжиргаа	12
Мал аж ахуй	15
Газар тариалан.....	17
Жендерийн харилцаа	19
Уул уурхайн компаниуд, бичил уурхай.....	20
Уул уурхайн компаниуд	23
Хөрөнгө оруулалтын үе шат.....	23
Ажил эрхлэлт ба компанийн нийгмийн хариуцлага (КНХ)	24
Бичил уурхай.....	26
Уул уурхайн үр нөлөө	27
Газар олгох үйл явц	31
Орон сууцны газар.....	32
Өвөлжөө, хаваржааны газар	34
Газар тариалан, бизнесийн зориулалттай газар	35
Газрын маргаан	36
Их Нартын байгалийн нөөц газар.....	37
Бэлчээрийн менежмент	37
Отор нүүдэл ба нүүдлийн хэв маягын өөрчлөлт	40
Эмэгтэй малчид, эмзэг бүлгийн хүмүүст учирч буй бэрхшээл	41
Дүгнэлт	42

Товчлол

АМХЭГ	Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар
ЗБУ	Зорилтот бүлгийн уулзалт
КНХ	Компанийн нийгмийн хариуцлага
ОН	Ойн нөхөрлөл
ХХЯ	Хувь хүний ярилцлага
ХТБХ	Хүн Төвтэй Байгаль Хамгаалал
ШХА	Швейцарын Хөгжлийн Агентлаг
ЭГЭЭББ	Эмэгтэйчүүдийн газар эдэлбэрийн эрхийн баталгаат байдал төсөл

Танилцуулга – ЭГЭЭББ судалгааны төслийн арга зүй

Мокоро байгууллагын практик, үйл ажиллагаанд суурилсан үрт хугацааны стратегитайгаар гүйцэтгэж буй Эмэгтэйчүүдийн газар эдэлбэрийн эрхийн баталгаат байдал (ЭГЭЭББ) судалгааны төсөл нь “Монгол болон Танзани улсад эмэгтэйчүүдийн газар эдэлбэрийн аюулгүй байдалд учрах эрсдлийг судлах” судалгааны арга зүйг түршиж байгаа юм. Монгол улс дахь Хүн Төвтэй Байгаль Хамгаалал ТББ-тай хамтран уул уурхайн хөрөнгө оруулалтын нөлөөлөлд өртсөн бэлчээрийн газар нутаг дахь эмэгтэйчүүдийн газар эдэлбэрийн баталгаат байдал ямар байгааг танадан судалж, эмэгтэйчүүдийн болон нийгмийн эмзэг бүлгийн газрын эрхэд учруулах гол аюулуудыг тогтоохын тулд хамтын оролцооны болон тоон судалгааны аргын аль альныг нь ашиглан судалгаа хийж байна. ЭГЭЭББ төслийн зорилго нь газар эдэлбэрийн засаглал дахь жендерийн эрх тэгш байдлыг сайжруулах, эмзэг бүлгийнхний газрын эрхийн баталгаат байдалд учирж буй нутгийн иргэдийн дотооддоо байгаа аюулаас хамгаалан дэмжих боломжийг судлах юм. Мөн нутгийн иргэдэд тэдний газар болон байгалийн нөөцөд учрах гадны аюул заналаас сэргийлэхэд түслэх зорилготой билээ. (ЭГЭЭББ төслийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг манай цахим хуудаснаас үзээрэй: <http://mokoro.co.uk/wolts/>).

Энэхүү сумын тайланд бидний 2016 оны 4-р сараас 11-р сарын хооронд хийсэн анхны танилцах аялал, суурь судалгаа болон хамтын оролцооны судалгааны үр дүнг харуулж байна.

Бид 2016 оны 8-р сард суурь Даланжаргалан сумын бүх багын нийт өрхийн 10% -ыг хамруулан судалгаа явуулсан. Нийт 93 өрх хамрагдсан бөгөөд 74 өрх нь санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон бөгөөд нэмж 19 өрх толгойлсон эмэгтэйчүүдтэй өрхийг зориудаар сонгосон. Өөрөөр хэлбэл судалгааны нийт түүврийн 80 % нь санамсаргүй түүврийн аргаар сонгосон (57 эрэгтэй болон 17 өрх толгойлсон эмэгтэйчүүдтэй өрхүүд), 20% нь зориудаар сонгосон өрх толгойлсон эмэгтэйчүүд байв. Ингэж өрх толгойлсон эмэгтэйчүүдтэй өрхүүдийг судалгаанд илүү олноор хамруулж эмзэг бүлгийн жендерийн асуудлуудыг олж тогтоох зорилготой байв. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүдөөс цуглуулсан нэмэлт 19 өрхийн мэдээллийг суурь судалгааны ерөнхий дүн шинжилгээний бүх хэсэгт оруулалгүй харьцуулсан байдлаар дүн шинжилгээ хийв.

Бид 2016 оны 11-р сард хамтын оролцооны аргаар судалгаа хийж нийт 14 зорилтот бүлгийн уулзалт (ЗБУ), 11 хувь хүмүүстэй ярилцлага (ХХЯ) хийсэн байна. Нийт 94 хүнтэй уулзаж ярилцсан байна. Суурь судалгааны шинжилгээний үр дүнд үндэслэн цаашид нарийвчлан судлах шаардлагатай нийгмийн янз бүрийн бүлгийн төлөөллүүд болон хувь хүмүүстэй тусгайлсан уулзалт, ярилцлага хийхийг зорьсон (жишээ нь, бэлэвсэн хүмүүс, уурхайчид, гэрлэсэн эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд гэх мэт). ЗБУ-ын бүтцийг оролцооны аргыг ашиглаж боловсруулсан (байгалийн нөөцийн зураглал, нүүдлийн зураглал, улирлын хөдөлмөрийн ачаалал, оролцогч талуудын зураглал, дүн шинжилгээ). ХХЯ –н бүтцийг урьдчилан боловсруулж ярилцлага хийж буй хувь хүний нөхцөл байдалд тохируулан тэдний амь амьдрал, амьжиргааны талаар, тэдний хүүхэд байхаас нь эхлээд янз бүрийн байгалийн нөөцийг олж хүртэх хэлбэр, жендерийн харилцааны аль альных нь тухай мэдэж авах зорилготой асуултууд байв. Мөн бүх ЗБУ болон ХХЯ-д чөлөөт ярилцлагын цаг гаргаж байсан.

Мөн бид судалгааны хүрээнд орон нутгийн засаг захиргааны мэргэжилтнүүд, Даланжаргалан суманд ажиллаж буй байгууллагууд, компаниудын төлөөллүүдтэй ярилцлага хийсэн.

Бидний судалгааны ажилд оролцож, элгэмсэг хандсан Даланжаргалан сумын бүх ард иргэддээ талархаж байгаагаа нуух юун. Ялангуяа бидний ярилцлага, хэлэлцүүлэгт оролцож жендер, газар, бэлчээр, уул уурхайн асуудлуудыг танин мэдэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан хүмүүст талархлаа илэрхийлье.

ЭГЭЭББ төслийн багын гишүүд- Е.Далей, К.Ланз, Я. Нарангэрэл, Н.Лхамдулам, З.Дрисколл, Б.Сувд, Б.Мөнхтүвшин, Ж.Грахам, Р.Эрдэнэбат. Энэхүү тайлан нь бидний хийж гүйцэтгэсэн хамтын бүтээл юм.

Байршил, хүн ам

Даланжаргалан сум нь Говийн бүсийн Улаанбаатар хотоос хойш 288 км-ийн зайд Дорноговь аймагт оршдог. Нийт газрын хэмжээ нь 404, 590 га бөгөөд цөл хээрийн бэлчээр зонхилсон нутаг юм. 2016 оны 4-р сарын 6-ны байдлаар сумын хэмжээнд 90 уул уурхайн лиценз олгосон бөгөөд үүнээс 42 нь олборлолт, 48 нь хайгуулын лиценз юм. Даланжаргалан сум нүүрс, жонш, барилгын материал, төмөр, хагас үнэт чулуу (өнгөт чулуу) зэрэг ашигт малтмалын нөөцтэй. Даланжаргалан сум нийт 5 багтай, Цомог, Олон-овоо багууд сумын төвийн илүү хотжсон, хэмжээний хувьд жижиг, харин Элдэв, Өнгөт, Бичигт нь хөдөөний, хэмжээний хувьд том багууд юм.

2016 оны 7-р сарын 28 –ны байдлаар нийт 2,641 хүн амтай, 916 өрхтэй байв. Энэ нь Даланжаргалан суманд бүртгэлтэй үндсэн иргэдийн тоо бөгөөд уул уурхайн компаниудын ажиллаж, амьдарч байгаа уурхайн ажилтнуудын тоог оруулаагүй. Уурхайн үйл ажиллагааны түвшнөөс шалтгаалан тэдний тоо хэзээд өөрчлөгдөж байдаг учир олон янзын компанийн ажилчдын байранд амьдарч байгаа иргэдийг оруулаагүй болно. Мөн Бичигт, Олон-Овоо багуудад хууль бусаар бичил уурхай эрхэлж байгаа (жоншны) иргэд, Өнгөт багт өнгөт чулуу түүж, ухаж байгаа иргэд, зэргэлдээх сумдын отроор явж байгаа малчид зэрэг суманд бүртгэлгүй түр зуурын оршин суугчдыг оруулаагүй. Багуудын өрхийн тоон 1-р хүснэгтэд харуулав. Сумын хүн амын нягтрал 1 га –д 0.007 хүн ноогдож байна. Газар зүйн хувьд 4 багын хэмжээ харилцан адилгүй, багын тухай мэдээлэл дутмагаас баг бүрийн хүн амын нягтралыг тооцоолох боломжгүй байсан.

Хүснэгт 1. Даланжаргалан сум, өрхийн тоо, багаар

Баг	Өрхийн тоо
Бичигт	145
Цомог	231
Олон овоо	234
Өнгөт	176
Элдэв	130
Даланжаргалан нийт	916

Эх үүсвэр: 2016 оны 7-р сарын 28. Даланжаргалан сумын захиргаанаас гаргасан албан ёсны мэдээлэл.

Суурь судалгааны үеэр ярилцлага авсан өрхүүдээс нэг хот айлд ноогдох өрхийн тоо ихэвчлэн нэг байсан (74 санамсаргүй түүврээр сонгогдсон өрхийн 30 нь) зарим айлын өвөлжөө хөршөөсөө 20 км-ийн цаана байдаг, харин Олон-Овоо, Цомог баг тус бүрт байх нэг өрх нэг гудамжиндаа 20 өрхтэй байв.

Суурь судалгаанд нийт 36 өрх толгойлсон эмэгтэйтэй өрх хамрагдсан ба үүнээс 17 буюу 23% нь 74 санамсаргүй түүвэрт байсан. Сумын нийт дүнд шилжүүлэн тооцвол судалгаа явагдах үед сумын хэмжээнд нийт 211 өрх толгойлсон эмэгтэйтэй өрх байсан гэсэн тооцоо гарч байна.

Санамсаргүй түүвэрт байх нэг өрхийн дундаж гишүүний тоо 3.68 хүн гэж гарсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй 36 өрхийн дундаж гишүүний тоо 3.75 байна. Тэргүүн нь эрэгтэй 57 өрхийн дундаж гишүүний тоо 3.63 байна.

Санамсаргүй түүврийн өрхөд нийт 267 (127 эмэгтэй, 140 эрэгтэй) хүн амьдардаг байсан ба 2-р хүснэгтэд насны бүтцийг харуулав.

Хүснэгт 2. Даланжаргалан сумын санамсаргүй түүврийн өрхөд амьдарч буй хүмүүсийн насны бүтэц

Нас (жилээр)	Хүмүүсийн тоо	Насны бүлэгт байгаа хүмүүсийн эзлэх хувь
5 ба түүнээс доош	32	12%
6 -12	34	13%
13 -18	30	11%
18-24	27	10%
25-34	29	11%
35-44	47	18%
45-54	24	9%
55-64	23	9%
65-74	17	6%
75 ба түүнээс дээш	4	1%
Нийт	267	100%

Эр сурвалж: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Түүврийн хэмжээ N = 267.

2-р хүснэгтэд байгаа мэдээлэлд үндэслэн нийт хүн амд шилжүүлэн тооцвол Даланжаргалан сумын албан ёсны бүртгэлтэй иргэдийн 36% нь хүүхэд (18 ба түүнээс доош настай), 8% нь ахмадууд (65 ба түүнээс дээш настай), 56% нь хөдөлмөрийн насны насанд хүрэгсэд (19 өөс 64 настай) байхаар байна.

Даланжаргалан сумын хүн амын ихэнх нь халх үндэстэн буюу санамсаргүй түүврийн өрхийн тэргүүлэгчдийн 95 % (70) нь халх хүмүүс байна. Мөн ихэнх нь буюу 66% (49) нь буддын шашин шүтдэг байна. Санамсаргүй түүврийн өрхийн тэргүүлэгчдийн хорин найман хувь нь (21) нь ямар нэгэн шашин шүтлэггүй гэж хариулсан байна. Үлдсэн нь бөөгийн юмүү христийн шашинтай хэмээн өөрсдийгөө тодорхойлсон байна. Мөн суманд Баяд, Буриад, Мянгад хүмүүс амьдардаг нь харагдсан.

Даланжаргалан сумын таван баг

Даланжаргалан сумын хоёр хотжсон баг нь сумын төвийн Цомог нөгөө нь сумын төвөөс хойд зүгт орших жоншны уурхайгаас үүдэлтэй хүмүүс суурьшиж эхэлсэн, төмөр зам болон үйлдвэрлэл хөгжсөн Олон-Овоо баг юм. Цомог багт нутгийн захиргааны байшин, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, банк, Цомог төмөр замын зогсоол байдаг. Энэ Транс-Сибирийн төмөр зам бөгөөд Улаанбаатар болон Хятад улстай хил залгаа Замын-Үүд хоёрын хооронд явдаг. Хил хамгаалах зэвсэгт хүчний байгууламж Цомог багт бий. Олон-Овоо баг 2008 онд захиргааны статустай болсон, урьд нь Цомог багын нэг хэсэг байв. Олон-Овоод бага сургууль, цэцэрлэг, банк, соёлын төв, хэд хэдэн дэлгүүр бий. Мөн Хятад руу явдаг хэд хэдэн замтай төмөр замын зогсоолтой, цемент, жонш, нүүрсний боловсруулах үйлдвэрүүдтэй.

Цомог, Олон-Овоо багт ихэвчлэн төрийн ажилтнууд, төмөр зам, үйлдвэрийн ажилчид амьдардаг ба олонхийнх нь орон сууцыг ажил олгогчоос хангаж өгсөн байдаг. Мөн засварын цех эсхүл дэлгүүрийн жижиг бизнесүүд байдаг. Цомог багт мал бүхий иргэд, нарийн харвал гэр бүлийн гишүүд салангид амьдардаг өрхүүд их байдаг. Эхнэр, хүүхдүүд нь хичээлийн жилд сумын төвд амьдарч, нөхөр нь малаа хариулж өвөлжөөндөө үлддэг. Энэ тухай доор дэлгэрүүлэн үзнэ.

Бичигт баг сумын баруун талд Улаанбаатараас Хятадын хил рүү явдаг гол замын урд байдаг. Цомог, Олон-Овоо баг энэ замын хоёр талаар байдаг.

Их нартн байгалийн нөөц газрын зарим хэсэг Бичигт багт байдаг. Хуурай тал хээрийн бэлчээр болон цөлөрхөг хээрийн хэв шинжийг агуулсан хад чулуу тохиолддог газар нутагтай, ховор амьтан аргалийн нутаг юм. Мөн тэнд хэд хэдэн рашаан, сувилал, жуулчны бааз, судалгааны төв, гэр бааз байдаг.

Нөөц газрын ойролцоо жоншны уурхайнууд байдаг бөгөөд 2016 оны бидний ажлын үеэр улсын эдийн засгын хямралаас шалтгаалан уул уурхайн салбар уналтад орсон учир ихэнх нь ажиллаагүй байсан. Бичигт багын хүмүүсийн ихэнх нь малчид. Бичигт багт давст нуур, тэжээлийн талбай байдаг бөгөөд бусад баг, сумдын малчид ашигладаг.

Өнгөт баг нь сумын баруун хойно, Элдэв баг зүүн хойно байдаг бөгөөд аль аль нь малчид амьдардаг. Элдэв багт хоёр жоншны уурхай, дөрвөн нүүрсний уурхай байдгаас хамгийн том нь МАК-ын Элдвийн нүүрсний уурхай юм. Тэд сумын төвөөс 30 гаруй км-ийн зайд өөрсдийн оффис, ажилчдын байрныхаа хажууд 2016 онд 100 хүний багтаамжтай хурлын өрөө бүхий, цахилгаантай жижиг багын төв барьсан.

Өнгөт багт одоо ажиллагаатай болон ажиллагаагүй жоншны уурхайнууд, төмрийн уурхай, багын нутаг дэвсгэрийн томоохон хэсэгт цацагдсан мэт хагас үнэт чулуу (chalcedony - өнгөт чулуу) байдаг. Мөн Өнгөт багт Далан түрүүний рашааны хажууд социализмын үед рашаан, сувилал байсан хуучны газар байдаг. Энэ амралтын газарт социализмын үед малчдын гавьяаг магтан дуулсан хонины хөшөө байдаг. Бидний 2016 оны ажлын үеэр энэ хавьцаа хэд хэдэн өрх айлууд багахан хэмжээний газар дээр хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуй эрхэлж байв.

Хүн ам, эдийн засгийн өөрчлөлтийн сүүлийн үеийн түүх

Манай ЗБУ, ХХЯ-д оролцсон хүмүүс социализмын үед уул уурхайн үйл ажиллагаа хязгаарлагдмал, суманд тариалан эрхэлдэггүй байсан гэв. Цаг уур, ургамлын хувьд Говийн бүс нутгийг хонь, ямаанд хамгийн их тохиромжтой гэж үздэг байсан учир бүх газар бэлчээр байсан. Даланжаргалан сум, тэр үеийнхээр бол Их Жаргалан сумын малчид 1950 оны сүүлээр нэгдэл байгуулагдах хүртэл хувь хувиараа аж ахуй эрхэлж байв. 1960 аад оноос бүх мал төрийн өмч болсноор Монгол орны бусад малчдын адил нэгдлийн малыг хариулж төрөөс тогтмол цалин авч эхэлсэн.

Тэр үед нэгдлийн бэлчээрийн менежмент, зохицуулалтыг төрийн захиргаа хариуцдаг байсан ба холбогдох сумын ажилтнууд зохион байгуулдаг байсан. Даланжаргалан сумын захиргаанаас малчдын улирлын нүүдлийн тээврийн хэрэгслийг хангах, усны нөөцөөр хангах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, хүнд хүчир, туслах ажил хийхэд туслах зэргээр ажиллаж байв.

Бидний ЗБУ, ХХЯ-аар зарим ахмад хүмүүс тэр үед нөхцөл байдал сайхан, Говийн баянбүрд шиг, одоогийнхийг бодвол бэлчээрийн гарц маш сайн, олон төрлийн ургамалтай сайхан байжээ хэмээн сэтгэл хөдлөм дурсаж байлаа.

1990 оноос хойш Монгол даяар нэгдэл тарж, мал хувьд шилжив. Энэхүү нэгдлийн өмчөөс хувийн өмчид шилжсэн томоохон өөрчлөлт, төрийн үнэгүй үйлчилгээ гэнэт буурсан зэргээс шалтгаалан малчдын дундахь ядуурал ихэсч, баян ядуугийн заагыг ихэсгээд зогсохгүй газрын доройтолд хүргэсэн хэмээн ЗБУ, ХХЯ-д оролцогчид хэлсэн. Ялангуяа, улирлын нүүдэл суудалд тээврийн хэрэгслээр тусалдаг байсан төрийн үйлчилгээ зогссон тул хол амьдардаг малчид усныхаа ойролцоо суурьших болсноор бэлчээр талхлах зэрэг асуудал үүссэн тухай бид доор үзнэ.


Нэгдлийн харьяанд байсан малчид хувьчилж авсан малдаа ямар нэгэн төлбөр төлөөгүй. Гэхдээ хувьчлал явагдахад мөн туршлагагүй, залуу малчдын тоо нэмэгдсэн бөгөөд тэд улирлын нүүдэл хийж сураагүй, бэлчээрийн менежментийн практик туршлагагүй байсан учир сумын газар доройтоход бас хувь нэмэр оруулсан. Эдгээр шинэ малчид нэгдлийн малчдын хүүхдүүд байсан хэдий ч социализмын үед хотод амьдарч мал малладаггүй байсан, харин төрийн өмчийн газрууд ажилгүй болж, ардчилал эхлэхэд эдийн засаг ерөнхийдөө хямралд орсон учир бизнесүүд хаалгаа барьж байсны улмаас сум нутагтаа буцаж ирж малчин болохоор шийдсэн хүмүүс байсан. Харин 1956 онд Олон-Овоо багт үндэсний төмөр замыг хангахаар барьсан улсын хэмжээний ганц төрийн мэдлийн чулуун завод хэвийн ажиллаж үлдсэн бөгөөд манай 2016 оны ажлын үеэр 60 жилийнх нь ой тохиож байлаа.

Социализмын үед Даланжаргалан суманд цөөн хэдэн жоншны уурхай байсан, уул уурхайн үйл ажиллагаа 1990 ээд оны дунд үе 1996 оноос нутгийн хүмүүс өрхийн амьжиргаандаа хувь нэмэр болох үүднээс гар аргаар хууль бүс жонш ухаж ирснээс хойш л жинхэнэ утгаараа эхэлсэн. Эхлээд цөөн хэдэн бичил уурхайчид жонш ухаж хятад худалдаачдад худалдаалдаг байсан. Удалгүй Даланжаргалан суманд ирж орлого олж болох сургаар Монгол орны өнцөг булан бүрээс ажилгүй хүмүүс ирж энэ тоо хэдэн мянгад хүрсэн юм. 1997 оны үед жижиг болон дунд компаниуд ажиллаж эхэлсэн ба 1998 онд Монголын томоохон уул уурхайн компани Монгол Алт Корпораци (МАК) суманд ирж нүүрсний уурхай ажиллуулж эхэлсэн.

Дараах 1-р зураглалд санамсаргүй түүврийн бүх өрхийн тэргүүний 55% (41) нь Даланжаргалан суманд төрсөн, зөвхөн 41% (30) нь насан хүрснээсээ хойш суманд нүүж ирсэн байна.

Манай судалгааны нийт 36 өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн тэргүүлэгчдийн 69% нь суманд төрсөн байхад нийт 57 эрэгтэй тэргүүнтэй өрхийн 59% ийн тэргүүн нь энэ суманд төрсөн байна. Даланжаргалан суманд насанд хүрээд ирсэн хүмүүс нь гэр бүлээ дагаад, гэрлээд, төмөр замд ажиллахаар, армид ороод, сумын аль нэг үйлдвэрт ажиллахаар тус тус ирсэн байна. Насанд хүрээд Даланжаргалан суманд нүүж ирсэн хүмүүсийн ихэнх нь төвийн хоёр багынх байлаа: Олон-Овоо багын санамсаргүй түүврийн өрхийн 58% (19 ын 11), Цомог багын 72% (18 ын 13). Эсрэгээрээ энэ тоо Бичигт багын хувьд 18% (11 ын 2), Өнгөт багын хувьд 27% (15 ын 4) байлаа. Элдэв багынх харин 100% сумандаа төрсөн байлаа.

Зураглал 1. Даланжаргалан суманд шилжин ирэгсдийн тухайн үеийн насны байдал



Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Түүврийн хэмжээ N = 74.


Амьжиргаа ба жендерийн харилцаа

Гэрлэлт, гэр бүлийн нөхцөл байдал

Санамсаргүй түүврийн нийт 74 өрхийн тэргүүний 61% (45) хууль ёсоор гэрлэсэн, 8% (6) зөвхөн албан бусаар юмуу уламжлалт байдлаар гэрлэсний зөвхөн нэг нь өрх толгойлсон эмэгтэйтэй өрх байв. Санамсаргүй түүврийн дөрвөн өрх толгойлсон эмэгтэйтэй, өрхийн тэргүүн нь хууль ёсны дагуу гэрлэсэн гэж тэмдэглэгдсэн байх юм.

Энэ нь нийт 36 өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн 11% нь хууль ёсоор гэрлэсэн эмэгтэй өрхийн тэргүүнтэй гэсэн үг. Харин нийт 57 эрэгтэй тэргүүнтэй өрхийн 72% хууль ёсоор гэрлэсэн эрэгтэйчүүд байна. 2-р зураглалд харуулав.

Зураглал 2. Даланжаргалан сум, Эмэгтэй (зүүн), эрэгтэй (баруун) тэргүүнтэй өрхийн гэрлэлтийн байдал



Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Эмэгтэйчүүдийн зураглалд зориудаар нэмж судалгаа авсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүд, санамсаргүй түүврийн өрхүүдийн мэдээлэл, аль аль нь багтав. “Эмэгтэй” зураглалын түүврийн хэмжээ N = 36. “Эрэгтэй” зураглалын түүврийн хэмжээ N = 57.

Санамсаргүй түүврийн өрхийн тэргүүний 14% (10) ганц бие, гэрлэж байгаагүй, үлдсэн 8 санамсаргүй түүврийн өрх салсан эсхүл тусдаа амьдарч байгаа тэргүүнтэй байсан, эсхүл тэд хамтран амьдарч байгаа хүнтэй ч гэрлээгүй, бүүр уламжлалт байдлаар ч гэрлээгүй гэж бүртгэгдсэн. Энэ сүүлийн ангилалд орсон өрхүүд Олон-Овоод амьдардаг байсан. Энэ багын санамсаргүй түүврийн өрхийн 21% (19 архийн 4 нь) байна. Үүний гурван өрх нь эрэгтэй өрхийн тэргүүнтэй, нэг нь эмэгтэй өрхийн тэргүүнтэй байсан. Зориудаар нэмж судалгаа авсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн хоёр нь хамтран амьдрагчтай гэхдээ гэрлээгүй гэж байсны нэг нь Элдэв, нөгөө нь Олон-Овоо багынх байв.

Мөн түүнчлэн Даланжаргалан суман дахь салалтын түвшин бага байсан, уламжлалт хэв маягаас шалтгаалан дахин гэрлэх явдал тийм ч таатай бус учир хосууд гэрлэсэн хэвээр үлддэг ба харин салсан, тусдаа амьдарч байгаа хүмүүс нь шинээр хүнтэй суулгүй хамтран амьдардаг байна. Санамсаргүй түүврийн өрхийн 4% (3) нь салсан өрхийн тэргүүнтэй байсны хоёр нь өрх толгойлсон эмэгтэй, мөн нэг өрх толгойлсон эмэгтэй өрхийн тэргүүн тусдаа амьдардаг, мөн зориудаар судалгаа авсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн хоёр нь салсан гэж бүртгэгдсэн байна.

Санамсаргүй түүврийн өрхийн 7% нь бэлэвсэн эмэгтэй (3) өрхийн тэргүүнтэй байсан буюу бэлэвсэн эрэгтэй (2) өрхийн тэргүүнтэй байсан. Манай суурь судалгааны 36 өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн гэр бүлийн байдлын нийтлэг шинж нь бэлэвсэрсэн гэсэн байв (36%). Нийт 36 өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн 26% нь ганц бие, гэрлэж байгаагүй өрхийн тэргүүлэгчтэй үлдэгдэл 36% нь албан ёсоор салсан юмуу тусдаа амьдарч байгаа, эсхүл хамтран амьдрагчтай юмуу уламжлалт ёсоор гэрлэсэн гэж хэлсэн, эсхүл “хуурамчаар” салсан хууль ёсоор гэрлэсэн хосууд байна. Ийм эхнэр нөхөр хоёр хоёр өөр суманд бүртгэлтэй байдаг практикийн тухай доор үзнэ. Даланжаргалан суманд “хуурамч” салалт тийм ч гайхах зүйл биш учир бидний судалгаанд нэрлэгдэх тэргүүн нь эрэгтэй өрхийн тоонд ийм өрхүүд ч багтаж байхыг үгүйсгэхгүй.

Бидний суурь судалгааны санамсаргүй түүврийн өрхийн арван есөн хувь (14) нь гэртээ ядаж ганц хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэсэн байна. Тэргүүн нь эрэгтэй өрхийн 18%, өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн 22% хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй байна. Санамсаргүй түүврийн өрхүүдээс нэг нь өнчин байсан ба тэргүүн нь эрэгтэй өрх байв.

Бидний судалгааны үеэр санамсаргүй түүврийн өрхийн 27% (74 өрхийн 20 нь) тэдэнтэй хамт амьдарч байгаа өрхийн гишүүн бус дор хаяж нэг хүнтэй байсан нь ихэвчлэн зуны амралтаараа өвөө, эмээгийн дээ ирж амарч байгаа хүүхдүүд байв. Нөгөө талаар, санамсаргүй түүврийн өрхүүдийн нийт 267 гишүүд 76% (203 хүн) үндсэн гэртээ тогтмол амьдардаг гэж мэдэгдсэн байна. Дөчин долоон хүн (18%) жилд түр зүүр өөр газар амьдардаг, 11 хүн (4%) дунд болон урт хугацаагаар өөр газар амьдардаг гэсэн. Эдгээр нь өрхийнхөө үндсэн гэрт тогтмол амьдардаггүй

39 өрхийн (санамсаргүй түүврийн өрхийн 53%) 58 хүн болж байгаа юм. Ийм хүмүүсийн ихэнх нь өрхийн тэргүүний хүүхдүүд бөгөөд ихэнхдээ сурах, цөөн хэд нь ажиллах, цэрэгт явах, уурхайд ажиллах зэргээр гэрээсээ хол амьдрах болсон байна. Мөн нэг өрхийн тэргүүн их сургуульд сурч байгаа тулд жилд есөн сар хол байдаг, хоёр өрхийн тэргүүний гэргий “хуурамч” салалттай бөгөөд өрхийн гишүүдтэйгээ тогтмол амьдардаггүй гэж бүртгэгдсэн байна.

Бичигт багын өрхүүдэд хамгийн бага хугацаагаар үндсэн гэртээ амьдардаг хүмүүс бүртгэгдсэн бөгөөд энэ багын санамсаргүй түүврийн өрхийн нийт гишүүдийн 65% үндсэн гэртээ байнга амьдардаг байхад Элдэв багын санамсаргүй түүврийн өрхийн нийт гишүүдийн 84% нь үндсэн гэртээ байнга амьдардаг байна.


Энэ нь бидний 2016 оны ажлын үеэр ажигласан Элдэв багын ихэнх өрх айлууд бэлчээрээ зэргэлдээх сумын малчдаас хамгаалахын тулд өвөлжөөндөө жилийн турш амьдардаг, нүүвэл ойрхон явдаг (5 км-ээс ихгүй) –г баталж байна гэж үзэж байна. Энэ тухай бид дараа нь дэлгэрүүлэн үзнэ.

Үүнээс гадна, малын улирлын нүүдлийн талаас нь авч үзвэл санамсаргүй түүврийн өрхийн 267 бүх гишүүдийн зөвхөн зургаа нь (2%) буюу Бичигт багаас бусад бүх багын өрхийн хүмүүс түр хугацаагаар (зөвхөн нэг улиралд) өөр газар амьдардаг гэсэн байна. Нэг нь өрхийн тэргүүн байсан гэхдээ шалтгаан нь бүртгэгдээгүй байна, харин бусад нь хүүхдүүд болон хамаатан садангийн хүмүүс малтайгаа отороор явдаг гэж бүртгэгдсэн бөгөөд энэ тухай бид дараа нь ярилцана. Бид суурь судалгааг зуны улиралд хийсэн учир оторт бүгдээрээ явсан өрх айлуудыг судалгаанд хамруулж чадаагүй. Гэхдээ санамсаргүй түүврийн өрхийн зөвхөн тийм шалтгаантай хоёр өрхийг бид судалгаанд хамруулж чадаагүй нь бидний бодсоноос бага тоо байсан. Гэсэн хэдий ч Даланжаргалан суманд үндсэн гэртэй өрхүүдийн улирлын нүүдлийн хэмжээ илүү өндөр байх магадлалтай. Учир нь Бичигт, Өнгөт багын аль алинд нь хайгаад олдохгүй санамсаргүй түүвэрт багтсан өрхийн тоо их байсан. Бидэнд өвлийн ЗБУ-д суманд төрсөн гэхдээ зуны суурь судалгааны үед оторт яваагүй эмэгтэйчүүдийг олоход хэцүү байсан. Нөгөө талаар өвөл ЗБУ, ХХЯ-д оролцсон хүмүүс, мөн зуны суурь судалгааны үеэр оторт явсан байсан хүмүүс Даланжаргалан сумын хэмжээнд өнөө үед уламжлалт нүүдлийн мал аж ахуйн хэв шинжийг хадгалсан улирлын отор нүүдлээр явж малаа бэлчээрлүүлж байгаа өрхийн тоо их хумигдсан хэмээн тайлбарласан. Учир шалтгааныг нь бид дараагийн сэдэвт нь үзнэ.

Боловсрол

3-р зураглалд харуулснаар бүх санамсаргүй түүврийн өрхийн зөвхөн 10% (7) нь боловсролын зэрэг нь дунд сургуулиас ахиагүй, цааш өсөөгүй ядаж нэг насанд хүрсэн эмэгтэй өрхийн гишүүнтэй байгаагүй. Харин санамсаргүй түүврийн өрхийн 41% (30) д нь ахлах сургууль төгсөөд боловсролын зэргээ ахиулсан (тусгай мэргэжлийн сургууль юмуу их сургууль) ядаж нэг насанд хүрсэн эмэгтэй гишүүнтэй байсан. Үүний эсрэгээр, санамсаргүй түүврийн бүх өрхийн 18% (13) нь боловсролын зэргээ дунд сургуулиас цааш ахиулаагүй ядаж нэг насанд хүрсэн эрэгтэй өрхийн гишүүнтэй байгаагүй байхад санамсаргүй түүврийн өрхийн 34% (25) нь ахлах сургууль төгсөөд боловсролын зэргээ ахиулсан ядаж нэг насанд хүрсэн эрэгтэй гишүүнтэй байсан.

Зураглал 3. Даланжаргалан сум, Өрхүүдийн насанд хүрсэн эмэгтэйчүүдийн (зүүн) болон эрэгтэйчүүдийн (баруун) хамгийн өндөр боловсролын зэрэг



Эх үүсвэр: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. N = 74. Аль нь ч биш= өрхөд нэрлэсэн хүйсийн насан хүрсэн хүн байхгүй.

3-р зураглалд үзүүлснээр санамсаргүй түүврийн бүх өрхийн насанд хүрсэн эмэгтэйчүүдийн түгээмэл хариулсан хамгийн өндөр боловсролын гурван зэрэг нь “их сургууль төгссөн” (22%), “ахлах сургууль төгссөн” (20%), “тусгай мэргэжлийн сургууль төгссөн” (16%) тус тус байна. Насанд хүрсэн эрэгтэйчүүдийн түгээмэл хариулсан хамгийн өндөр боловсролын гурван зэрэг нь “дунд сургууль төгссөн” (24%), “тусгай мэргэжлийн сургууль төгссөн” (23%), “ахлах сургууль төгссөн” (19%) тус тус байсан. Нийтэд нь авч үзвэл санамсаргүй түүврийн өрхийн 38% нь “тусгай мэргэжлийн сургууль төгссөн” эсхүл их сургууль төгссөн ядаж нэг насанд хүрсэн эмэгтэй гишүүнтэй байсан байна. Харин зөвхөн 28% нь дээрхтэй ижил боловсролын зэрэгт хүрсэн ядаж нэг насанд хүрсэн эрэгтэй гишүүнтэй байна.

Нийтдээ, санамсаргүй түүврийн бүх өрхийн хамгийн өндөр боловсролын зэрэгтэй хүмүүс Олон-Овоо, Цомог, Өнгөт багуудад байна. Өнгөт багт санамсаргүй түүврийн 53% (15 хүний 8) -д өрхийн ядаж нэг гишүүн нь ахлах сургууль төгссөн насанд хүрсэн эрэгтэйтэй, 87% (13) -д нь ядаж нэг насанд хүрсэн эмэгтэй гишүүнтэй тус тус байна. Олон-Овоо багын хувьд санамсаргүй түүврийн өрхийн 63% (19 өөс 12) –д нь эрэгтэй насанд хүрсэн гишүүн, 84% (16) эмэгтэй насанд хүрсэн гишүүд дээрхтэй адил боловсролын зэрэгт хүрсэн байна. Сумын төвийн Цомог багт санамсаргүй түүврийн өрхийн 83% (18 аас 15) ядаж нэг ахлах сургууль төгссөн насанд хүрсэн эмэгтэй, эрэгтэй гишүүний аль алинтай нь байна. Харин Элдэв багын хувьд санамсаргүй түүврийн өрхийн зөвхөн 27% -д (11 өрхийн 3 нь) ахлах сургууль төгссөн ядаж нэг эрэгтэйтэй байна. Мөн Элдэв, Өнгөт, Бичигт багуудад их сургууль төгссөн эрэгтэйтэй өрх байхгүй байна. Бичигт багт мөн их сургууль төгссөн эмэгтэй байхгүй байна. Бидний дараа нь үзэх Өнгөт, Бичигт, Элдэв баг нь Даланжаргалан сумын малчдын багууд гэдгийг харгалзаж үзвэл хөдөөний эрэгтэй малчдын дунд боловсролын түвшин бага байгаа гэсэн үндэсний мэдээллийг дэмжин, бататгаж байгаа юм. Энэхүү чиг хандлагын урт хугацааны нийгэмд үзүүлэх нөлөөллийг манай ЗБУ, ХХЯ-ын зарим залуу эрэгтэй малчид хөндөж ярихдаа боловсрол эзэмшихээр том хотыг зорьж байгаа олон залуу эмэгтэй байгаа учир хөдөө амьдарч байгаа залуучуудад эхнэр олно гэдэг хэцүү болж байгааг хэлсэн юм.

Хөрөнгө чинээ, ядуурал


Орон сууц

Даланжаргалан сумын санамсаргүй түүврийн өрхийн дөчин есөн хувь (36) гэртэй, 39% (29) байшинтай, 11% (8) аль алинтай нь байсан. Нэг өрх орон гэргүй бусдын гэрт амьдарч байсан. Гэртэй айлуудын гэрийн дундаж тоо 1.3. Өнгөт багын нэг өрх гурван гэртэй байсан. Дөрөв

болон таван ханатай гэр түгээмэл үндсэн амьдардаг гэр нь байна. Үндсэн гэртэй өрхийн 48% нь дөрвөн ханатай (44 өрхийн 21), 48% (21) нь таван ханатай гэртэй байна.


4, 5-р зураглалд өрхийн орон сууцны хэлбэр, материалыг (хамгийн их ханатайг нь тэмдэглэсэн, өрх тус бүрийн үндсэн орон сууцны дээврийн материалыг судалсан) харуулав.

Зураглал 4. Даланжаргалан сум, Эрэгтэй, эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрхийн ханын материалын төрөл, хувиар



Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Үүнд зориудаар судалгаа авсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, санамсаргүй түүврийн өрх аль аль нь багтсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүврийн хэмжээ N = 36. Тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ N = 57.

Зураглал 5. Даланжаргалан сум, Эрэгтэй, эмэгтэй тэргүүнтэй өрхийн дээврийн материал, хувиар



Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Үүнд зориудаар судалгаа авсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, санамсаргүй түүврийн өрх аль аль нь багтсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүврийн хэмжээ N = 36. Тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ N = 57.

Дээрх хоёр зураглалаас харахад “мод, эсгий” гэсэн орон сууцны материал эрэгтэй, эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрхийн аль алинд нь хамгийн түгээмэл байна. Дараа нь “мод”он материал түгээмэл байна. Сонирхолтой нь өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүдийн үндсэн гэрийн дээвэр, ханын материал нь тэргүүн нь эрэгтэй өрхүүдээс бага зэргийн илүүтэйгээр шатаасан тоосго, хар цаасан дээвэртэй байгаа нь тэд илүү байшинтай байна гэсэн дүгнэлт хийхэд хүргэж байна. Энэ нь өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүд малчин өрх байх нь бага гэсэнтэй уялдаж байгаа бөгөөд энэ тухай бид доор үзнэ. Суурин хоёр багт хөдөөний багуудаас харьцангуй их өрх толгойлсон эмэгтэйтэй өрх амьдарч байгаа бололтой.


Манай суурь судалгааны санамсаргүй түүврийн өрхийн 55% (40) нь гэр, байшингийн хамгийн өндөр өртөгтэй ханын материал “мод, эсгий” гэж мэдээлсэн. Олон-Овоо, Цомог багаас бусад бүх багт “Мод, эсгий” нь хана, дээврийн аль альных нь хувьд хамгийн өндөр өртөгтэй сууцны

материал байсан. Харин энэ хоёр багт мод хамгийн өндөр өртөгтэй түгээмэл хэрэглэгдсэн ханын материал байв. Зарим өрх шатаасан тоосго, цемент, шавар, шавар тоосго, plaster болон чулуун ханатай байшинтай байсан. Үүний адилаар Олон-Овоо, Цомог багт гэр нь хар цаасан дээвэртэй өрхүүд тааралдсан ба ихэнх өрхийн үндсэн сууц төмөр, модон дээвэртэй байв. Эсрэгээрээ Бичигт багын санамсаргүй түүврийн өрхүүд 100% гэрт амьдардаг. Мөн бидний ажиглалтаар Олон-Овоо багын төвд сумын төвийн Цомог багтай харьцуулахад илүү олон байшинтай, бас илүү өртөгтэй барилгын материалтай байв. Гэхдээ Олон-Овоо багын бүх өрх багын төв дээр амьдардаггүй хөдөө амьдардаг байна. Энэ нь Олон-Овоо багын байшинд амьдардаг хүмүүс сумын төв дээр амьдарч байгаа хүмүүсээс бага зэргийн илүү хөрөнгөтэй гэж дүгнэж болохоор байна. Байшин барих (орон гэртэй хүмүүсийн), түрээслэхэд (түрээсэлж суухад) илүү өндөр үнэтэй гэж үзвэл Сумын төвд гэртэй айл илүү олон байсан.

Өмч хөрөнгө

Даланжаргалан сумын судалгаа авсан өрхийн ихэнх нь гар утас, телевизортой байсан. Мөн хөргөгч, угаалгын машин түгээмэл хэрэглээ байсан. Мөнгөн аяганаас бусад тохиолдолд эрэгтэй, эмэгтэй тэргүүнтэй өрхийн эзэмшиж буй өмч хөрөнгийн хооронд ялгаа бага байсан. Харин эрэгтэй тэргүүнтэй өрхүүд өрх толгойлсон эмэгтэй өрхүүдийг бодвол илүү их мөнгөн аягатай байсныг 6-р зураглалд харуулав. Малчин хүмүүс илүү их мөнгөн аяга хэрэглэдэг учир энэ ялгаа нь эрэгтэй тэргүүнтэй малчин өрхтэй харьцуулбал өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн мал маллах явдал бага мөн/эсхүл тэд харьцангуй ядуу малчин өрх байдгыг харуулж байна.

Зураглал 6. Даланжаргалан сум, Эрэгтэй, эмэгтэй тэргүүнтэй өрхийн өмч хөрөнгө, хувиар



Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Үүнд зориудаар судалгаа авсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, санамсаргүй түүврийн өрх аль аль нь багтсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүврийн хэмжээ N = 36. Тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ N = 57.

Цахилгаан, ус, ариун цэврийн байгууламж

Манай суурь судалгааны санамсаргүй түүврийн өрхийн ерэн хоёр хувь (68) нь цахилгаанд холбогдсон байсан ба эрэгтэй, эмэгтэй тэргүүнтэй өрхүүдийн хооронд ялгаа бага байсан. Эдгээр цахилгаантай өрхүүдийн 45 нь төвийн цахилгаанд холбогдсон, 23 нь зөөврийн нарны тольтой байсан. Зөөврийн нарны тольтой бүх өрх Бичигт, Элдэв, Өнгөт багуудад байсан ба Бичигт багын 82% нь нарны тольтой байсан. Мөн энэ гурван багын санамсаргүй түүврийн өрхүүдийн төвийн цахилгаанд холбогдсон байдал нь хамгийн доогуур байсан. Өнгөт багын өрхүүдийн 33%, Бичигт, Элдэв багт тус бүр зөвхөн хоёр өрх төвийн цахилгаантай холбогдсон байв. Харин эсрэгээрээ, Цомог болон Олон-Овоо багт санамсаргүй түүврийн өрхийн 100%, 95% нь тус тус төвийн цахилгаантай холбогдсон байна.

Дараагийн сэдэвт үзэх гүний усны бохирдол, түвшин доошилж байгаа зэрэг усны хомсдол нь уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой гэж Даланжаргалангийн хүмүүс сэтгэл зовж байгаа нь 2016 оны бидний ажлын үеэр ажиглагдсан. Зарим малчид үүнээс болж хувийн худаг барьж эхэлжээ. 3-р хүснэгтэд суурь судалгааны санамсаргүй түүврийн өрхийн бүх улирлын усны эх үүсвэрийн төрлийг хувиар харуулсан. Үүнд хамгийн түгээмэл усны эх үүсвэр нь хувийн өмчлөлийн гүний худгаас мөнгөөр авдаг хэлбэр байна. Зарим өрх янз бүрийн усны эх үүсвэрээс усаа авч байна.

Хүснэгт 3. Даланжаргалан сум, Санамсаргүй түүврийн өрхийн янз бүрийн улиралд ашиглаж буй усны эх үүсвэр, тоо, хувиар

Усны эх үүсвэр	Гүний худга	Гүхэн худга
Хувийн	4 (5%)	6 (8%)
Ойролцоох - Нийтийн/хувийн	16 (22%)	5-6 (7-8%)
Ойролцоох – Төлбөр төлж авдаг	32-33 (43-45%)	1 (1%)

Эх үүсвэр: ЭГЭЭББ суурь судалгаа, 2016. Түүврийн хэмжээ N = 74.

Даланжаргалан суманд төвийн усан хангамж байхгүй, ихэнх өрх ойролцоох гүний худагаас (мөнгө төлж авдаг) усаа авдаг нь эрэгтэй, эмэгтэй тэргүүнтэй өрхийн хувьд ялгаагүй адил байна. Өвөл, хавар, зуны улиралд нийт өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн 56% (20), нийт тэргүүн нь эрэгтэй өрхийн 40-42% (23-24) ийм гүний худгаас усаа авдаг. Булаг, шандны усыг зөвхөн тэргүүн нь эрэгтэй өрхүүд буюу нийт тэргүүн нь эрэгтэй өрхийн 14-18% (8-10) нь улирлаас шалтгаалан ашигладаг. Харин өрх толгойлсон эмэгтэйтэй нэг ч өрх ашигладаггүй байна. Булаг шанд ашигладаг ихэнх өрх урьд нь сувилал байсан, ногооны талбайтай Өнгөт багт байдаг. Эдгээр өрхийн эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн аль аль нь булгаас ус авдаг ч эрэгтэй хүмүүс малаа усладаг учир илүү хэрэглэдэг. Бусад усны эх үүсвэрүүдийг ховор ашигладаг: нэг тэргүүн нь эрэгтэй өрх, нэг өрх толгойлсон эмэгтэйтэй өрх булгын голоос зундаа ус авдаг, нэг тэргүүн нь эрэгтэй өрх усны зөөврийн усан сангаас хавар, зундаа ус авдаг хэмээжээ.


Ариун цэврийн байгууламжийн хувьд санамсаргүй түүврийн өрхийн 36% гадаанаа татуургагүй (гүнзгий нүхтэй) жорлонтой байхад 15% нь жорлонгүй байв. Ариун цэврийн байгууламжийн төрлийн хэрэглээний хувьд эрэгтэй, эмэгтэй тэргүүнтэй өрхүүдийн хооронд бараг ялгаа байгаагүй.

Тээврийн хэрэгсэл

Даланжаргалан сумын мотортой хамгийн түгээмэл хэрэгсэл нь мотоцикл бөгөөд санамсаргүй түүврийн өрхийн 43% хэрэглэж байна. Санамсаргүй түүврийн өрхийн 22% (16) нь энгийн (2 дугуй нь мааждаг) машинтай, 22% (16) ачааны тэрэгтэй, 32% (24) нь гар тэрэгтэй, 34% (25) морь уналгад ашигладаг.

Ачааны машин, трактор, мосттой машин, энгийн машин, мотоцикл, дугуй, гар тэрэг, морь болон чиргүүл гээд бүх төрлийн тээврийн хэрэгслийг эрэгтэй тэргүүнтэй өрх илүү эзэмшдэг. Энэ тухай 7-р зураглалаас харж болно. Жишээ нь тэргүүн нь эрэгтэй бүх өрхийн 46% (26) нь мотоциклтой байхад өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн зөвхөн 31% (11) мотоциклтой байна. Үүний адилаартэргүүн нь эрэгтэй бүх өрхийн 25% (14) нь энгийн машинтай байхад өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн 8% (3) нь ийм байна. 7-р зураглалд үзүүлснээр малчин иргэдэд тээврийн хэрэгсэл чухал хэрэгцээ болдог гэдгийг харгалзаж үзвэл морьтой тэргүүн нь эрэгтэй өрхийн тоо их (түүх, соёлын талаас харахад малчин өрхийн хамгийн их хэрэглэдэг уналга) байгаа нь харагдаж байна. Эрэгтэй, эмэгтэй тэргүүнтэй өрхийн тээврийн хэрэгслийн хэрэглээний ялгаанаас харахад өрх толгойлсон эмэгтэйтэй өрх харьцангуй ядуу мөн өрх толгойлсон эмэгтэй малчдад харьцангуй бэрхшээлтэй тулгардаг гэдэг нь харагдаж байна.

Зураглал 7. Даланжаргалан сум, Эрэгтэй, эмэгтэй тэргүүнтэй өрхийн тээврийн хэрэгслийн төрөл, хувиар



Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Үүнд зориудаар судалгаа авсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, санамсаргүй түүврийн өрх аль аль нь багтсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүврийн хэмжээ N = 36. Эрэгтэй тэргүүнтэй өрхийн түүврийн хэмжээ N = 57.

Ерөнхийдөө бидний ЭГЭЭББ суурь судалгааны орон сууцны хэлбэр, материал, эзэмшиж буй хөрөнгө, цахилгаанд холбогдсон байдал, ус, ариун цэврийн байгууламж, тээврийн хэрэгслийн хэрэглээ зэргээс харахад Даланжаргалан суманд өрх толгойлсон эмэгтэйчүүд харьцангуй ядуувтар гэдгийг, эмзэг бүлгийн хүмүүсийг, ялангуяа өрх толгойлсон эмэгтэйтэй малчин өрхийн эмзэг байдлыг харуулж байна. Энэ нь оролцооны судалгааны үеэр илрүүлсэн зүйлстэй тохирч байгаа бөгөөд эмэгтэйчүүдэд тулгардаг бэрхшээлийн тухай бид дараагийн сэдэвт үзнэ.

Үндсэн амьжиргаа

Суурь судалгаанаас Даланжаргалан суманд хоёр үндсэн амьжиргааны бүлэг байдаг - “малаа өөрсдөө малладаг малчид”, “албан ёсны ажил эрхэлдэг хүмүүс”. Энэ нь 74 санамсаргүй түүврийн өрхийн 43%(32), 45% (33) түс түс болж байна. Эрэгтэй тэргүүнтэй өрхийн 46% (57 өрхийн 22) нь “малаа өөрсдөө хариулдаг малчид”, 42% (24) нь “албан ёсны ажил эрхэлдэг хүмүүс”. Харин өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн 33% (36-ийн 12 нь) энэ хоёр төрлийн ажлын аль альныг хийдэг байна.

Нийтдээ санамсаргүй түүврийн өрхийн 26% (19) сүүлийн 12 сарын хугацаанд зөвхөн нэг төрлийн мөнгөн орлогын эх үүсвэртэй байсан, 31% (23) хоёр төрлийн, 23% (17) гурван төрлийн, 12% (9) дөрвөн төрлийн, 5% (4) дор хаяж таван төрлийн мөнгөн орлогын эх үүсвэртэй байсан ба 3% (2) мөнгөн орлогын ямар нэгэн эх үүсвэргүй байсан. 4-р хүснэгтэд үзүүлсэнчлэн, эрэгтэй, эмэгтэй тэргүүнтэй өрхүүдийн хооронд том ялгаа гараагүй. Гэхдээ өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүд цөөн мөнгөн орлогын эх үүсвэртэй, тэргүүн нь эрэгтэй өрхүүд мөнгөн орлогын эх үүсвэр олонтой байна. Тэргүүн нь эрэгтэй өрхүүдэд хөдөлмөрийн насны хоёр ба түүнээс дээш насанд хүрсэн хүмүүс байсан учир үүнд гайхах зүйл байхгүй.

Хүснэгт 4. Даланжаргалан сум, Бүх судалгаанд оролцсон өрхийн мөнгөн орлогын эх үүсвэрийн тоо

Мөнгөн орлогын эх үүсвэрийн тоо	Байхгүй	1	2	3	4	5 ба түүнээс	Нийт
Өрх толгойлсон эмэгтэйтэй өрх	2 (6%)	11 (31%)	13 (36%)	7 (19%)	3 (8%)	0	36 (100%)
Тэргүүн нь эрэгтэй өрх	2 (4%)	14 (25%)	18 (32%)	13 (23%)	6 (11%)	4 (7%)	57 (100%)

Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Үүнд зориудаар судалгаа авсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, санамсаргүй түүврийн өрх аль аль нь багтсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүврийн хэмжээ N = 36. Тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ N = 57.

Хувь хүмүүсийн нэг төрлийн мөнгөн орлогын эх үүсвэрүүдээс олсон мөнгөн орлогын хэмжээ янз бүр байсан ба нэг өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн ноос худалдсан 19,160 төгрөгний орлогоос авахуулаад хамгийн их орлого олсон нэг өрхийн мах худалдсан 20,000,000 төгрөгний орлого байх жишээтэй.

Мал маллах, албан ёсны ажил эрхлэх хоёрын аль аль нь чухалд тооцогддогтой уялдаад санамсаргүй түүврийн өрхүүдээс сүүлийн 12 сард мал маллах, албан ажил эрхлэлтээс хамгийн их орлого олжээ.

Даланжаргалан сумын санамсаргүй түүврийн өрхийн хорин зургаа хувь (19) -ийн сүүлийн 12 сард олсон хамгийн их мөнгөн орлогын эх үүсвэр нь мал аж ахуйгаас байсан ба 30% (22) –ийн хамгийн их мөнгөн орлогын эх үүсвэр төрийн ажил эрхлэлт байсан гэжээ. 5-р хүснэгтэд судалгаанд оролцсон бүх өрхийн хамгийн их мөнгөн орлогын эх үүсвэрийг жендерээр ангилан харуулсан.

Хүснэгт 5. Даланжаргалан сум, судалгаанд оролцсон бүх өрхийн хамгийн их мөнгөн орлогын эх үүсвэр

Хамгийн их мөнгөн орлогын эх үүсвэр	Өрх толгойлсон эмэгтэйтэй өрх	Тэргүүн нь эрэгтэй өрх
Төрийн ажил эрхлэлт	10 (28%)	17 (30%)
Мал маллах	9 (25%)	15 (26%)
Тэтгэвэр	6 (7%)	11 (19%)
Уул уурхай	3 (8%)	3 (5%)
Группын орлого	-	4 (7%)
Хүүхдийн тэтгэмж	2 (6%)	1 (2%)
Хувийн компанийн цалин	2 (6%)	-
Мөнгөн орлогогүй	-	2 (4%)
ТББ/Холбоо	1 (3%)	1 (2%)
Газар тариалан	1 (3%)	-
Эрүүл мэндийн сувиллын орлого	1 (3%)	-
Туслах тогооч	1 (3%)	-
Хувийн жижиг блокны үйлдвэр	-	1 (2%)
Уул уурхайн компанид цэвэрлэгч	-	1 (2%)
Нийт	36 (100%)	57 (100%)

Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Үүнд зориудаар судалгаа авсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, санамсаргүй түүврийн өрх аль аль нь багтсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүврийн хэмжээ N = 36. Тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ N = 57

5-р хүснэгтэд харуулсны дагуу тэргүүн нь эрэгтэй өрх, өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн аль альных нь сүүлийн 12 сарын турш олсон хамгийн их мөнгөн орлогын эх үүсвэр болох төрийн ажил, мал маллах хоёрын хооронд ялгаа бага байсан. Манай санамсаргүй түүврийн өрхийн 17 өрх толгойлсон эмэгтэйтэй өрхөөс 4 нь (24%) Олон-Овоогоос бусад бүх багаас тус бүр нэг нь мал маллах, Цомог баг (3) ба Олон-Овоо багын (2) 5 өрхийн (29%) төрийн ажил эрхлэлт хамгийн их мөнгөн орлогын эх үүсвэр байсан гэв.

Энэ мэдээлэл нь багаас хамаарч амьжиргаа ялгаатай байгааг харуулж байна. Жишээ нь, сумын төвийн Цомог багын санамсаргүй түүврийн өрхийн 72% (18 -ын 13 нь) төрийн ажил эрхлэлт, 6% (1) мал маллах нь хамгийн их мөнгөн орлогын эх үүсвэр байсан гэжээ. Олон-Овоо багын санамсаргүй түүврийн өрхийн сүүлийн 12 сарын турш 47% (19 өрхийн 9) төрийн ажил эрхлэлт, 16% (3) уул уурхай, 5% (1) мал маллахаас тус бүр хамгийн их мөнгөн орлого олсон гэжээ. Харин эсрэгээрээ, хөдөөний багуудын (Өнгөт, Элдэв, Бичигт) санамсаргүй түүврийн өрхийн 46% (37 өрхийн 17) сүүлийн 12 сарын турш мал маллахаас хамгийн их мөнгөн орлого олсон гэж мэдэгдсэн байна. Манай ЗБУ, ХХЯ-н үеэр Даланжаргалан сумын хөдөөгийн айл өрхүүдийн мөнгөн орлогын гол эх үүсвэр мал маллах юм гэдгийг бид олж мэдсэн.

Түүнчлэн санамсаргүй түүврийн өрхийн тэргүүн нь насанд хүрээд суманд шилжиж ирсэн 30 өрхийн 53% (16 өрх) сүүлийн 12 сард төрийн ажил эрхлэлтээс, зөвхөн 13% (3 өрх) мал маллахаас хамгийн их мөнгөн орлого олсон гэжээ. Харин үүний эсрэгээр, санамсаргүй түүврийн өрхийн тэргүүн нь энэ суманд төрсөн өрхөөс 34% (14 өрх) сүүлийн 12 сарын турш мал

маллах, зөвхөн 12 % (4 өрх) төрийн ажил эрхлэлтээс хамгийн их мөнгөн орлого олсон гэжээ. Энэ мэдээлэл нь Даланжаргалан сумын хүн амын уугуул хүмүүс нь илүү уламжлалт мал аж ахуй эрхэлдэг, шинээр ирсэн суугуул хүмүүс нь илүү албан ёсны төрийн ажил эрхэлдэг бөгөөд уугуул, суугуул хүмүүсийн хооронд нийгэм-эдийн засгийн хувьд ялгаа байгаа нь харагдаж байна.

Судалгаанд оролцсон бүх өрхүүдээс 5 нь сүүлийн 12 сарын турш хамгийн бага орлоготой байсан бөгөөд эдгээр нь бүгд өрх толгойлсон эмэгтэйтэй өрх байв. Тэдний орлого 150,000 аас 819, 160 төгрөгний хооронд байв. Эдгээрээс нэг өрх нь санамсаргүй түүврийн өрх, нөгөө дөрөв нь зориудаар нэмж судалгаа авсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрх байв. Бичигт багын албан ёсоор гэрлэсэн эмэгтэй өрхийн тэргүүнтэй нэг өрх хамгийн бага мөнгөн орлого буюу 150,000 төгрөгийг гар аргаар алт олборлож олсон байна. Энэ мөнгийг өрхийн эхнэр, нөхөр хоёр тус тусдаа олж нийлүүлсэн байна.

Үүний эсрэгээр, сүүлийн 12 сарын турш хамгийн их мөнгөн орлого олсон таван өрхийн дөрөв нь тэргүүн нь эрэгтэй өрх байсан ба орлого нь 15,760,000 - 27,850,000 төгрөгний хооронд байсан. Эдгээр өрхийн нэг өрх нь дор хаяж таван мөнгөн орлогын эх үүсвэртэй байсан. Энэ өрх Өнгөт багынх ба мах худалдаж 20,000,000 төгрөгний орлого олсон нь хамгийн их орлогын эх үүсвэр байсан. Энэ орлогыг эхнэр, нөхөр хоёул хамтран олжээ.

Түүнчлэн энэ өрх сүү, ноос, ноолуураас 7,850,000 төгрөгний мөнгөн орлого олсон байна. Сүүлийн 12 сарын турш хамгийн их мөнгөн орлого олсон 5 дахь өрх нь өрх толгойлсон эмэгтэйтэй өрх байсан ба 3 янзын эх үүсвэрээс 15,760,000 төгрөг олсон байна.


Бидний суурь судалгааны санамсаргүй түүврийн өрхийн зөвхөн дөрвөн өрх сүүлийн 12 сарын турш уул уурхайгаас ямар нэгэн орлого олсон гэж мэдээлсэн ба бүгдийнх нь хувьд энэ нь хамгийн их мөнгөн орлого нь байсан байна. Уул уурхайгаас олсон хамгийн их мөнгөн орлогыг тэргүүн нь эрэгтэй өрх олсон байсан ба эхнэр нөхөр хоёр хамтаараа 5,000,000 төгрөгний орлогыг жоншны уурхайгаас олсон байна. Нэг өрх толгойлсон эмэгтэй сүүлийн 12 сарын турш 500,000 төгрөгний орлогыг жоншны олборлолтоос олсон бөгөөд түүний хүү нь уул уурхайн компанид харуулын ажил хийж 4,050,000 төгрөгний мөнгөн орлого олсон байна. Бас нэгэн тэргүүн нь эрэгтэй өрх хагас үнэт чулуу олборлож 1,000,000 төгрөгний орлого олсон байна. Сүүлийн 12 сарын турш уул уурхайгаас ямар нэгэн мөнгөн орлого олсон хэмээн мэдээлсэн дөрөв дэх өрх судалгааны хамгийн бага мөнгөн орлого олсон өрх байсан бөгөөд Бичигт багт амьдардаг, хууль ёсоор гэрлэсэн эмэгтэй тэргүүнтэй өрх байв.

Даланжаргалан суманд хэд хэдэн уул уурхайн компани байдаг хэдий ч дээр дурьдсанчлан уул уурхайн үйл ажиллагаанаас орлого бага олж байгаа талаар харья. Бидний ЗБУ, ХХЯ-аас иргэдийн уул уурхайд оролцох оролцоо суурь судалгаа хийхэд гарч байснаас илүү ялангуяа хууль бус гар аргаар алт олборлох ажиллагаа их болох нь харагдав. Түүнчлэн суурь судалгааны бүх эмэгтэй хариулагчдын 21 % (54 өөс 19 нь), бүх эрэгтэй хариулагчдын 35% (39 өөс 8 нь) “энэ нутгийн ихэнх хүмүүсийн амьжиргаа уул уурхайгаас хамаардаг” гэсэн мэдэгдэлтэй санал нийлсэн. 2016 оны бидний ажлын үеэр уул уурхайн салбар ерөнхийдөө уналтад байсан ба ЗБУ, ХХЯ-д оролцсон хүмүүс тухайн үедээ биш ч гэсэн урьд нь гар аргаар алт олборлож, холбоотой ажиллаж байсан тухай хэлсэн. Суурь судалгааны үеэр уул уурхайгаас бага хэмжээний мөнгөн орлого олдог гэж бүртгэгдсэн байдлыг суманд ажиллаж байгаа уул уурхайн компаниудад ажил эрхлэх боломж муу байдагтай холбоотой гэсэн өргөн хүрээний асуудлыг авч үзэх ёстой юм. Энэ тухай доор үзнэ. Мөн үүнийг зарим хүмүүс уул уурхайн хууль бус үйл ажиллагаа эрхэлдэгтэй холбож авч үзэх хэрэгтэй.

8-р зураглалд үзүүлснээр Даланжаргалан суманд хийсэн суурь судалгаагаар ямар хэлбэрээр уул уурхайтай холбоотой ажиллаж байгааг харахад ихэнх өрх том хэмжээний уул уурхай буюу албан ажилтай байна. Гэхдээ мөн эрэгтэй эмэгтэй тэргүүнтэй өрхийн аль аль нь жижиг хэмжээний улирлын чанартай албан бус уул уурхайн ажил хийдэг байна. Энд хууль бус гар

аргаар алт олборлох эрэгтэй тэргүүнтэй өрх арай давамгай байна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль аль нь олборлох ажилд оролцдог болохыг доор үзнэ.

Зураглал 8. Даланжаргалан сум, Судалгааны бүх өрхийн хамрагдсан үүл үүрхайн үйл ажиллагааны төрөл



Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Үүнд зориудаар судалгаа авсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, санамсаргүй түүврийн өрхийн аль аль нь багтсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүврийн хэмжээ $N = 36$. Тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ $N = 57$

Даланжаргалан сумын уул уурхайн үйл ажиллагаа байгаль орчин, нийгмийн ноцтой асуудлуудыг дагуулж байгаа ч өрхийн орлогыг бүрдүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байгаа тухай бид дэлгэрэнгүй үзнэ. Түүнчлэн албан ажил, түүнээс ч илүүтэйгээр мал малласнаас хамгийн их мөнгөн орлого олж байгаа гэж мэдэгдсэн нь уул уурхайн эдийн засаг муудсан ч өөр хийх ажилтай байгааг харуулж байна.

Мал аж ахуй

6-р хүснэгтэд санамсаргүй түүврээс сүүлийн 12 сарын турш мал аж ахуйгаас хамгийн их мөнгөн орлого олсон гэж мэдэгдсэн 29 өрхийн мөнгөн орлогын 5 эх үүсвэрийн төрлийг харуулсан. Олон өрх мал аж ахуйгаас олон төрлийн мөнгөн орлого олсон гэж мэдээлсэн. Санамсаргүй түүврийн өрхийн 39% мал аж ахуйгаас орлого олсноос 93% (27) ноолуур, 69% (20) нь мах, 45% (13) ноос худалдаалснаас тус тус мөнгөн орлого олсон байна.


Хүснэгт 6. Даланжаргалан сум, Санамсаргүй түүврийн өрхийн мал аж ахуйн мөнгөн орлого

Мөнгөн орлогын эх үүсвэр	Өрхийн тоо	Мал малласнаас ямар нэгэн мөнгөн орлого олсон өрхийн эзлэх хувь
Мал аж ахуй- ноолуур	27	93%
Мал аж ахуй – мах	20	69%
Мал аж ахуй – ноос	13	45%
Мал аж ахуй- сүү	2	7%
Мал аж ахуй – мэдэгдэхгүй	2	7%

Эх үүсвэр: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Түүврийн хэмжээ N= 29.

Өөр олон өрх малтай байсан хэдий ч сүүлийн нэг жил ямар нэгэн мөнгөн орлого олоогүй зөвхөн өрхийн хэрэгцээндээ зарцуулсан байна. Сумын төвд амьдардаг малаа хамаатан садан эсхүл өөр хүмүүсээр маллуулдаг мал бүхий иргэд өөрсдийгөө малчид гэж үздэггүй ахмад хүмүүсийн хувьд өрхийн хэрэгцээндээ зориулж малтай байх явдал нь илүү чухал зүйл мэт харагдаж байв. Даланжаргалан сумын санамсаргүй түүврийн өрхийн 55% (41) суурь судалгааны үед өрхийн хэрэгцээний мал, амьтантай байсан. Харин 41% (30) нь ноос, ноолуур, 30% (22) нь мах, 19% (14) нь арьс, шир, 7% (5) нь сүү, цагаан идээ тус тус борлуулж орлого олдог хэмээн тайлбарласан байна. Энэ тухай мэдээллийг 9-р зураглалд хүйсээр ангилан харуулсан.

Зураглал 9. Даланжаргалан сум, Судалгааны өрхүүдийн мал, бусад амьтны хэрэглээ



Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Үүнд зориудаар судалгаа авсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, санамсаргүй түүврийн өрхийн аль аль нь багтсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүврийн хэмжээ N = 36. Тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ N = 57

9-р зураглалд тэргүүн нь эрэгтэй өрхийн хувьд өрх толгойлсон эмэгтэйтэй өрхтэй харьцуулахад сүү, цагаан идээ борлуулдаг гэснээс бусад бүх ангилалд мал аж ахуйгаас илүү хамааралтай, харин өрх толгойлсон эмэгтэйтэй өрх малгүй байх нь элбэг байгааг цохон тэмдэглэх нь зүйтэй. Сүү, цагаан идээний борлуулалт бага байгааг хөргөгч, агуулах зэрэг хүчин зүйлээс шалтгаалан говийн халуунд сүү худалдах боломж бага байдагтай холбож үзэж болох юм. Мөн Говийн хүмүүсийн ихэнх нь хонь, ямаатай байдаг тул сүүний гарц бага харин илүү өтгөн, шимтэй байдаг байна. Нутгийн хүмүүс сүүгээр олон төрлийн бүтээгдэхүүн хийлгүйгээр зөвхөн тараг (curd) хийх нь түгээмэл байна.

Даланжаргалан сумын иргэд хонь маллах нь хамгийн түгээмэл, санамсаргүй түүврийн өрхийн 47% (35) хоньтой байсан ба тэдний 54% (19) нь 50 аас илүү толгой хоньтой байсан. Мөн ямаа, үхэр тэжээх нь нийтлэг байсан ба санамсаргүй түүврийн өрхийн 45%, 43% (33, 32 өрх) тус тус байв. Судалгааны өрхүүдээс Өнгөт багын нэгэн өрх хамгийн олон малтай байсан ба өрхийн тэргүүн нь эрэгтэй, нийт 1000-2000 малтай байв. 7-р хүснэгтэд үзүүлсний дагуу байршлаас шалтгаалан мал маллах байдал янз бүр байгаа нь ажиглагдсан. Олон-Овоо, Цомог багт малтай өрхийн тоо хамаагүй бага, үүнтэй холбоотойгоор сумын төвийн маш цөөхөн өрх хашаандаа малтай болох нь ажиглагдсан.

Хүснэгт 7. Даланжаргалан сум, Санамсаргүй түүврийн малтай өрхийн тоо, хувь.

Баг	Үхэр		Хонь		Ямаа		Адуу		Тэмээ	
	Өрхийн тоо	Багт эзлэх %	Өрхийн тоо	Багт эзлэх %	Өрхийн тоо	Багт эзлэх %	Өрхийн тоо	Багт эзлэх %	Өрхийн тоо	Багт эзлэх %
Бичигт	5	45%	10	91%	9	82%	7	64%	-	-
Элдэв	8	73%	9	82%	9	82%	6	55%	2	18%
Олон-Овоо	5	26%	3	16%	3	16%	4	21%	-	-
Цомог	3	17%	4	22%	3	17%	2	11%	-	-
Өнгөт	11	73%	9	60%	9	60%	8	53%	4	27%

Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Бичигт багын түүврийн хэмжээ N = 11. Элдэв N = 11. Олон-Овоо N = 19. Цомог N = 18. Өнгөт N = 15.

Манай суурь судалгааны өрхийн зөвхөн хоёр эрэгтэй тэргүүнтэй өрх (нэг нь Даланжаргалан суманд төрсөн, нөгөө нь насанд хүрээд суманд нүүж ирсэн) том хэмжээний малчин өрх байсан ба хөлс өгч бусдаар малаа маллуулдаг байна. Мөн өөр нэг хоёр өрх, нэг нь өрх толгойлсон эмэгтэйтэй өрх (зориудаар нэмж судалгаанд хамруулсан) нөгөө нь эрэгтэй тэргүүнтэй өрх, аль

аль нь энэ суманд төрсөн, Өнгөт багынх бөгөөд өрхийн гишүүдийн зарим нь ямар нэгэн мөнгөн хөлс авалгүйгээр бусад өрхийн малыг хариулах, мал аж ахуйтай холбоотой ажил хийдэг хэмээн мэдээлсэн байна. Ер нь бидний судалгаанд хөлсөөр мал хариулдаг гишүүнтэй өрх байгаагүй. Ингэж 2016 оны суурь судалгаанд хамрагдсан малчин өрхүүдийн байдлаас харахад мал аж ахуй нь гэр бүл дотор явагддаг өрхийн үйл ажиллагаа гэдгийг нотолж байгаа юм. Бид мөнгөн төлбөр авалгүйгээр мал маллахад тусалдаг өрхийн бус гишүүнтэй хэдэн өрх байна вэ гэж нарийн асуугаагүй (жишээ нь, мөнгөн бус солилцоо эсхүл өөр ажил хийж өгөх, эсхүл хамаатан садан юмуу найз нөхрийн хоорондын тохиролцоо гэх мэт), гэхдээ санамсаргүй түүврийн өрхийн 16% (12) нь бод мал хариулахад өрхийн гишүүн бус хүн ямар нэгэн байдлаар оролцдог хэмээн мэдэгдсэн байна.

Мөн бид суурь судалгаагаар эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн мал аж ахуйн хөдөлмөрийн хуваарийн талаар тодорхой мэдээлэл цуглуулсан. Санамсаргүй түүврийн бүх өрхийн эмэгтэйчүүдийн 32% (24) сүү саах ажилд оролцдог бол эрэгтэй хүмүүсийн зөвхөн 5% (4) нь оролцдог байна. Үүний адилаар сүүн бүтээгдэхүүн бэлтгэх, боловсруулах ажлыг ихэвчлэн эмэгтэй хүмүүс хийдэг байна (санамсаргүй түүврийн өрхийн эмэгтэйчүүдийн 30% (22), эрэгтэйчүүдийн 4% (3)). Эрэгтэй хүмүүс голдуу бод мал хариулах ажилд оролцдог ба энэ тоо санамсаргүй түүврийн өрхийн 32% (24) байв. Эмэгтэйчүүдийн хувьд 14% (10) байв. Урьд дурьдсанчлан эрэгтэйчүүд голдуу малаа худаг, шанднаас услах ажлыг хийдэг байна. Хүүхдүүд, ялангуяа эрэгтэй хүүхдүүд сургуулийн бус үеэр мал хариулахад тусалдаг. Мал муулах ажлыг эрэгтэйчүүд хийх хандлагатай, 32% (24 өрх) байсан. Эмэгтэй хүмүүс мал муулж болохгүй гэсэн уламжлалт нийгмийн ёс зүйгээс шалтгаалан мал муулдаг гэсэн эмэгтэй хүн бүртгэгдээгүй. Мах худалдаалдаг эсхүл өрхийн хэрэгцээндээ хэрэглэдэг эмэгтэйчүүд хөршийнхөө эрэгтэй хүнийг гуйж мал гаргуулах эсхүл малаа амьдаар нь борлуулдаг хэмээн мэдэгдсэн. Махны гол зах зээл нь нутагтаа байсан ба сумын төвийн бусад иргэдэд, уул уурхайн компанийн байранд амьдардаг ажилчдад худалдаалдаг байна. Элдэв багын эрэгтэй малчид уул уурхайн компаниудад махаа шууд худалдаалдаг ба эхнэрүүд нь сумын төвд сууж сумын төвийн дэлгүүр, зээл дээр мах худалдаалдах боломжтой байдаг байна. Үнэндээ урьдын цагт мал маллаж байх байсан хоёр төвийн багт амьдарч байгаа эмэгтэйчүүд зах зээлд ойрхон учир мал худалдааны ажилд илүү оролцдог болохыг бид ажигласан.


Газар тариалан

Бидний 2016 оны ажлаас харахад газар тариалан Даланжаргалан сумын амьжиргаанд ач холбогдол багатай байна. Санамсаргүй түүврийн 84% (62 өрх) нь ямар нэгэн ургамал тариалаагүй, 14% (10 өрх) өрхийн хэрэгцээндээ зориулж тарьсан, нэг өрх гэрээ чимэх зорилгоор зөвхөн цэцэг тарьсан байсан. Эдгээр 11 өрхийн 8 нь газар тариалангийн талбайд, үлдсэн гурав нь хашааныхаа газар дээр тарьсан байсан.

Газар тариалангийн газартай 8 өрхийн нийт тариалалт хийсэн талбай 3.75 га, тариалсан талбайн дундаж 0.23 га байв. Эдгээр өрхийн 7 нь Өнгөт багт амьдардаг ба багын төв Далантүрүүний рашааны ойролцоо, Дархан сумаас урсацтай Жонш (Sprag) гол дагуу жижиг хүлэмж, ногооны талбайтай ба рашааны энэ газарт жимс, ногоо тарих хамгийн тохиромжтой гэж хэлцдэг. Найм дахь нь Бичигт багт маш баг хэмжээгээр буюу 0.0011 га-д төмс тариалж буй өрх юм. Газар тариалангийн талбайтай Өнгөт багын долоон өрх долүүл сонгино, төмс тарьсан, зургаа нь манжин, дөрөв нь лууван, хүрэн манжин тарьсан байна. Өөр ганц хоёр өрх байцаа, улаан лооль, чинжүү, өргөст хэмх, хулуу, саладны ногоо, цагаан гаа, халуун чинжүү, наранцэцэг, чацаргана, тэжээлийн ургамал, мод, эрдэнэ шиш тарьсан байна. Газар тариалангийн талбайгүй Цомог багын гурван өрх сонгино, наранцэцэг, мод, цэцэг хашаандаа тарьсан байна.

10-р зураглалд харуулснаар, ерөнхийдөө эрэгтэй тэргүүнтэй өрхтэй харьцуулахад өрх толгойлсон эмэгтэйтэй өрх бага зэргээр илүү газар тариалан эрхэлж байгаа бөгөөд энэ зургаас газар тариалангийн ургацын бүх ашиглалтын хэлбэрийг харж болно.

Зураглал 10. Даланжаргалан сум, судалгаанд хамрагдсан бүх өрхийн газар тариалангийн бүтээгдэхүүний ашиглалт



Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Үүнд зориудаар судалгаа авсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, санамсаргүй түүврийн өрхийн аль аль нь багтсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүврийн хэмжээ N = 36. Тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ N = 57.

Нэг өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, нэг эрэгтэй тэргүүнтэй өрх буюу санамсаргүй түүврийн зөвхөн хоёр өрх сүүлийн 12 сарын хугацаанд хүнсний ногоогоо өрхийн хэрэгцээндээ ашиглаад зогсохгүй худалдаалж мөнгөн орлого олсон бөгөөд энэ нь нэг өрхийнх нь мөнгөн орлогын анхдагч эх үүсвэр байсан гэжээ. Эрэгтэй тэргүүнтэй гурван өрх өрхийн хэрэглээндээ ногоо тариалахаас гадна малын тэжээлийн ургамал тарьсан байсан.

Мал аж ахуйн бүтээгдэхүүнтэй адилаар хүнсний ногооны гол зах зээл нь уул уурхайд ажилладаг ажилчид байв. Гэхдээ Говьд уламжлалт хоол хүнсний хэрэглээ өөрчлөгдөж эхэлж байгаа бөгөөд нутгийн хүмүүс ногоо илүү их хэрэглэх болсон. Ус бага шаардагддаг эсхүл үр ашигтай үсалгааны систем ашиглаж нутгийн хөрсөнд ургуулсан ногоо чанартай хөрснөөсөө шалтгаалаад онцгой амттай байдаг учир нутгийн иргэд ам сайтай худалдан авдаг. Иймд Даланжаргалан сумын захиргааны ажилтнууд сумын хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих сонирхолтой байгаагаа илэрхийлсэн юм. Ингэх нь өрхийн мөнгөн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж уул уурхай зогсонги эсхүл ган зуд болох, бэлчээрийн талхагдал нэмэгдэж буй үед хүмүүсийн эдийн засгийн тэнцвэрийг хангахад хэрэгтэй хэмээсэн. Бидний ЗБУ, ХХЯ-д оролцсон хүмүүс 2009 онд нэгэн ТББ төслийн хүрээнд Даланжаргалан сумын төвд 1.5 га хүнсний ногооны талбай байгуулж 23 ядуу өрхийг ногоо тарих, боловсруулах сургалтад сургасан ба үүнээс 9 өрх 1 га талбай дээр үргэлжлүүлэн тариалалт хийж байгаа тухай бидний 2016 оны ажлын үеэр мэдээлсэн.

Бидний суурь судалгаанаас харахад Даланжаргалан сумын зарим тариаланчид бусад өрхийн гишүүдээс хөлстэй, хөлсгүйгээр туслах хүн авч ажиллуулдаг нь харагдсан. Суурь судалгааны өрхөөс зөвхөн хоёр нь (3%) нь “мөнгөн хөлс авалгүйгээр өөр өрхийн эсхүл аж ахуйн нэгжийн газар тариалангийн ажилд оролцдог” өрхийн гишүүнтэй хэмээн мэдэгдсэн ба нэг нь эрэгтэй тэргүүнтэй, нөгөө нь өрх толгойлсон эмэгтэйтэй өрх байв. Энэ хоёр өрхийн тэргүүний аль аль нь энэ суманд төрсөн байв. Суурь судалгааны санамсаргүй түүврийн өрхийн 5 (7%) нь “мөнгөн хөлсөөр өөр өрхийн эсхүл аж ахуйн нэгжийн газар тариалангийн ажил хийдэг” өрхийн гишүүнтэй байсны 3 нь эрэгтэй тэргүүнтэй, 2 нь өрх толгойлсон эмэгтэйтэй өрх байв. Түүнчлэн зориудаар судалгаанд хамруулсан өрх толгойлсон эмэгтэйтэй нэг өрх мөн тийм гэж мэдэгдсэн. Эдгээр 6 өрхийн 5 –ынх нь өрхийн тэргүүн энэ суманд төрсөн байна. Мал аж ахуйн хөдөлмөрийн хуваарийн тухай дээр өгүүлсэнтэй хамтатган дүгнэж үзвээс Даланжаргалан сумын уугуул иргэдийн хувьд ямар нэгэн төрлийн харилцан үйлчлэх эдийн засгийн зохицуулалт байдаг буюу газар тариалан эрхлэх, мал маллахад нутгийн өрх айлууд нэгэндээ дэмжлэг

үзүүлж тавиул мал харах, эсхүл мөнгөн хөлс авах юмүү мөнгөн бүс төлөөс авах зэргээр ажилладаг байна гэж дүгнэж болно.

Жендерийн харилцаа

Даланжаргалан сумын ЗБУ, ХХЯ-д оролцогчид малчин өрхийн хөдөлмөрийн хуваарь байгалийн зохицол ёсоор эрэгтэйчүүд нь мал маллах, услах, хашаа хороо засаж янзлах, түлээний мод бэлтгэх, мал хуй муулах зэрэг хүнд хүчир, гэрийн гадаах ажил үүргийг гүйцэтгэдэг байхад эмэгтэйчүүд гэрийн доторх ажил буюу хоол хийх, гэр орон цэвэрлэх, аяга таваг угаах, сүү саах, сүүн бүтээгдэхүүн хийх зэрэг ажлыг гүйцэтгэдэг байна. Суурь судалгаагаар өрхийн гишүүдийн хөдөлмөрийн хуваарийн талаар тодорхой мэдээлэл цуглуулсан бөгөөд санамсаргүй түүврийн өрхийн 81% (60) -д эмэгтэйчүүд, 39% (29) –д эрэгтэйчүүд хоол хийдэг байна. Мөн үүнтэй ижил 80% (59)-д эмэгтэйчүүд, 42% (31) –д эрэгтэйчүүд хувцас хунар угаах ажлыг хийдэг байна. Гэхдээ улирлын ажил үүргийн хуваарийн дасгалыг эрэгтэй, эмэгтэй хүмүүстэй тусад нь хийж үзэхэд эрэгтэй хүмүүсийн хийдэг олон ажлыг эмэгтэйчүүд хамтдаа хийдэг бололтой харагдсан. Жишээ нь мал хариулах, услахад эмэгтэйчүүд оролцдог. Мөн сумын төв дээр эхнэр нь хүүхдүүдтэйгээ хичээлийн жилд амьдардаг гэр бүлийн нөхрүүд өвлийн удиралд хоолоо өөрсдөө хийх гэх мэтээр гэр орны ажил илүү хийдэг болох нь харагдсан.

Улирлын ажлын ачааллын дасгалын үеэр хүүхдийн тус дэм, ажлын үүрэг тод илрэн гарч ирсэн. Манай ЗБУ-ын оролцогчид хүүхдүүд эцэг эхдээ тусалдаг, ялангуяа мал хариулах, гэр цэвэрлэх, дүү нараа харах зэрэгт их тусалдаг хэмээжээ. Түүнчлэн жил бүрийн хавар Боловсролын яамны зохицуулалттайгаар сургуулийн хүүхдийн улирлын амралтыг мал төллөх үеэр тохируулан 14-21 хоног олгож хүүхдүүдийг эцэг эхдээ туслах боломж гаргадаг байна.

Бидний эрэгтэйчүүдтэй хийсэн нэгэн ЗБУ-н оролцогчид Даланжаргалан сумын эмэгтэйчүүд бодол санаагаа ичиж зоволгүй илэрхийлдэг тухай мэдээлсэн. Мөн өөр хэд хэдэн ЗБУ, ХХЯ-н оролцогчид сумын удирдлагын зохиодог олон нийтийг хамарсан уулзалт, зөвлөгөөнд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү идэвхтэй оролцож санал бодлоо чөлөөтэй илэрхийлж чаддаг, тэд багын хуралд тогтмол оролцдог тухай ярьсан юм.

Даланжаргалан сумын уламжлалт малчин өрхийн хувьд ч эмэгтэйчүүд өрхийнхөө санхүү мөнгийг зохицуулдаг харин үндсэн хөрөнгө, мал хуй худалдах зэрэг асуудалд эрэгтэй хүмүүс хол амьдарч байсан ч илүү оролцдог байна. Нөгөө талаар эмэгтэйчүүд газрын гэрчилгээ авах бичиг баримт хөөцөлдөх ажлыг түлхүү хийдгийг тэд хичээлийн жилд сумын төвд амьдардагтай нь холбож үзэж болох юм. Нийтэд нь дүгнэж үзэхэд эмэгтэйчүүд өрх гэрийнхээ шийдвэр гаргах үйл явцад идэвхтэй оролцдог ч өрх хоорондын асуудлууд буюу газар, усны нөөц олж авах (нийтийн бэлчээрийн газрын менежмент) зэрэг асуудлыг эрчүүд хоорондоо хэлэлцдэг тухай бид үзэх болно. Энэхүү уламжлалт ажил үүргийн хуваарь нь эмэгтэй хүнийг эр хүний дэмжлэггүйгээр мал маллахад маш хэцүү болгодог байна.

Даланжаргалан сумын айл өрх хуваагдаж амьдардаг асуудал нь жендерийн харилцааг ойлгох гол түлхүүр юм. Энэ байдал нь өрхийн бүтэц, бүрэлдэхүүн, гэр бүлийн харилцаанд нөлөөлж байгаа бололтой ч жинхэнэ үр дагавар нь хараахан тодорхой мэдэгдээгүй байна. Бидний ЗБУ, ХХЯ-н оролцогчид үүний шалтгааныг малчин өрхүүдийн өвөлжөө энд тэнд сумын төвийн сургуулиас хол тасархай байдагтай холбож үзсэн. Социализмын үед сумын сургууль боломжийн хичээллэх байр талбайтай, хоол сайтай, хүүхдүүдийг харж ханддаг дотуур байртай байсан бол одоо үгүй. Нутгийн хүмүүсийн яриагаар хүүхдээ сумын төвд хамаатан садан, танил талтай байлгаснаас эцэг эхийнхээ нэгтэй байвал илүү сайн сурдаг гэж үздэг байна. Уламжлалт малчин өрхүүд хүүхдүүддээ өөрсдөөсөө илүү боловсрол олгохыг чухалчлан үзэж байгаа үед малчин өрх болгоны эхнэр нөхөр хоёр хичээлийн жилд тус тусдаа хуваагдаж амьдардаг, ээж нь хүүхдээ хараад сумын төвд, аав нь малаа хараад хөдөө, ээж нь удаан үргэлжлэх өвлийн хүйтэн улирлын үеэр заримдаа амралтын өдрүүдээр хөдөө гэртээ ирдэг байна. Сумын захиргаанаас энэхүү хуваагдаж амьдардаг байдлыг зохицуулахын тулд ийм өрхийг сумын төвд хашааны

газар авахыг зөвшөөрсөн байна. Ихэнх өрх хоол хүнсээ хөдөөнөөс татдаг, гэхдээ зарим эмэгтэйчүүд албан ажил эсхүл жижиг бизнес эрхлэх зэргээр сумын төв дээр орлого олох ажил хийдэг. Энэ байдал нь эрэгтэйчүүдийг өвлийн улиралд гэр орныхоо ажлыг өөрсдөө хийдэг болгоод зогсохгүй эмэгтэйчүүд эдийн засгийн хувьд эрх чөлөөтэй болох боломж олгож байна. Жишээ нь, дээр өгүүлсэнчлэн одоо эмэгтэйчүүд хэдийгээр нөхөртэйгээ зөвлөлдөж байгаа ч урьд нь эрэгтэй хүмүүсийн хяналтан доор явагддаг байсан мал хуй зарж борлуулах ажлыг гардан хийх төлөвтэй байна.

Бидний ЗБУ, ХХЯ-ны зарим оролцогч ингэж хуваагдаж амьдарч байгаа нөхцөл байдал нь эмэгтэйчүүдэд шинэ боломж олгож, үүний үрээр эмэгтэйчүүд харьцангуй эрх мэдэлтэй болж байгаа гэж үзэж байна.

Гэсэн хэдий ч ЗБУ, ХХЯ-н оролцогчид эмэгтэйчүүд хүүхдүүдтэйгээ өсвөр насанд хүрсэн үед нь ч хамт байх болсон тул энэхүү практикаас болж салалт нэмэгдэх хандлагатай байгаа тухай дурьдсан. Ингэснээр өрх айл 10 гаруй жилийн түрш хуваагдан амьдрах шаардлагатай болж байгаа бөгөөд ийм нөхцөл байдал нь ирээдүйд ямар үр дагавар авчрах нь тодорхой болоогүй байна. Жишээ нь, бидний зөвхөн эрэгтэй малчидтай хийсэн ЗБУ-н оролцогчид эмэгтэйчүүд хүүхдүүдтэйгээ сумын төвд байдаг учир эрэгтэйчүүдийн ажлын ачаалал өвлийн улиралд эмэгтэйчүүдийнхээс даруй 40% аар их, харин зундаа эмэгтэйчүүд хөдөө гэртээ ирдэг учир ажлын ачаалал нь эрэгтэйчүүдийнхээс 30% аар их болдог гэсэн байна. Түүнчлэн өрх хуваагдан амьдарч, эмэгтэйчүүдийн бие даасан байдал нэмэгдсэнээр хүйсээс шалтгаалсан хүчирхийлэл нэмэгдэхэд нөлөөлөх бас нэгэн сөрөг үр дагавар гарах магадлалтай. 2016 оны ажлын үеэр энэ тухай онцгойлон хөндөж ярилцаагүй юм.

Мөн Даланжаргалан суманд бэлчээр хомсдолтой учир “хуурамч” салалт ихсэх хандлагатай байгаа гэсэн тайлбар хийж байсан юм. Олон малтай гэрлэсэн хосүүд салж нөгөө нь өөр (ихэнхдээ зэргэлдээх) суманд албан ёсоор бүртгүүлж өвөлжөө олж авдаг гэж бидэнд хэлсэн юм. Энэхүү “хуурамч” салалт ялангуяа зэргэлдээх Бор-Өндөр сумын ойролцоо амьдардаг өрх айлуудын хувьд жирийн үзэгдэл болж буй бололтой. Монгол улсын хуулийн дагуу өвөлжөө, хаваржааны газрын эрхийг нэг өрхөд эхнэр эсхүл нөхрийн нэр дээр олгож болох ч нэг өрхөд нэгээс дээш газар олгохгүй. Иймд “хуурамч” салалт үйлдэж хоёр өвөлжөөний газар (ойролцоох бэлчээрийг хамтад нь) авч, малаа чөлөөтэй бэлчээж, гэрээ нүүлгэх боломжтой болдог байна. Энэхүү практик нь эмэгтэйчүүдэд өөрсдийн нэр дээр өвөлжөө авах давуу тал бий болгож болох ч малчин өрхийн энэ “хуурамч” салалт яваандаа жинхэнэ салалтад хүргэх эрсдэлтэй. Тэд хоёр өвөлжөө, бэлчээрийн газрынхаа эрхийг хамгаалахын тулд тусдаа амьдрах шаардлагатай болж байгаа тухай доор өгүүлье.

Ерөнхийдөө, салалт ихсэх нь өвөлжөөний газар ихэнхдээ эрэгтэй хүний нэр дээр байдаг учир эмэгтэйчүүд өвөлжөөний эрхгүй болбол сумын төвд эрэгтэй хүний дэмжлэггүйгээр амьдарч амьдралаа залгуулах хэрэгтэй болж байна гэсэн үг юм. Сумын төвийн амьдрал хөдөөнийхөөс илүү зардалтай учир амьдрахад хэцүү гэж бидэнд тайлбарласан бөгөөд энэ нь эрэгтэй хүний дэмжлэггүй өрх толгойлсон эмэгтэйчүүдэд илүү асуудал үүсгэж байгаа талаар бид доор сөхье.

Уул уурхайн компаниуд, бичил уурхай

Даланжаргалан суманд том, дунд, жижиг хэмжээний нүүрс, жоншны уурхайн үйлдвэрлэл, төмөр, барилгын материалын олборлолт, хууль бус бичил жонш, хагас үнэт чулууны олборлолт, цементийн үйлдвэр, жонш боловсруулах үйлдвэр зэрэг байдаг. Сүүлийн хорин жилд суманд уул уурхай хурдацтай хөгжиж байгаа бөгөөд сумын нутаг дэвсгэрийн 70% -г 100 гаруй олборлолтын лиценз эзэлж, Цомог багаас бусад бүх багт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа нийт 48 уурхайн компаниуд байдаг ба өөр олон компани хайгуулын лицензтэй гэсэн мэдээг бидэнд анх хэлсэн. Гэсэн хэдий ч сумын байгаль орчны байцаагчийн өгсөн Ашигт малтмалын газрын албан ёсны мэдээгээр Даланжаргалан суманд нийт 90 уул уурхайн лиценз байгаагаас 42 олборлолт, 48 хайгуулынх юм. 8-р хүснэгтэд энэ мэдээллээс дүн шинжилгээ

хийснийг харуулсан бөгөөд нийт 75,597 га буюу сумын нийт нутаг дэвсгэрийн 19%-г уул уурхайн лиценз эзэлж байна.

Хүснэгт 8. Даланжаргалан сум, Уул уурхайн лицензийн хамгийн их болон бага талбайтай (га) хувь аж ахуй нэгжийн эзэмшилд буй лиценз

	Хамгийн бага талбай	Хамгийн их талбай	Нийт талбайн хэмжээ
Хайгуул	39.75	9,299.79	64,256.85
Олборлолт	19.07	1,430.55	11,339.76
Бүх лиценз			75,596.61

Эх үүсвэр: Даланжаргалан сумын захиргааны албан ёсны мэдээлэл, 2016 оны 4-р сарын 6.

Даланжаргалан суманд байгаа нэг аж ахуй нэгжийн эзэмшилд байгаа хамгийн том талбай 9,300 га бөгөөд Блю Скай Хорс нэртэй гадаадын хамтарсан компанийн хайгуулын лиценз байна. Хамгийн том олборлолтын лицензийг Монгол Алт -МАК эзэмшдэг бөгөөд 1,431 га талбайтай байна. Энэ компани мөн хамгийн бага талбайтай олборлолтын лицензийг эзэмшдэг ба энэ нь 19 га байна. Мөн энэ компани өөр хоёр олборлолтын лицензтэй. Бас МАК Цемент олборлолтын өөр гурван лиценз эзэмшдэг. Нийтдээ Ашигт малтмалын газарт бүртгэлтэй 70 тусдаа аж ахуйн нэгжийн эзэмшилд 90 уурхайн лиценз байна.

Олборлолтын бүх лиценз 30 жилийн хугацаатай дуусах хугацаа нь 2025 аас 2044 оны хооронд байна. Монгол Алт компанийн Элдэв багт байдаг нүүрсний уурхайнуудын нэг нь суманд олгосон хамгийн анхны лицензийг эзэмшдэг байна. Хамгийн анхны хайгуулын лицензийг 2002 онд олгосон ба бүх хайгуулын лицензүүд 2017 онд дуусах нөхцөлтэй байна.

Доорхи 9-р хүснэгтэд үзүүлсэнчлэн сумын хэмжээнд олборлолтын лицензийн тоогоор тооцвол жонж (13 лиценз) хамгийн түгээмэл олборлож буй ашигт малтмал бөгөөд чулуу, хайрга, элс гэх мэт барилгын материал (12 лиценз), нүүрс (11 лиценз) маш ойрхон удаалж байгаа юм. Гэхдээ ашигт малтмал олборлож буй талбайн хэмжээгээр тооцвол нүүрс хамгийн ихээр олборлож буй ашигт малтмалын тоонд орж байгаа бөгөөд нийт 4,721 га талбайд ашиглалт явагддаг байхад 4,121 га-д барилгын материалын олборлолт явагддаг байна. Төмрийн ашиглалт явагдаж байгаа талбайн хэмжээ 1,284 га бөгөөд жоншны олборлолтын талбай 1,214 га юм.

Хүснэгт 9. Даланжаргалан сум, Уул уурхайн олборлолтын лицензтэй ашигт малтмалуудын талбайн мэдээлэл

	Нүүрм	Барилгын материал	Жонш	Нүүрс
Лицензийн тоо	11	12	13	6
Хамгийн бага талбай	19.07	22.62	24.93	55.91
Хамгийн том талбай	1,430.55	1,240.71	354.67	907.49
Нийт талбай	4,721.15	4,120.98	1,214.09	1,283.54

Эх үүсвэр: Даланжаргалан сумын захиргааны албан ёсны мэдээлэл, 2016 оны 4-р сарын 6.

Ашигт малтмалын газрын мэдээгээр төмрийн лицензээс бусад бүх ашиглалтын лицензийн ихэнх нь дотоодын (Монголын) аж ахуйн нэгжийн мэдэлд байдаг байна. Үүнийг 10-р хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 10. Даланжаргалан сум, Уул уурхайн ашиглалтын лицензтэй ашигт малтмалуудын хөрөнгө оруулалтын хэлбэр

	100% Гадаадын хөрөнгө оруулалт			Гадаадын хамтарсан аж ахуйн нэгж			Үндэсний аж ахуйн нэгж		
	Барилгын материал	Жонш	Төмөр	Нүүрс	Барилгын материал	Жонш	Нүүрс	Барилгын материал	Жонш
Лицензийн тоо	1	3	6	2	1	1	9	10	9
Хамгийн багатай талбай	1240.71	28.22	55.91	28.17	22.62	29.84	19.07	87.57	24.93
Хамгийн том талбай	1240.71	354.67	907.49	238.73	22.62	29.84	1430.55	611.91	254.36
Нийт талбай	1240.71	421.08	1283.54	266.9	22.62	29.84	4454.25	2857.65	763.17

Эх үүсвэр: Даланжаргалан сумын захиргааны албан ёсны мэдээлэл, 2016 оны 4-р сарын 6.

10-р хүснэгтэд харуулсан мэдээллийн дагуу бидний 2016 оны ажлын үеэр 10 тусдаа лицензийн нийт 2,945 га буюу ашиглалтын 11,340 га талбайн 26% нь 100% гадаадын хөрөнгө оруулалттай, 291 га буюу нийт ашиглалтын 3% нь гадаадын хамтарсан компанийн дөрвөн тусдаа лицензтэй байсан. Энэ нь бидний ажлын үеэр сумын газрын ихэнх хэсгийг гадаадууд (гадны хүмүүс) авч байгаа гэсэн түгээмэл ойлголттой зөрүүтэй байна. Даланжаргалан сумын голлох хөрөнгө оруулагч нь Монголын үндэсний аж ахуйн нэгжүүд, 8,075 га буюу нийт ашиглалтын лицензийн 71% , 28 тусдаа лиценз эзэмшиж байна. Хайгуулын лицензийн хувьд ч байдал төстэй байгаа бөгөөд нийт хайгуулын лицензийн 81% -г дотоодын аж ахуйн нэгжийн (48 ын 39) мэдэлд, зургаа нь 100% гадаадын аж ахуйн нэгж, гурав нь гадаадын хамтарсан аж ахуйн нэгжийн мэдэлд байна.

Манай ЗБУ, ХХЯ-ын ажлын үеэр Даланжаргалан сумын нутгийн иргэд суманд явагдаж байгаа уул уурхайн үйл ажиллагааны тухай мэдлэг, мэдээлэл дутмаг байгаа нь тодорхой байсан, эргэлзээ таамаг ихтэй, ялангуяа жижиг уурхайн үйл ажиллагаа болон уул уурхайн хайгуулын талаар мэдлэг, мэдээлэл хомс байна. ЗБУ, ХХЯ-ын оролцогчдын мэдэж байгаа үйл ажиллагаа явагдаж буй хамгийн том гурван уул уурхайн компани нь 1993 онд байгуулагдсан 100% үндэсний компани болох Монгол Алт Корпораци (МАК), Ашигт Малтмалын газарт хамтарсан компанийн бүртгэлтэй Чингисийн Хар Алт компани, Ашигт Малтмалын газарт бүртгэлгүй Касман Жоншны уурхай байв.

МАК суманд хоёр янзын үйл ажиллагаа явуулдаг. Нөөц болон байгууламжийн хувьд сумын хамгийн том уурхай болох МАК-ын Элдэв багт байрладаг нүүрсний уурхай 20 жил ажилласны эцэст 2-3 жилийн хугацаанд хаалтын үедээ орохоор төлөвлөж байна. Энэ уурхайгаас олборлосон нүүрсийг Эрдэнэт Майнинг Корпораци, Хөтөл цемент, шохойн үйлдвэр, Дарханы цахилгаан станц, Дарханы төмөрлөгийн үйлдвэр, Улаанбаатар төмөр зам зэрэг томоохон компаниудад нийлүүлдэг. Мөн саяхан МАК Олон-Овоо суманд 192жилийн нөөцтэй, Говийн бүсийн түүхий эд материалыг ашиглан жилд 1 сая тонн үйлдвэрлэх хүчин чадалтай Хөх Цав цементийн үйлдвэр байгуулсан юм.

Элдэв багт үйл ажиллагаа явуулдаг Чингисийн Хар Алтын нүүрсний уурхай, Касманы Жоншны уурхайг Монгол улсын жоншны тэргүүлэх олборлогч МОНРОС ХХК эзэмшдэг хэмээн хүмүүс бидэнд хэлсэн. Касман уурхай 2006 онд үйл ажиллагаагаа эхэлж 3 жилийн өмнөөс зогссон гэсэн боловч нутгийн хүмүүс 2016 оны бидний ажлын үеэр одоог хүртэл ажиллаж байгаа гэж дуулгасан юм. Гэхдээ Даланжаргалан суман дээр энэ хоёр уурхайн тухай албан ёсны мэдээлэл байхгүй, тэдний албан ёсны вэбсайт дээр ч мөн адил байхгүй, МОНРОС ХХК нь Ашигт малтмалын газрын мэдээллийн санд бүртгэлгүй байсан юм.

Манай ЗБУ, ХХЯ-ын оролцогчид Даланжаргалан суманд Хятад хүмүүс ажиллуулдаг жижиг дунд хэмжээний жоншны уурхайн компаниуд үйл ажиллагаа явуулдаг хэмээн мэдэгдсэн боловч тэдний тухай мэдээлэл хомс байлаа. Мөн нутгийн тодорхой тооны өрх айл жижиг, дунд жоншны уурхай байгуулан бизнес хийж байгаа бөгөөд бичил уурхайчдыг хөлсөлж ажиллуулдаг хэдий ч зах зээл буурсан гэсэн шалтгаанаар 2016 оны бидний ажлын үеэр идэвхтэй ажиллаагүй байв. Эдгээр орон нутгийн бизнес ихэвчлэн хууль бусаар ажилладаг бөгөөд томоохон уурхайн компаниудтай ихээхэн зөрчилддөг гэсэн ба энэ тухай бид доор үзнэ. Дээр өгүүлсэнчлэн Даланжаргалан суманд уул уурхайтай холбоотой ажилладаг хүний тоог барагцаалан гаргахад маш хэцүү байсан ч бидний ЗБУ, ХХЯ-ын оролцогчид бараг хүн бүр их бага хэмжээгээр бичил уурхайтай холбоотой эсхүл аль нэг газарт хүр бүр ажиллаж үзсэн гэсэн мэдээ өгч байсан.

Уул уурхайн компаниуд

Хөрөнгө оруулалтын үе шат

Манай суурь судалгаагаар иргэдийн уул уурхайн компаниудын тухай мэдлэг хомс байдаг гэснийг ЗБУ, ХХЯ-н үеэр ялангуяа газартай холбоотой мэдлэг байхгүй гэдгийг нотолсон. Нийт 54 эмэгтэй хариулагчийн 30% (16), нийт 39 эрэгтэй хариулагчийн 28% (11) нь “Танай нутагт компаниуд энгийн иргэдтэй зөвлөлдөхгүйгээр ирж хүмүүсийн газрыг авч чаддаг” гэсэн мэдэгдэлтэй санал нийлсэн байна. Мөн бүх эмэгтэй хариулагчийн 28% (15), бүх эрэгтэй хариулагчийн 26% (19) “Танай нутагт газрын менежментийн талаар шийдвэр гаргахдаа бүх хүмүүсийг оролцуулж, зөвлөлддөг” гэсэн мэдэгдэлтэй санал нийлсэн байна. Энэхүү зөрүүтэй ойлголтыг тайлбарлахад бэрхшээлтэй. Эхний мэдэгдлийн хариултын хувьд хүмүүс албан ёсны зөвлөлдөх үйл явц тодорхой хэмжээгээр байдаг ч сүүлийн мэдэгдлийн хариултаас харахад, хүмүүс тэдэнтэй зөвлөлдөж, шийдвэр гаргахад оролцуулдаггүй гэж үнэн хэрэгтээ үзэж байгаа гэж хэлж болно. Бидний ЗБУ, ХХЯ-аас харахад байдал мөн ийм бололтой. Уул уурхайн компаниуд ямар албан ёсны процессийн дагуу ажилладаг тухай нутгийн хүмүүсийн мэдлэг дутмаг байсан ч заримдаа сүм, багын хурал хуралдаж уул уурхай эрхлэх хүсэлтүүдийн талаар хэлэлцдэг тухай мэдээлэлтэй байсан юм.

2016 оны бидний ажлын үеэр уулзаж хэлэлцсэн хүмүүсийн тайлбарласнаар уул уурхайн компаниуд Ашигт Малтмалын газраас уурхай эрхлэх лиценз авах шаардлагатай. Ашигт малтмалын газраас тухайн компанид лиценз өгөхийг зөвшөөрсөн тохиолдолд сумын хурал руу захиа явуулж, нөлөөлөлд өртөх багын бүх иргэд (багын хурал) 30 өдрийн дотор хуралдаж уурхайн үйл ажиллагаа хаана явагдах тухай мэдээлж, хурлаар лиценз өгөх асуудлыг зөвшөөрөх эсэхэд хариу өгөх шаардлагатай байдаг. Хэрэв лицензийн ажиллагаанд өртөх багын бүх гишүүд тэдний нутагт явагдах уул уурхайн үйл ажиллагааг эсэргүүцвэл ялангуяа өрхийн тэргүүд (ихэвчлэн эрэгтэй хүмүүс) эсэргүүцвэл тухайн лиценз батлагдахгүй тул үйл ажиллагаа явуулж болохгүй гэж бидэнд мэдэгдсэн юм.

Гэхдээ ЗБУ, ХХЯ-ын ихэнх оролцогч суманд уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөх эсэх талаар шийдвэр гаргах ёстой ийм албан уулзалтууд ихэвчлэн болдоггүй учир хүмүүс уул уурхайн компаниуд зүгээр ирж нутгийн хүмүүстэй хэлэлцэлгүйгээр үйл ажиллагаа явуулж эхэлдэг гэсэн ойлголтод хүрдэг гэсэн байна. Түүнчлэн ЗБУ-ын оролцогчид, тэдний өөрсдийнх нь ойлгосноор уул уурхайн хайгуулын анхны лиценз зөвхөн 5 жилийн хугацаатай олгогдох ёстой бөгөөд энэ хугацаанд багын иргэдийн хурал компанийн үйл ажиллагаанд хяналт тавих, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэсэн эсэх, татвар төлсөн эсэхийг хянах онцгой үүрэгтэй байх ёстой гэсэн. Гэсэн хэдий ч ЗБУ-н оролцогчид практикт ийм явдал бараг байдаггүй бөгөөд уул уурхайн компаниудын үйл ажиллагаанд хяналт тавих ажил явагддаггүй гэсэн юм. Жишээ нь, уул уурхайн компаниуд бие даасан хараат бус байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэж сумын засаг даргад хоёр жил тутамд танилцуулах ёстой байдаг ч бидний 2016 оны ажлын үеэр ярилцсан ихэнх хүмүүс тийм тайлан хараагүй, тайлан бэлтгэдэг гэдгийг мэддэггүй, үргэлжлэн хийгддэг ажлын тухай мэдлэггүй (жишээ нь хяналтын талбай дээр гэрчээр байх зэрэг) байсан

юм. Үүнтэй холбоотойгоор ЗБУ, ХХЯ-ын зарим оролцогч зарим компаниуд их нууцлаг байдаг нутгийн малчдад хууль ёсоор ажиллаж байгаа эсэхээ нотлох уурхайн лицензээ үзүүлэхээс татгалздаг гэжээ.

Түүнчлэн зарим уул уурхайн компаниуд сум захиаг хүлээн авсан өдрөөс хойш биш Ашигт малтмалын газарт өргөдөл өгсөн цагаас хойш 30 өдрийн хугацааг тооцдог. Хэрэв энэ хугацаанд уулзалт болоогүй бол үүнээс хойш гарсан багын хурлын ямар ч шийдвэрийг харгалзан үздэггүй уул уурхайн үйл ажиллагаагаа үргэлжлүүлдэг гэж бидэнд хэлсэн нь уул уурхайн талаар Монгол улсад хэрэгжиж буй үндэсний хууль, журмын хэрэгжилтэд ноцтой асуудал байгааг илтгэнэ. Манай ЗБУ, ХХЯ-ын оролцогчид түүнчлэн заасан хугацаанд шинэ уурхайн лицензийг зөвшөөрөхөөс татгалзсан санал өгсөн ч (жишээ нь, өргөдлийг сум хүлээн авснаас хойш 30 хоногийн хугацаанд) тэдний саналыг хүндэтгэн үздэг гэдэгт итгэхгүй байгаагаа илэрхийлсэн юм. Саяхны нэг жишээгээр Элдэв багын нутагт үйл ажиллагаа явуулах сонирхолтой хоёр уурхайн компанийн хүсэлтийг орон нутгийн иргэд хамгийн сайн бэлчээртэй есөн өвөлжөөний газрыг хамрах учир аль альныг нь зөвшөөрөөгүй байна.

Бидний 2016 оны ажлын үеэр сөхөгдсөн уул уурхайн хөрөнгө оруулалтын процедурын тухай бусад асуудал нь ихэвчлэн гадаадын, ялангуяа Хятад хүмүүс уурхай эзэмшдэг гэсэн ойлголт нутгийн иргэдийн дунд байдагтай холбоотой байв. ЗБУ, ХХЯ-ын оролцогчид жишээ нь Хятад хүмүүс дотоодын (Монгол) компаниудаар дамжуулан (албан ёсны) ажилладаг ба жижиг, дунд хэмжээний жоншны уурхай эрхлэгчид “түгээмэл олдоцтой ашигт малтмал” гэсэн нэрийн доор том хэмжээний лиценз авч (жишээ нь хайрга, чулуу зэрэг барилгын материалын) гар аргаар жоншны олборлолт явуулж байгаа хүмүүсийн газрыг булаан авдаг гэсэн юм. Бидэнд хүмүүс хэлэхдээ жоншны бичил уурхай олон жил эрхэлсэн хүмүүс тухайн газрын жоншны нөөцийн их байгаа эсэхийг үнэрлээд л мэддэг учир дээрх компаниуд өөрсдийн нэр дээр албан ёсны бичиг баримт авангуутаа бичил уурхай эрхлэгчдийг тухайн газраас хөөдөг байна. 2016 оны ажлын үеэр ярилцсан зарим хүмүүс томоохон жоншны уурхайн компаниуд хайгуул хийхдээ энэ аргыг ашигладаг тэдний нийтлэг стратеги юм гэж хэлсэн юм.

Хятадын эзэмшиж буй уурхайнууд гэсэн ойлголт мөн хууль бус лицензийн худалдаатай холбоотой байсан. Энэ нь Монгол улсын тухай өөр олон тайлангуудаас харахад Даланжарган суманд байгаа 42 албан ёсны ашиглалтын лицензний хэд нь зүй ёсны болохыг таашгүй болгож байгаа юм. Бусад лиценз эзэмшигчид газраа хэсэгчлэн бичил уурхай эрхлэгчдэд түрээсэлдэг байна.

Нөгөө талаас компаниудыг “сайн”, “муу” гэж зайлшгүй ялгах шаардлагатай байдаг бөгөөд манай ЗБУ, ХХЯ-ын оролцогчдын зүгээс МАК-г хамгийн хариуцлагатай “сайн” уул уурхайн компани гэж үнэлсэн. Гэхдээ хамгийн сайн компанийн хувьд ч заримдаа хөрөнгө оруулалтын процедурын хувьд бэрхшээлтэй тулгардаг. Жишээ нь, 2016 оны ажлын үеэр бидний үүлзсан МАК-ын ажилтнууд хэлэхдээ баг, сумын уулзалтад оролцож байх үед нутгийн иргэдийн олонхи холбогдох хууль, журмын тухай мэдлэггүй, оролцогч бүх талуудын эрх, үүргийн талаар мэддэггүйг ажигласан бөгөөд төр захиргаа, ард иргэдийн дунд гацдаг тухайгаа тайлбарласан юм.

Ажил эрхлэлт ба компанийн нийгмийн хариуцлага (КНХ)

2016 оны ажлын үеэр дунд, том хэмжээний уул уурхайн компаниудын ажил эрхлэлт, компанийн нийгмийн хариуцлага (КНХ) гэсэн хоёр асуудал сөхөгдөн гарч ирсэн юм. Уул уурхайн компаниуд зарим хүнд ажил олгосон ч нийт нутгийн иргэдийн тусын тулд маш бага зүйл хийсэн, харин ч илүү их асуудал үүсгэсэн гэж нутгийн олон хүн үздэг байна.

Ажил эрхлэлтийн талаар албан ёсны мэдээлэл бидэнд бага олдсон ч Даланжаргалан суманд ажиллаж байгаа уул уурхайн компаниуд цөөн хэдэн хүнд голдуу биеийн хүчний ажил олгосон гэж хүмүүс үздэг байна. МАК-ын ажилтны яриагаар Элдэв багт байрлах МАК-ын нүүрсний уурхайд 2016 оны ажлын үеэр 30 гаруй хүн ажиллаж байв. Гэхдээ урьд нь тэнд илүү олон хүн

ажилладаг байсан ба зарим орон нутгийн иргэд цэвэрлэгч, галчийн ажил эрхэлдэг байв. Олон-Овоо баг дахь МАК-ын цементийн үйлдвэрт барагцаагаар 500 гаруй хятад барилгын ажилтнууд түр ажиллаж байгаа бөгөөд үйлдвэр ашиглалтад бүрэн ороход орон нутгийн иргэдийг түлхүү авч ажиллуулах төлөвлөгөөтэй байна. Гэхдээ заримдаа орон нутгийн ажилтнуудтай холбоотой асуудлууд ялангуяа цалин буусны дараа архидалт, ажил таслалт зэрэг асуудлууд гардаг тухай бас яриа байна.

Бидний ЗБУ, ХХЯ-н үеэр Даланжаргалан сумын уул уурхайн компаниуд ажилтнуудынхаа нийгмийн даатгалын төлбөрийг төлдөггүй бөгөөд уурхайн ихэнх ажил хүнд хэцүү учир компаниуд эрэгтэй хүмүүсийг ажилд авахыг илүүд үздэг байна. Олон хүмүүс ажлын нөхцөл байдал эрүүл бус ялангуяа тоостой орчинд ажилладаг тухай гомдол мэдүүлсэн юм. Нөгөө талаар Даланжаргалан суманд ихэнх нь албан бус, цаг зуурын ажил байж болох ч орон нутгийн иргэд уул уурхайгаас ажил олох боломжтой гэдэг нь тодорхой харагдаж байна. Мөн дээр дурьдсан Хятадын жоншны зарим компани газар дээр гаргаж ирсэн жонш ялгах ажлыг нутгийн иргэдийг хөлсөлж үе үе хийлгэдэг байх жишээтэй. Нэг тонныг ялгахад 250,000 төгрөг (115 ам.доллар) байдаг байна.

Дээр дурьдсанчлан МАК аас бусад тохиолдолд ЗБУ, ХХЯ-н оролцогчид ерөнхийдөө дунд, том хэмжээний уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлага дутмаг байгаа гэж дүгнэж байв. Бусад олон компаниудын эсрэгээр МАК-н үйл ажиллагаанд эерэг хандлагатай байсан нь уурхайн үйл ажиллагааны дунд болон хаалтын үе шатанд байгаль орчны нөхөн сэргээх ажил хийдэг гэж ойлгож байгаатай холбоотой байна. Бидний 2016 оны ажлын үеэр ярилцсан зарим хүмүүс МАК-н байгаль орчны төлөвлөгөөний талаар багын хурлаар (Элдэв багт) хэлэлцэн зөвлөлдсөн, гэхдээ зарим хүмүүс энэ төлөвлөгөөний талаар дэлгэрэнгүй мэдэх зүйл байхгүй гэсэн юм. 2016 оны 11-р сард Элдэв багын нутагт байрлах МАК-н нүүрсний уурхайд айлчлах үеэр бидний ажигласнаах 50 га газрыг нөхөн сэргээж чацаргана тарьсан байв. Мөн МАК-н ажилтны хэлснээр Монгол улсын хэмжээний хамгийн том уул уурхайн компани учир хамгийн сүүлийн үеийн байгаль орчинд хамгийн бага хохирол учруулах технологийг нэвтрүүлж бусад уул уурхайн компаниудад үлгэрлэж олон улсын жижиг тогтоохыг эрмэлздэг гэсэн юм.

Мөн МАК компани нийгмийн хариуцлагын нэг хэсэг болгож 120 хүүхдийн багтаамжтай бүрэн тохижуулсан цэцэрлэгийг Даланжаргалан сумын төвд, мөн дээр дурьдсан Элдэв багын төвийг барьж өгсөн байдаг. МАК-ын ажилтан Дорноговь аймгийн хэмжээнд 2013-2015 оны хооронд нутгийн иргэдэд дэмжлэг үзүүлэх санаачлагуудад 65,000,000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн гэсэн ч үүнээс Даланжаргалан суманд яг хэдий хэмжээний хөрөнгө оруулалт хийснийг хэлээгүй юм. Гэсэн хэдий ч компанийн цахим хуудсанд МАК Сангаар дамжуулан гүйцэтгэдэг компанийн нийгмийн хариуцлагын олон тооны үйл ажиллагааны жагсаалт байсан ба компанийн зүгээс сумын бусад компаниудтай харьцуулахад хийсэн ажилаараа бахархаж байсан юм. МАК орон нутгийн барилга байгууламжийг барьж байгуулах, засч сэлбэхээс гадна өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, ганцаар амьдарч буй өндөр настан, олон хүүхэдтэй ядуу өрх зэрэг нийгмийн эмзэг бүлгүүдэд өвөлжилтийн бэлтгэл болох нүүрс, түлээний модоор хангаж тусалсан байна. Бидний ажлын үеэр энэ төрлийн тусламжийн хэмжээ бага, тогтвортой биш гэж илэрхийлсэн олон янзын хүмүүс байсан ба ерөнхийдөө илүү ихийг хийх хэрэгтэй гэж байв. Гэсэн хэдий ч МАК-ын ажилтан Даланжаргалан сумын малчдаас ямар нэгэн ноцтой гомдол санал хүлээж авч байгаагүй гэсэн учир хүмүүс олон янзын компаниудын нийгмийн хариуцлагын ажлыг ялгаж салгаж үнэлж байгаа эсэх, эсхүл ерөнхийдөө уул уурхайн компаниудад сэтгэл тааламжгүй ханддаг эсэхийг мэдэхэд бэрхшээлтэй байв.

Уул уурхайн татвар хураамжийн талаарх хүмүүсийн мэдлэг бас их дутмаг байсан. Манай ЗБУ, ХХЯ-ын оролцогчид компаниуд суманд татвараа төлдөггүй гэж гомдол мэдүүлж байсан бол үнэндээ компанийн төлдөг татвар улсын төсөвт хуримтлагддаг бөгөөд тэндээс аймгуудад төсөв хуваарилагддаг (дараа нь сумдад) үндэсний бодлогын хүрээнд явагддаг байна. Гэхдээ Даланжаргалан суманд идэвхтэй ажиллаж буй жижиг хэмжээний уул уурхайн компаниуд сумын хөгжилд шууд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг тухай ЗБУ, ХХЯ-н оролцогчид хэлж байсан ч

түүний хэмжээ, механизмын аль аль нь тодорхойгүй байлаа. Мөн үүл уурхайн үйл ажиллагааны улмаас малаа алдсан хүмүүст ямар нэгэн нөхөн олговор олгоогүй зарим тохиолдол байгаа тухай бидэнд хэлсэн юм.

Бичил уурхай

Бидний 2016 оны ажлын үеэр Даланжаргалан сумын бичил уурхай эрхлэгчид жижиг хэмжээний жоншны уурхай болон Хятад улсад гоёл чимэглэлийн зүйл хийх, байшин барилга чимэхэд хэрэглэдэг янз бүрийн өнгөтэй хагас өнгөт чулуу цуглуулах буюу олборлох ажилд холбогдож байгаа нь харагдсан. Жоншны олборлолт хийхийн тулд 10 аас 60 метр нүх ухаж газар доогуур явдаг эрсдэлтэй, байгаль орчинд халтай ажил бөгөөд хагас үнэт чулууны олборлолт бол зөвхөн газрын өнгөнөөс чулуу түүх үйл ажиллагаа юм.

Даланжаргалан сумын бичил уурхайн үүсэл хөгжлийн тухай нарийн мэдээлэл олж авахад хүндрэлтэй байсан. Дээр өгүүлсэнчлэн энэ үйл ажиллагаа 1990 ээд оны үед эхэлсэн ба хүмүүс улсын өнцөг булан бүрээс ирж Элдэв, Олон-Овоо багт ажиллахаар ирж байлаа. 1990 ээс 2000 аад оны үед суманд хэдий тооны бичил уурхай эрхлэгчид байсан талаар албан мэдээлэл олж авч чадаагүй ч манай ЗБУ, ХХЯ-ын оролцогчид 2010 оны үед хэдэн мянган хүмүүс байсан гэж хэлж байгаа юм. Эдгээр гар аргаар уурхай эрхлэгчид хууль бусаар ажиллаж байсан ба эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, мөн оюутнууд зуны амралтаараа оролцдог байв. Тэр үед ажиллаж байсан уурхайчид бидэнд хэлэхдээ хүрэээр нүх ухах гэх мэтээр маш энгийн тоног төхөөрөмж ашигладаг байсан гэв. Гэхдээ бусад хүмүүс хууль бусаар үйл ажиллагаа явуулж байсан мөн сайн сайхан дурсамж бараг үгүй тул түршлагаасаа хуваалцах сонирхолгүй байв. Ихэнх нь бичил уурхай эрхэлж амьжиргаагаа үнэмлэхүй сайжруулсан ба зарим нь өвчин туссан юм.

2010 оноос жоншны бичил уурхайчдын тоо эрс багассан нь тодорхой байгаа нь нэгдүгээрт нөөц багассан, хоёрдугаарт хүмүүс жоншны бичил уурхайн олборлолт тоос шороотой орчинд ажилладаг болон газар доор байхад шороонд дарагдаж бэртэж гэмтэх тэр бүү хэл үхэх аюултай гэдгийг аль альныг нь ойлгосон явдал юм.

Даланжаргалан суманд жоншны бичил олборлолт буурсан гурав дахь шалтгаан нь компаниудад ашиглалтын лиценз илүү ихээр олгож эхэлсэнтэй холбоотой гар аргаар олборлогчдод ажиллах газар бага үлдсэн ба ялангуяа компаниуд газраа хашаалж, эргүүл гаргасантай холбоотой. Гэсэн хэдий ч манай ЗБУ, ХХЯ-ын оролцогчид орон нутгийн хүмүүс уурхай эрхэлсэн хэвээр байгаа ба эмэгтэй уурхайчдаас бүрдсэн нэгэн ЗБУ-ын оролцогчид Олон-Овоо багт 50-60 өрх жоншны бичил уурхайн ажил эрхэлдэг гэж бидний 2016 оны ажлын үеэр хэлэх жишээтэй.

Даланжаргалан сумын гар аргаар жонш олборлогчид ихэвчлэн өрхийн эсхүл нөхөрлөлийн зохион байгуулалттай байдаг байна. Сумын захиргаанд албан ёсоор бүртгүүлсэн хэд хэдэн нөхөрлөл авсан газартаа үүл уурхай явуулах хууль ёсны эрхтэй ч ихэнх нь хууль бусаар үйл ажиллагаа явуулсан хэвээр байна. Манай ЗБУ, ХХЯ-ын хэд хэдэн оролцогч жоншны бичил уурхай эрхлэх лиценз авахыг оролдсон ч бүтээгүй учир хууль бусаар олборлолт явуулсаар байна хэмээсэн. Даланжаргалан сумын олон бичил уурхайчид орон нутгийн захиргааны дэмжлэгтэй хууль ёсны бичил уурхай эрхлэх нөхөрлөл байгуулж, албан ёсоор газар авах хүсэлтэй байгаа талаар бид олж мэдсэн. Бидний ЗБУ, ХХЯ-н оролцогчид бичил уурхайчид сонголтгүй, зайлшгүй шаардлагын улмаас л гар аргаар жонш олборлосон хэвээр байгаа бөгөөд тэд янз бүрийн эрсдэлтэй гэдгийг мэдэж байгаа ч үүнийг илүү аюулгүй, зүй ёсны амьжиргааны эх үүсвэр болгохыг хүсдэг гэв.

Даланжаргалан сумын захиргаа улсын бусад газарт гар аргаар уурхай эрхлэгчдийн нөхөрлөл байгуулан ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлж байгаа шиг дотоодын дүрэм, журам гаргаагүй байгаа учир бичил уурхайчдыг бүрэн дэмжихгүй байна гэж үзэж байна. Суманд бичил уурхай эрхлэгчдийг хууль ёсны болгох процесс ахицгүй байгаа нь хоёр шалтгаантай. Нэгдүгээрт бичил уурхай эрхлэгчдийн тоо хурдацтай өсч нийгэмд нөлөө үзүүлэх (эрүүл мэндэд муугаар

нөлөөлөх, хүчирхийлэл ба архидалт ихсэх) болов уу гэсэн айдас, хоёрдугаарт жижиг жижиг гар аргаар жонш олборлогчдод газар олгосноос цөөн хэдэн дунд хэмжээний уурхайн компаниудад газар олгохыг илүү үзэж байгаад юм. Гэсэн хэдий ч бидний 2016 оны ажлын үеэр Даланжаргалан сумын гар аргаар жонш олборлогчдын хувьд тэдний хууль бус гэсэн статусаас шалтгаалан бичил уурхай эрхлэгчдийн дунд болон бичил уурхайчид болон том компаниудын хооронд маргаан их гардагаас шалтгаалан албан ёсны бүртгэл хийлгэхтэй холбоотой хүндрэлтэй асуудлууд их байна.

Гар аргаар жонш олборлох бүлгүүд нь ихэвчлэн 4-10 гишүүнтэй заримдаа зөвхөн эмэгтэйчүүдээс бүрддэг. Зарим бүлэг газар доогуур ажилладаг байхад зарим нь томоохон жоншны компанийн үлдэц газар дээр ажилладаг байна. Ихэвчлэн эрэгтэйчүүд газар ухаж доошоо ордог ч зарим үед эмэгтэй хүн хийдэг байна. Зарим өрхийн хэмжээний бүлэг жижиг бизнесийн хэлбэрээр ажилладаг газар доор орж хүдэр авчрах хүн хөлсөлж авах, жоншоо зах зээлд борлуулах гэх мэтээр эмэгтэйчүүд уурхайн ажил болон бизнес худалдааны ажлын аль алинд оролцдог байна. Жонш олборлолт ихэвчлэн зүн цагт явагддаг бөгөөд намар худалдаалдаг байна. Гэхдээ бидний ярилцсан зарим нэг жонш ухагчид зөвхөн өдрийн хоолны мөнгөө олохын тулд л ухаж байгаа болохоос энэ ажлыг хийж баян болсон хүн олно гэдэг амаргүй гэсэн юм.

Жонштой адилгүй хагас үнэт чулуу түүдэг хүмүүс бүгд хууль бусаар ажилладаг ба зарим үед эхнэр нөхөр хоёр хамтдаа байдаг ч аль болох хувиараа ажилладаг. Энэ төрлийн гар аргаар олборлолт хийх үйл явц саяхан үүссэн бөгөөд Хятад хүмүүс нутгийн иргэдээс чулуу худалдан авч эхэлснээс хойш сүүлийн хэдэн жил болж буй үйл явц юм. Манай ЗБУ, ХХЯ-н оролцогчид хууль бус хагас үнэт чулуу олборлогчдын ихэнх нь эмэгтэйчүүд, ялангуяа Өнгөт багт явагддаг үйл ажиллагааны хувьд гэсэн юм. Зарим нэг баг, сумын ажилтнууд бидэнд хэлэхдээ эдгээр эмэгтэйчүүдийг үйл ажиллагаагаа зогсоохыг шаардахад хүч хэрэглэн айлган сүрдүүлсэн хэмээсэн юм. Одоогийн байдлаар ихэнх нь шөнөөр үйл ажиллагаа явуулдаг гэсэн мэдээ байна.

Мөн бид өөр сумын 4-5 хүн хагас үнэт чулуу цуглуулахаар ачааны машинтай ирсэн дор хаяж нэг тохиолдол гарсныг сонссон ба зарим хүмүүс Өмнөговь, Сэлэнгэ аймгаас ирсэн сурагтай. Газар дээр ил байгаа чулуунуудыг түүж авч дуусаад газар доор даруй 15 метр хүртэл нүх ухаж илүү ихийг хайдаг нь өнгөн хөрс болон ургамал ногоог сүйтгэж нутгийн малчид болон чулуу ухагчдын хооронд зөрчил гарахад нөлөөлж байна.

Уул уурхайн үр нөлөө

Бидний суурь судалгааны үеэр санамсаргүй түүврийн 74 өрхийн 54% (40%) сүүлийн хоёр жилийн хугацаанд уул уурхай тэдний амьдралд ямар нэгэн хэлбэрээр нөлөөлсөн гэж мэдэгдсэн бөгөөд Элдэв багын санамсаргүй түүврийн өрхийн 82%, сумын төвийн Цомог багын санамсаргүй түүврийн өрхийн 33% байна. 11-р хүснэгтэд харуулав. Үүнийг Даланжаргалан суманд Их Нартын байгалийн нөөц газар байрладаг ч санамсаргүй түүврийн өрхийн зөвхөн 5% (4) болон 15% (11) нь байгалийн цогцолбор газар болон том хэмжээний газар худалдан авалт тус тус өрхийн амьдралд сүүлийн хоёр жилийн хугацаанд нөлөө үзүүлсэн гэсэнтэй харьцуулж болох юм. Бүх эмэгтэй хариулагчдын 57% (54 хүний 31), бүх эрэгтэй хариулагчдын 46% (39 хүний 18) нь уул уурхай өрх гэр бүлд нь нөлөө үзүүлсэн гэж хариулжээ.

Хүснэгт 11. Даланжаргалан сум, Уул уурхайн өрхөд үзүүлсэн нөлөөлөл, багаар

Баг	Уул уурхай өрхийн амьдралд нөлөөлсөн гэж хариулсан өрхийн %
Бичигт	64%
Элдэв	82%
Олон-Овоо	47%
Цомог	33%
Өнгөт	60%
Нийт Даланжаргалан	54%


Эх үүсвэр: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа 2016. Бичигт багын түүврийн хэмжээ N = 11. Элдэв багын түүврийн хэмжээ N = 11. Олон-Овоо баг N = 19. Цомог баг N = 18. Өнгөт баг N = 15. Даланжаргалангийн нийт түүврийн хэмжээ N = 74.

11-р хүснэгтэд байгаа мэдээлэл сонирхолтой байсан. Яагаад гэвэл нэгдүгээрт хамгийн их, том уурхайнууд байрладаг Элдэв багын өрхүүдийн хамгийн их хувь нь уул уурхай тэдэнд нөлөө үзүүлсэн гэж тайлбарласан байхад суурь судалгаанд энэ багт уул уурхайтай холбоотой ажил хийдэг нэг ч хүн байгаагүй ба ЗБУ-ын үеэр цөөн хэдэн оролцогч МАК-ын нүүрсний уурхайд ажилладаг гэж хэлсэн байх юм. Хоёрдугаарт, үйлдвэр компанийн ажилчдын ихэнх амьдардаг суурин хоёр багын өрхийн хамгийн бага хувь нь уул уурхай өрхийн амьдралд нөлөө үзүүлсэн гэж мэдээлсэн юм. Энэ нь суурь судалгааны оролцогчид хэдийгээр дараа нь бид өрхийн эдийн засгийн байдал, орон нутгийн газар, байгалийн нөөцөд нөлөөлж буй эерэг, сөрөг нөлөөллийн талаар янз бүрийн асуултыг дэлгэрэнгүй тавих байсан ч суурь судалгааны нээлтийн ерөнхий асуултыг уул уурхайн сөрөг нөлөөллийн тухай асууж байна гэж үзсэнд оршино.

Ямар багт амьдарч байгаагаас шалтгаалан өрхийн нөлөөлөлд өртөж буй хэлбэр ялгаатай байсан нь бас их сонирхолтой юм. Жишээ нь, Элдэв багын санамсаргүй түүврийн өрхийн 55% уул уурхай өрхийн орлогыг бууруулсан гэж үзэж байхад Олон-Овоо багын санамсаргүй түүврийн өрхийн 26% уул уурхай өрхийн орлогыг нэмэгдүүлсэн гэж үзэж байв. Энэ нь эхний тохиолдолд уул уурхай уламжлалт малчдын амь амьжиргаанд нөлөө (ихээхэн сөргөөр) үзүүлдэг, хоёр дахь тохиолдолд уул уурхайн нь уул уурхайн компани, үйлдвэрийн ажилчдын амьдралд нөлөө (ихээхэн эерэгээр) үзүүлдэгтэй холбоотой юм. Суурь судалгааны Бичигт багын санамсаргүй түүврийн хоёр өрх уул уурхайн үйл ажиллагаа өрхийн газрын зарим хэсгийг ямар нэгэн нөхөн олговор өгөлгүйгээр авсан, Элдэв, Өнгөт, Бичигт гэсэн гурван хөдөөний багын 10 өрх “Уул уурхайн үйл ажиллагаа нийтийн эзэмшлийн бэлчээрийн газрын зарим хэсэгт нэвтрэхээргүй/орж чадахааргүй болгосон” гэсэн ба мөн энэ 3 багын 17 өрх “уул уурхай нийтийн бэлчээрийн газрын хүрэлцээг бууруулж байна” гэсэн байна.

Даланжаргалан сумыг нийтэд нь авч үзвэл дараах 11-р зураглалд харуулсны дагуу уул уурхайн үзүүлж буй хамгийн их нөлөөлөл нь сөрөг, газар, байгалийн нөөцтэй холбоотой байна. Гэхдээ эдийн засгийн эерэг нөлөө буюу санамсаргүй түүврийн өрхийн 14% (10) уул уурхайн үйл ажиллагаа тэдний өрхийн орлогыг нэмэгдүүлсэн, жишээ нь махны зах зээлийг бий болгосон, нутгийн дэлгүүр, үйлчилгээний газарт худалдан авагчидтай болсон гэх зэргээр, 3% (2) бичил уурхайд ажиллах болсноор өрхийн гишүүд ажилтай болсон гэсэн байхад 4% (3) өрхийн зарим гишүүд “уул уурхайн компанид албан ёсны ажил олсон” гэжээ. Нөгөө талаар мөн 11-р зураглалд харуулснаар 15% (11) уул уурхай “өрхийн орлогыг бууруулсан”, 19% (14) уул уурхайн үйл ажиллагаа “өрхийн гишүүдийн эрүүл мэндэд муугаар нөлөөлсөн” гэжээ.

Зураглал 11. Даланжаргалан сум, Санамсаргүй түүврийн өрхийн үүл уурхайн нөлөөлөлд өртсөн байдлын мэдээлэл



Эх үүсвэр: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Түүврийн хэмжээ N = 74.

Суурь судалгааны санамсаргүй түүврийн өрхийн хариулагчдын мэдээлснээр уул уурхайн хамгийн түгээмэл нөлөөлөл нь газар болон байгалийн нөөцөд үзүүлэх нөлөө байсан бөгөөд 11-р зураглалд үзүүлсний дагуу “уул уурхай нутгийн усны нөөцийг багасгаж байна” –санамсаргүй түүврийн өрхийн 41% (30), “уул уурхай энд тэндгүй зам гаргаж, бэлчээр сүйтгэж, малд аюул учруулдаг”- 38% (28), “уул уурхай шороо их гаргаж, газрын чанарыг муутгадаг” -36% (27), “уул уурхай нийтийн бэлчээрийн газрын үрэлцээг бууруулж байна”-32% (24) тус тус байна.

Манай ЗБУ, ХХЯ-ын ихэнх оролцогч байгаль орчинд үзүүлж буй асар их нөлөөлөл голдуу бэлчээр, усны нөөц буюу малчдын амьжиргааны гол эх үүсвэр, хүн малын аль альных нь эрүүл мэндэд нөлөөлж буй талаар саналаа хэлсэн юм. Хоорондоо уялдаатай 4 хэсэг асуудлыг ихэнх оролцогч хөндөж байв. Нэгдүгээрт, уул уурхай олон хяналтгүй зам үүсгэж байна гэсэн мэдээ өгсөн. Замаа засварлаж ашиглахын оронд компаниуд зүгээр л шинэ зам гаргаад байдаг нь тоос шороо их босгодог, бэлчээрийг сүйтгэдэг гэсэн байна. Түүнчлэн компанийн машинүүд шөнийн цагаар мал дайрдаг ба малчдад нөхөн олговор олгодоггүй гэсэн байна. Хоёрдугаарт, гадаргын болон гүний усны аль альных нь түвшин буурсан учир малчдад малаа услахад бэрхшээлтэй болсон. Мөн уул уурхайн компаниуд ашигласан усаа газарт шингээдэг нь гадаргын болон гүний усны чанарт нөлөөлж байна гэж үзсэн. Говь нутаг гадаргын усны цөөн хэдэн урсгалтай бөгөөд суманд явагдаж байгаа томоохон уул уурхайн үйл ажиллагааны үршгаар ихэнх нь хатаад дууслаа гэж бидний 2016 оны ажлын үеэр хүмүүс гомдол мэдүүлж байсан юм. Гуравдугаарт, манай ЗБУ, ХХЯ-ын оролцогчдын үзэж буйгаар уул уурхайн компаниудын бий болгосон гүнзгий нүхнүүд мал үхэх гол шалтгааныг үүсгэж байгаа бөгөөд ихэнх уурхайн компаниуд газраа нөхөн сэргээдэггүйн улмаас суманд энд тэндгүй үхсэн нүх байна гэж мэдэгдсэн юм. Эцэст нь уул уурхайн компаниудын үүсгэж байгаа утаа, тоос малчдын эрүүл мэндэд муугаар нөлөөлдөг астматай болгодог, мөн малын эрүүл мэндэд муугаар нөлөөлдөг уушиг, ходоодноос нь тоос гарч ирдэг гэж малчид тайлбарласан билээ.

Манай ЗБУ, ХХЯ-ын зарим оролцогчид ихэвчлэн эрэгтэй хүмүүс уурхайд ажиллаж, эрүүл мэндээр хохирдог учир уул уурхайн нөлөөлөлд илүү өртдөг гэсэн. Мөн тэд уул уурхайн гол нөлөөлөлд өртдөг хүмүүс бол малчид бөгөөд уламжлалт мал аж ахуйг голдуу эрэгтэй хүмүүс эрхэлдэг юм гэсэн. Гэхдээ манай ихэнх ЗБУ-ын эрэгтэй, эмэгтэй хүмүүс ялгаагүй тэдний өрхийн бүх гишүүдэд уул уурхай сөргөөр нөлөөлж байгаа тухай гомдол хэлсэн.

Даланжаргалан суманд гар аргаар ашигт малтмал олборлолт хэмжээний хувьд бага тул байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь дунд болон том хэмжээний уул уурхайн компануудынхтай харьцуулахад бага гэж үздэг байна. Жишээ нь, компаниуд бэлчээр сүйтгэж, тоос татуулж зам их гаргадаг гэсэн асуудал том компанитай холбоотой байхад бичил уурхайчдын хувьд ашигласан

газраа цэвэрлэдэггүй том том нүх үлдээгээд явдаг, ялангуяа жоншныхон 60 гаруй метрийн гүн нүх үлдээдэг гэсэн байна. Бидэнд хэлснээр энэ асуудал нь малчид болон бичил уурхайчдын хооронд гардаг гол зөрчлийн шалтгаан бөгөөд үхсэн нүхэнд мал унаж үхдэг байна. Гэхдээ том компанийн хувьд ч ийм зүйл тохиолддог. Өнгөт багт Сайн Гашуун компани 2016 оны бидний ажлын үеэр үйл ажиллагаагаа зогсоосон байсан ч энэ уурхай маш гүнзгий нүх ухаж орхисон бөгөөд бэлчээрийн малд үхлийн аюултай гэж хүмүүс үзэж байв. Нөгөө талаар хагас үнэт чулуу олборлож байгаа бичил уурхайчид багахан газар, байгальд хор хохирол бага учруулах техник хэрэглэдэг учир байгаль орчинд үзүүлэх нөлөө хамгийн бага байдаг гэж үздэг байна.

Бидний суурь судалгаагаар байгаль орчны доройтлын тухай хүмүүсийн ойлголт нь бүхэлдээ уул уурхайтай холбоотой байгаа нь илэрсэн. 12- р зураглалд үзүүлэв. Бидний 2016 оны судалгааны ажлын үеэр бүх эмэгтэй хариулагчийн 72% (39), бүх эрэгтэй хариулагчдын 69% (27) нь энэ нутагт байгалийн нөөц, байгаль орчны доройтол нүүрлэж байна гэж үзсэн ба бүх эмэгтэй хариулагчийн 63% (34), бүх эрэгтэй хариулагчийн 44% (17) нь усны бохирдлын асуудал байгаа гэж үзэж байна.

Хүснэгт 12. Даланжаргалан сум, Хариулагчдын орон нутгийн байгаль орчны тухай ойлголт, хүйсээр

	Тийм (жендерээр ялгасан хувь)		Үгүй (жендерээр ялгасан хувь)		Мэдэхгүй (жендерээр ялгасан хувь)	
	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр
Танай энд байгалийн нөөцийн доройтлын асуудлууд байдаг.	72	69	15	21	13	10
Танай энд усны бохирдол асуудал болоод байгаа.	63	44	24	38	13	18

Эх үүсвэр: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Хүснэгтэд зориудаар нэмэлт судалгаа авсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, санамсаргүй түүврийн өрхийн аль аль нь багтсан. Эмэгтэй хариулагчийн түүвэр N = 54. Эрэгтэй хариулагчдын түүвэр N = 39.

Бидний 2016 оны ажлын үеэр ажигласан бас нэг зүйл нь Даланжаргалан сумын иргэд уул уурхайн салбарт үүсч буй олон асуудлын заримыг янз бүрийн аргаар шийдвэрлэх гэсэн оролдлого хийдэг байна. Дээр өгүүлсэнчлэн Өнгөт багын нутагт явуулах зорилготой хоёр компанийн хүсэлтийг багын хурлаар нилээд нухацтай авч хэлэлцсэн ба зарим хүмүүс олон асуудлын талаар гомдол мэдүүлсэн байна. Гэхдээ бидний олж мэдсэнээр уул уурхайн компаниуд орон нутгийн иргэдийн санал гомдлыг хүлээн авдаг албан ёсны ажилтангүй байдаг ба ерөнхийдөө иргэдийн санал гомдлыг хүлээн авч сайн шийдвэрлэдэггүй бололтой юм.

Бидний суурь судалгааны үеэр сүүлийн 12 сарын туршид уул уурхайн компаниудтай маргаанд холбогдсон 3 тохиолдлын зөвхөн нэг маргааныг шийдвэрлэсэн байна. Энэ тохиолдол Олон-Овоо багын өрхийн тухайд байсан ба өрхийн тэргүүний эхнэр нь нөхөрлөлийн гишүүн байсан ба тэдний ашиглаж байсан талбай дээр сүүлд Хятадын уул уурхайн компанийн лиценз авсан талбайтай давхацсан байсан учир нөхөрлөлийн ахлагч 500,000 (229 ам.доллар) төгрөгний нөхөн олговрыг компанид төлж газартайгаа үлдэх тохиролцоо хийсэн байдаг.

Хоёр дахь тохиолдол нь Бичигт багын шүтлэгтэй Их Хонгор хайрхантай холбоотой бөгөөд Хятад, Солонгосын жоншны уул уурхайн компаниуд сүүлийн жилүүдэд олборлолт хийсэн гэсэн мэдээ байна. Бидэнд хэлснээр нутгийн иргэд албан ёсны гомдол мэдүүлсэн боловч компаниуд олборлолтоо үргэлжлүүлсээр байсан ба аймгийн захиргаанаас ямар нэгэн арга хэмжээ авч шийдвэр гаргаагүй байна. Гурав дахь тохиолдол нь Өнгөт багын өрхийн мэдээлсэн хэрэг юм. Энэ өрхийн гишүүд уул уурхайн компаниудын ачааны тэрэгнүүдийн бий болгож байгаа тоос шорооны талаар аймгийн иргэдийн хурал, улсын мэргэжлийн хяналтын газарт хандаж гомдол гаргасан боловч ямар нэгэн хариу сонсоогүй л байгаа гэсэн юм. Бидэнд хэлснээр аймгийн тээврийн асуудал хариуцсан ажилтан ирж, тоосжилтыг бууруулах, засмал зам барих боломжийг судалсан боловч одоогоор хийсэн зүйлгүй байсан. Уурхайн том том ачааны машинууд энэ өрхийн өвөлжөөний хажуугаар асар их тоос татуулсан давхисаар л байна.

Газар олгох үйл явц

Албан ёсны газар олгох үйл явцыг дагах ёстой газрын үндсэн хэлбэр нь төвийн хоёр багт амьдарч байгаа иргэдийн өмчлөх эрхтэй авах орон сууцны газар, хөдөөний гурван багын иргэдийн эзэмших эрхтэй авах өвөлжөө, хаваржааны газар юм. Дээр өгүүлсэнчлэн, шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэх, орон нутгийн захиргаатай уулзах, газар авах, өмчлөх, эзэмших гэрчилгээ авах өргөдөл гаргах ажлыг эмэгтэйчүүд хийдэг байна. Энэ нь хөдөөний малчин өрхийн хувьд сүүлийн жилүүдэд сумын төвд ихэвчлэн амьдрах болж, захиргааны байгууллагатай ойрхон, үүлзалт хуралд оролцох, бичиг цаасны араас хөөцөлдөхөд хялбар болсонтой зарим талаар хамааралтай. Гэхдээ бас ЗБУ, ХХЯ-н зарим оролцогч залуу сайхан эмэгтэй хүн газрын албанд хандвал газар авах үйл хэрэг хурдан бүтэх магадлалтай учир эмэгтэйчүүд газар авах ажилд илүү их оролцдог гэсэн жиг жүг яриа гаргасан юм.

Мөн эмэгтэйчүүд ажлын ихэнхийг хийдэг ч ихэнх тохиолдолд гэрчилгээ эрэгтэй хүний нэр дээр гардаг байна. Харин бидний мэдэхээр манай ЗБУ-д оролцсон нэг малчин эмэгтэй өвөлжөөнийхөө эзэмших гэрчилгээг өөрөө бичиг баримтаа хөөцөлдсөн учир нөхрийнхөө нэрээр бус зөвхөн өөрийн нэрээр авсан нэг тохиолдол байна. Гэхдээ манай ЗБУ, ХХЯ-ийн ихэнх оролцогч эмэгтэйчүүд эр нөхөртөө итгэдэг, газрын гэрчилгээ нөхрийн нэр дээр байсан ч зөвхөн түүнийх биш өрхийн газар гэж үзэж буйгаа хэлсэн юм. Гэхдээ сум, багын ажилтнуудаас салалт болох тохиолдолд хэрхэх тухай асууж лавлахад хосууд шүүхэд хандаж болно эс бөгөөс гэрчилгээн дээр нэр байгаа хүн газраа авч үлдэнэ гэсэн юм.

Бидний 2016 оны ажлын үеэр Даланжаргалан сумын хүмүүс холбогдох хууль, журмын талаар хангалттай мэдлэггүй байгаа нь тодорхой байсан ба 13-р хүснэгтэд үзүүлэв. Жишээ нь, манай суурь судалгааны нийт эмэгтэй хариулагчийн 70% (54 өөс 38), нийт эрэгтэй хариулагчийн 64% (39 өөс 25) эмэгтэй хүмүүс газар өмчилж авж болно гэж зөв мэдэж байсан. Бүх эмэгтэй хариулагчийн 76% (41), бүх эрэгтэй хариулагчийн 85% (33) газар өмчлөлтэй холбоотой эрэгтэй эмэгтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхах явдал хууль бус гэж зөв хариулсан юм. Гэхдээ бүх эмэгтэй хариулагчийн 46% (25), бүх эрэгтэй хариулагчийн 26% (10) газрын эрхтэй байх нь бас тухайн газрын дор байгаа ашигт малтмалын эрхтэй гэсэн үг хэмээн буруу хариулж байв. Түүнчлэн нийт 93 хариулагчийн 33% (31) энэ тухай мэдэхгүй байна гэж хариулсан. Үүнээс гадна, бүх эмэгтэй хариулагчийн 20% (11), бүх эрэгтэй хариулагчийн 13% (5) Монголын хуулиар эрэгтэйчүүдийн газрын эрх эмэгтэйчүүдийн эрхээс илүү байдаг гэж үзжээ.

Хүснэгт 13. Даланжаргалан сум, Монголын хуулийн талаарх ойлголт, хүйсээр

	Тийм (жендерээр ялгасан хувь)		Үгүй (жендерээр ялгасан хувь)		Мэдэхгүй (жендерээр ялгасан хувь)	
	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр
Танай орны хуулиар эмэгтэйчүүдийг газар өмчлөхийг зөвшөөрдөггүй.	4	0	70	64	26	36
Танай орны хуулинд эрэгтэйчүүдийн газрын эрх эмэгтэйчүүдийнхээс илүү давуу байдаг ба нөхрүүдийн газрын эрх эхнэрүүдийнхээс илүү давуу байдаг.	20	13	59	56	20	31
Танай оронд газар өмчлөлийн тухайд эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдэд ялгавартай хандах нь хууль бус үйлдэл мөн.	76	85	11	3	13	13
Танай орны хувьд, хэрэв та газрын эрхтэй бол газрын дээр эсхүл доор нь байгаа ашигт малтмалын бас эрхтэй гэсэн үг.	46	26	22	38	31	36
Танай нутагт эмэгтэйчүүд байгалийн нөөцийн талаар шийдвэр гаргахад томоохон үүрэгтэй оролцдог.	15	21	52	41	33	38

Эх үүсвэр: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Хүснэгтэд зориудаар нэмэлт судалгаа авсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, санамсаргүй түүврийн өрхийн аль аль нь багтсан. Эмэгтэй хариулагчийн түүвэр N = 54. Эрэгтэй хариулагчийн түүвэр N = 39.

Үүнтэй холбоотойгоор 13-р хүснэгтэд мөн манай суурь судалгааны бүх эрэгтэй хариулагчийн 21% (8), бүх эмэгтэй хариулагчийн 15% (8) Даланжаргаланд эмэгтэйчүүд байгалийн нөөцийн талаар шийдвэр гаргахад томоохон үүрэгтэй оролцдог гэжээ.

Орон сууцны газар

Даланжаргалан сумын төвийн орон сууцны газрын өргөдөл гаргахад сумын жилийн газар ашиглалтын төлөвлөгөөний дагуу компаниар кадастрийн зураглал хийлгэдэг. ЗБУ-ын оролцогчдоор оролцогч талуудын шинжилгээ болон байгууллагуудын зураглал гэсэн дасгалууд хийлгэсэн ба тэд амьдрал дээр орон сууцны газар авах үйл явц чирэгдэл ихтэй, тодорхойгүй байдаг бөгөөд газар авах процесс бүхэлдээ их удаан явагддаг тухай сэтгэгдлээ хуваалцсан юм. Зарим хүн орон сууцны газраа бүртгүүлж гэрчилгээ авах үйл явцын тухай мэдээлэлгүй байсан ба зарим нь газар авах үйл явцад хүн бүрт эрх тэгш ханддаггүй гэж үзэж байв.

Манай ЗБУ, ХХЯ-н хэд хэдэн оролцогч сумын төвд орон сууцны зориулалтаар олгох газаргүй болсон учир зам гэх мэт дэд бүтэц дутмаг шинэ суурьшлын бүсэд газар олгож байгаа хэмээн дурьдсан юм. Мөн Даланжаргалан сумын төвд газар олгоход хотын ангилалд оруулан үзэж хөдөө өвөлжөөний газрын эзэмших гэрчилгээ олгодог 0.07 га шиг биш орон зөвхөн 0.05 га-аар өмчлөх гэрчилгээ өгч байгаа тухай дуулгасан юм.

Манай суурь судалгааны санамсаргүй түүврийн өрхийн 61% (45) Монгол орны хаа нэгтээ нэг ба нэгээс дээш орон сууцны газартай гэж мэдээлсэн ба энэ нь зөвхөн Даланжаргаланд байхгүй гэсэн үг. Гучин гурван өрх орон сууцны нэг газартай, 11 өрх хоёр газартай, нэг өрх 3 сууцны газартай ба 74 санамсаргүй түүврийн өрхийн нийт сууцны газрын тоо 58 болж байна.

Хүснэгт 14. Даланжаргалан сум, Санамсаргүй түүврийн өрхийн орон сууцны газрын өмчлөл/эзэмшил

	Орон сууцны газаргүй өрхийн тоо	1 орон сууцны газартай өрхийн тоо	2 орон сууцны газартай өрхийн тоо	3 орон сууцны газартай өрхийн тоо	Хариул аагүй	Санамсаргүй түүврийн нийт өрхийн эзэмшиж буй орон сууцны газрын тоо
Өрхийн тоо	28	33	11	1	1	58


Эх үүсвэр: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. N=93.

Манай суурь судалгааны санамсаргүй түүврийн өрхийн 53% (39) үндсэн амьдарч байгаа орон сууцны газар, хашаа, өвөлжөөгөө өрхийн гишүүд өмчилж эсхүл эзэмшдэг (өрхийн гишүүдийн ихэнх нь ихэвчлэн амьдардаг), 32% (24) үндсэн амьдарч байгаа орон сууцны газар, хашаа, өвөлжөөгөө зээлээр эсхүл мөнгө төлөхгүйгээр түрээсэлдэг гэжээ. Хүмүүс ихэвчлэн эцэг эх, ах дүү эсхүл хамаатан садангийн ихэвчлэн хашаа, өвөлжөөний газарт зээлээр амьдардаг байна. Санамсаргүй түүврийн үлдсэн 11 өрхөөс 6 нь үндсэн амьдарч байгаа газраа түрээсээр, 3 нь ажил олгогчоос үнэгүй өгсөн орон сууц эсхүл хашаа байшинд, үлдсэн 2 нь судалгаа явагдаж байх үеэр албан бус, түр зуурын суурьшлын газар амьдарч байв. Цомог багт (56%) өрхийн гишүүдийн ихэнх нь амьдардаг өмчлөх, эзэмших гэрчилгээтэй орон сууцны газрын ихэнх байсан ба Олон-Овоо багт (47%) хамгийн бага байв. Түрээсээр амьдарч байгаа өрхүүд Цомог багт гурав, Элдэв, Олон-Овоо, Өнгөт баг тус бүрт нэг нэг байв. Ажил олгогчоос өгсөн үнэгүй байранд амьдарч байгаа өрх Олон-Овоо багт хоёр, Цомог багт нэг байв. Бидний ажиглалтаар хоёр багын аль алинд өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүд ихэвчлэн ажил олгогчоос өгсөн сууцанд амьдарч байгаа харагдав. Мөн Монгол орны хаа нэгтээ нэг юмуу хоёр орон сууцны газартай гэж мэдээлсэн өрхүүдийн 6 нь тэр газар дээрээ амьдардаггүй харин бидний судалгааны үеэр үндсэн амьдарч байгаа сууцны газартаа түрээсээр юмуу зээлээр эсхүл ажил олгогчоос үнэгүй олгосон байранд амьдарч байв.

Бидний судалгаанд оролцсон өрхийн тэргүүний хүйсээс шалтгаалан үндсэн амьдарч байгаа газрынх нь эзэмшлийн ялгаа их байв. Үүнийг 12-р зураглалд харуулав. Өрх толгойлсон эмэгтэйтэй бүх өрхийн 53% (19), эрэгтэй тэргүүнтэй өрхийн зөвхөн 39% (17) бидний судалгааны үеэр үндсэн сууцны газартаа түрээсээр юмуу зээлээр амьдарч байв. Өрх толгойлсон эмэгтэйтэй

өрхийн 36% (13), эрэгтэй тэргүүнтэй өрхийн 58% (33) үндсэн сууцны газраа өмчилж юмуу эзэмшиж авсан байсан.

Зураглал 12. Даланжаргалан сум, Судалгаанд оролцсон бүх өрхийн үндсэн орон сууцны газрын эзэмшил



Эх үүсвэр: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Зураглалд зориудаар судалгаанд хамруулсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, санамсаргүй түүврийн өрхийн аль аль нь багтсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүвэр N = 36. Эрэгтэй тэргүүнтэй өрхийн түүвэр N = 57.

Үндсэн орон сууцны газар, хашаа эсхүл өвөлжөөний хувьд манай суурь судалгааны санамсаргүй түүврийн нийт 74 өрхийн 85% (63 өрх) нэг хүний өмчлөлттэй, 14% (10 өрх) хамтын өмчлөлттэй гэж мэдээлсэн ба (жишээ нь, гэрчилгээн дээр нэгээс илүү хүний нэр бичээстэй гэсэн үг) нэг өрх хариулаагүй байна. Бидний ажиглалтын хуудсан дээр бичсэнээр өрхийн амьдарч буй үндсэн сууцны газар нэг хүний өмч гэж хариулсан ч өрхийн эрэгтэй юмуу эмэгтэй тэргүүний аль альных нь нэр дээр биш байж болох ба харин ажил олгогч, хамаатных нь нэр дээр байж болно гэсэн үг. Гэхдээ нэг хүний нэр дээр гэж тэмдэглүүлсэн эрэгтэй тэргүүнтэй 5 өрхийн үндсэн орон сууцны газар эхнэрийнх нь нэр дээр бүртгэлтэй байв.

Бидний судалгаанд хамрагдсан бүх өрхийн үндсэн орон сууцны газрын хамгийн олон хамтын өмчлөлттэй өрх Олон-Овоо багт байсан ба санамсаргүй түүврийн өрхийн 26% (19 өрхийн 5) байв. Цомог багт хамтын өмчлөлттэй хамгийн олон өрх толгойлсон эмэгтэйтэй өрх ба байсан ба дараа нь Олон-Овоо баг орно. Үүнийг 15-р хүснэгтэд харуулав. Түүнчлэн Бичигт, Элдэв багын аль алинд нь хамтын өмчлөлийн орон сууцны газартай өрх байхгүй байсан ба Өнгөт багт нэг өрх байв.

Хүснэгт 15. Даланжаргалан сум, Судалгаанд хамрагдсан бүх өрхийн үндсэн орон сууцны газрын өмчлөлийн байдал

	Хамтын өмчлөлттэй орон сууцны газарт амьдарч буй		Ганц хүний өмчлөлттэй орон сууцны газарт амьдарч буй	
	Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн багт эзлэх хувь	Эрэгтэй тэргүүнтэй өрхийн багт эзлэх хувь	Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн багт эзлэх хувь	Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн багт эзлэх хувь
Бичигт	0%	0%	100%	100%
Элдэв	0%	0%	100%	100%
Олон-Овоо	25%	25%	75%	69%
Цомог	36%	17%	64%	83%
Өнгөт	0%	8%	100%	92%

Эх үүсвэр: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Зураглалд зориудаар судалгаанд хамруулсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, санамсаргүй түүврийн өрхийн аль аль нь багтсан. Бичигт багын өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүвэр N = 6. Бичигт багын эрэгтэй тэргүүнтэй өрхийн түүвэр N = 9. Элдэв багын өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүвэр N = 5. Элдэв багын эрэгтэй тэргүүнтэй өрхийн түүвэр N = 8. Олон-Овоо багын өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүвэр N = 8. Олон-Овоо багын эрэгтэй тэргүүнтэй өрхийн түүвэр N = 15. Цомог багын өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүвэр N = 11. Цомог багын эрэгтэй тэргүүнтэй өрхийн түүвэр N = 12. Өнгөт багын өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүвэр N = 6. Өнгөт багын эрэгтэй тэргүүнтэй өрхийн түүвэр N = 12. Олон-овоо багын нэг эрэгтэй тэргүүнтэй өрх хариулаагүй.

Дээрх бүх мэдээлэл Даланжаргалан сумын хөдөөгийн 3 багт эрэгтэй хүн өрхийн тэргүүн гэж үздэг уламжлал илүү хадгалагдсан (өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн хувьд хүүгээ өрхийн тэргүүн гэж үзэх талтай) бөгөөд өрхийн газрын эзэн байх ёстой гэж үздэг нь тод томруунаар харагдаж байна. Үлдсэн хоёр баг үүнээс ялгаатай, өрхийн тэргүүлэгч нь ихэвчлэн суманд сүүлд шилжиж ирсэн хүмүүс байдаг ба уламжлалт мал аж ахуйгаас илүүтэйгээр төрийн албан ажилаас илүү хамааралтай байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Манай суурь судалгааны санамсаргүй түүврийн өрхийн 34 нь зарим газрынхаа бичиг баримттай гэж мэдэгдсэн. Нийтдээ эдгээр өрхийн гишүүдэд 43 бичиг баримт байна гэж бүртгэгдсэн ба 16-р хүснэгтэд харуулав.

Хүснэгт 16. Даланжаргалан сум, Санамсаргүй түүврийн 74 өрхийн газрын бичиг баримтын төрөл

Бичиг баримтын төрөл	Орон сууц	Аж ахуй эрхлэх газар	Байшин	Хаваржаа	Хүнсний ногооны газар	Өвөлжөө	Нийт бичиг баримт
Өмчлөлийн гэрчилгээ	1	-	18	-	-	-	19
Эзэмшлийн гэрчилгээ	-	2	-	4	1	16	23
Ашиглах гэрчилгээ	-	-	-	-	1	-	1
Нийт бичиг баримтын тоо	1	2	18	4	2	16	43

Эх үүсвэр: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016.

16-р хүснэгтэд бичиг баримтын төрлүүдийг манай суурь судалгааны үеэр оролцогч нарын хэлснээр бүртгэсэн юм. Орон сууцны газрын хувьд өмчлөх гэрчилгээ, өвөлжөө, хаваржааны газрын хувьд эзэмших гэрчилгээ хамгийн түгээмэл байв. Хүнсний ногооны газрын хувьд зөвхөн нэг албан ёсны ашиглах гэрчилгээ, аж ахуйн зориулалттай газрын хоёр гэрчилгээ, нэг өрх орон сууцны байрны өмчлөх гэрчилгээтэй байв. Бидэнд хувийн газар худалдан авалт эсхүл түрээсийн ямар нэгэн бичиг баримт бүртгэгдээгүй ба албан бус газрын бичиг баримт мөн бүртгэгдээгүй юм. Энэ нь бидний 2016 оны ажлын үеэр Даланжаргалан суманд газрын зах зээл хязгаарлагдмал байгааг харуулж байгаа ба манай ЗБУ, ХХЯ-н үр дүнгээр батлагдаж байгаа юм.

Өвөлжөө, хаваржааны газар

Сумын захиргаанаас бидэнд хэлснээр өвөлжөө, хаваржааны эзэмших гэрчилгээг 2008 оноос хойш 15 жилийн хугацаатай малчдад олгож эхэлсэн бөгөөд 2013 он гэхэд ихэнх айл үе удам дамжин амьдарч ирсэн газрынхаа гэрчилгээг авсан гэв. Малчин өрх бүр нэг өвөлжөөний газар, нэг хаваржааны газар авах эрхтэй ба салангид амьдрахын тулд сумын төвд хашааны газар бас авах эрхтэй байв. Гэхдээ суманд цөөн тооны газар үлдсэн учир гэсэн шалтгаанаар 2010 аад оны эхээр Даланжаргалан суманд нүүж ирсэн хүмүүс газрын эзэмших гэрчилгээгээ хараахан аваагүй байгаа.

Даланжаргалан суманд уламжлалт эдэлбэрийн эрхтэй байсан учир өрхүүдэд өвөлжөө, хаваржааны газрын эзэмших гэрчилгээг кадастрийн зураг хийлгүүлэлгүйгээр олгосон. Манай ЗБУ, ХХЯ-н оролцогчид сумын хүмүүс нэг нэгнээ сайн мэддэг, хэн ямар өвөлжөөнд хэдий хугацаагаар амьдарч байгаа гэдгийг мэддэг байсан ба ингэж уламжлалт эрх үүссэн хэмээн тайлбарласан. Энгийн иргэд, сумын захиргааны аль аль нь зарим малчин өвөлжөөгөө социализмын үеэс ч өмнө ашиглаж байсан гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Социализм нуран унасны дараа зарим малчинд дөрөв таван газрын өвөлжөө, хаваржааны газар байсан ба зарим айл өрх гишүүдийнхээ нэр тус бүр дээр тэр бүх газартаа эзэмших гэрчилгээ авсан байна. Гэхдээ 2013 онд батлагдсан орон нутгийн журмын дагуу Даланжаргалан сумын багын дарга нар гурван жил дараалан ашиглаагүй өвөлжөөний эзэмших эрхийг цуцлах эрхтэй болсон гэдгийг бид мэдсэн. Манай зарим ЗБУ, ХХЯ-н оролцогч энэхүү өөрчлөлтийн талаар олж мэдээгүй байсны үршгаар өвөг дээдсийнхээ ашиглаж байсан өвөлжөөний газрыг алдахад хүрсэн байна. Гэхдээ олон өвөлжөөтэй эсхүл удаан хугацаагаар өвөлжөөнөөсөө хол байсан цөөн хэдэн хүн ийм байдалд хүрсэн бололтой.

Орон сууцны газар буюу хашааны газар авахаас илүү өвөлжөө, хаваржааны газар авах үйл явц хүндрэлтэй. Малчид багын засаг даргаас эхлээд уламжлалт эрхээ бататгаж тодорхойлолт/зөвшөөрөл авах хэрэгтэй болдог. Дараа нь багын иргэдийн хурал өргөдөл гаргасан газар сумын кадастрийн зураглалд орж эзэмших гэрчилгээ авсан бусад газартай давхцаж байгаа эсэхийг шалгасны дараа зөвшөөрөл олгоно. Дараа нь малчид өргөдлөө сумын газрын даамалд өгнө. Өргөдлийг сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсны дараа сум, багын зөвшөөрлийн хамт өргөдлийг аймгийн газрын албанд малчин өөрөө аваачиж өгнө. Аймгийн түвшинд баталж суманд буцаж мэдэгдсэний дараа малчин сумын газрын даамлаас албан ёсны бичиг баримт, гэрчилгээгээ авах боломжтой болдог.

Манай ЗБУ, ХХЯ-н оролцогчид дээрх үйл явц ихэнхдээ сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал дээр ирээд гацаж уддаг, иргэдийн төлөөлөгчдийн хурал гурван сард нэг, хоёр удаа хуралддаг гэсэн юм. Энэ үйл явцыг дамжихын тулд хэдэн жил болж байгаа цөөн тохиолдлын тухай оролцогчид ярьсан юм. Мөн заавар, мэдээлэл дутмаг байдаг учир малчид илүүтэйгээр энэхүү үйл явцыг түвэг ихтэй, удаан гэж хэлж байв. Жишээ нь, хол амьдардаг малчид сумын захиргааны ажилтнуудтай багын засаг даргатайгаа харьцдаг шигээ тийм ч дотно биш, тэдэнтэй бага үулздаг учир өргөдлөө албан бусаар хөөцөлдөхөд бэрхшээлтэй байдаг байна. Зарим малчин газар нь өөр хүний албан ёсны эзэмших гэрчилгээ авчихсан газартай давхцаж байгааг мэдээгүйн улмаас удаан хүлээсэн байх жишээтэй. Ихэнх малчин багын засаг даргатайгаа сайн харилцаатай байдаг бололтой ч малчид өөр хоорондоо алслагдмал байдаг, завгүй ажилтай учир багын засаг дарга нар өргөдлийн талаарх мэдээллийг тэдэнтэй үргэлж хуваалцахгүй байх нь олонтаа. Зарим малчин сумын төвд ажиллаж, амьдардаг багын төв дээр байдаггүй багын засаг даргатай харилцахад хэцүү байдаг тухай ярьсан ч багын засаг дарга нар сумын төсвөөс хуваарилдаг түлшний зардлын төсөв хангалтгүй учир алс хол амьдарч байгаа малчидтай үулзах боломжгүй байдаг тухай хэлсэн юм. Хол амьдарч байгаа малчид мөн өргөдлийнхөө араас явах цаг хугацаа, түлшний зардал гэсэн том асуудалтай тулгардаг, ялангуяа өвлийн цагаар явдал суудал хийхэд улам хэцүү байдаг. Дээрх бүх асуудал өрх толгойлсон эмэгтэйтэй малчин өрхийн хувьд улам хүнд байдаг ба энэ тухай доор өгүүлнэ.

Газар тариалан, бизнесийн зориулалттай газар

Манай суурь судалгааны санамсаргүй түүврийн өрхийн 15% (11) Даланжаргалан суманд орон сууцны бус газрын өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй гэж мэдэгдсэн. Эдгээр өрхийн есийнх нь газар (11 өрхийн 82%) тэдний өөрсдийн амьдарч байгаа багт байрладаг, нэг өрхийнх өөр багт байрладаг, бас нэгэн өрх газраа хаана байдгыг хэлээгүй. Орон сууцны бус газартай өрхийн 64 % (11 өрхийн 7 нь) төр захиргааны байгууллагад хүсэлт гаргаж газраа авсан, хоёр өрх худалдаж авсан, нэг өрх өвлөж авсан ба үлдсэн нэг өрх хэрхэн газар олж авснаа бүртгүүлээгүй.


Манай суурь судалгааны санамсаргүй түүврийн орон сууцны бус газартай 11 өрхийн 8 нь дээр дэлгэрэнгүй үзүүлсэнчлэн газар тариалангийн газартай гэж бүртгүүлсэн байв. Үлдсэн өрхүүд орон сууцны бус газар дээрээ бидний судалгаа хийх үед тариа тариагүй байсан ба эдгээр өрхийн доор хаяж хоёрынх нь газар аж ахуйн нэгжийн зориулалттай байсан. Энэ 3 өрхийн нийт орон сууцны бус газрын хэмжээ 214 га байгаа нь тариалангийн газартай 8 өрхийн нийт 3.75 га-тай харьцуулахад харьцангуй их байна.

Зөвхөн Олон-Овоо багт манай ЗБУ-ын оролцогчид худалдааны болон бизнес хийх зориулалттай газар олж авах тухай асуудлыг хөндсөн. Тэд зөвхөн сумын газрын даамал тодорхой газрыг тендер зарлаж худалдахаар зарласан тохиолдолд л аж ахуйн нэгжийн зориулалттай газар авах боломжтой байдаг гэж хэлсэн. Тендерийн ялагчид газрын гэрчилгээгээ батлуулахын тулд аймгийн газрын албанд бичиг хүргүүлдэг байна. Гэсэн хэдий ч тендерийн ялагч ямар нэгэн бизнесийн үйл ажиллагаа явуулаагүй эсхүл газар дээр ямар нэгэн үл хөдлөх хөрөнгө бариагүй бол эзэмших гэрчилгээг хүчингүй болгодог.

Газрын маргаан

Манай суурь судалгааны санамсаргүй түүврийн өрхийн 9 нь сүүлийн 12 сарын хугацаанд газар эсхүл хөрөнгөтэй холбоотой маргаанд оролцсон хэмээсэн ба үүний 2 нь өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, 7 нь эрэгтэй тэргүүнтэй өрх байв. Энэ нь санамсаргүй түүврийн өрхийн 12 %, мөн өрх толгойлсон эмэгтэйтэй өрх болон эрэгтэй тэргүүнтэй нийт өрхийн тус тус 12% болж байгаа юм. Маргаанд оролцсон өрхийн 3 нь эрэгтэй тэргүүнтэй байсан ба дээр өгүүлж байсанчлан уул уурхайн компаниудтай маргалдсан тохиолдол Өнгөт, Олон-Овоо, Бичигт багт тус бүр нэг байв. 13-р зураглалд гарсан маргааны бүх төрлийг харуулав.

Зураглал 13. Даланжаргалан сүм, Санамсаргүй түүврийн өрхийн гарсан маргааны хэлбэр



Эх үүсвэр: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. N = 9.

Манай ЗБУ, ХХЯ-ийн оролцогчдын мэдээлснээр бэлчээрийн талхагдал, усны нөөц багассантай холбоотой газрын маргаан түгээмэл байсан бөгөөд доор дэлгэрэнгүй үзнэ. Мөн газрын гэрчилгээ авах, газар олгох үйл явцтай холбоотой маргаан их байсан. Мөн Их Нартын нөөц газартай холбоотой маргаан гарсан тухай доор товч өгүүлнэ.

Монгол орны өөр бусад хэсэгтэй харьцуулахад Даланжаргалан суманд гарсан маргаанууд хүч хэрэглээгүй, хүмүүс ч газар болон байгалийн нөөцийн талаарх маргаан зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай тулгамдсан асуудлуудын нэг гэж үздэггүй болох нь харагдсан. Учир нь бэлчээрийн талхагдал олон хүний санааг зовниулж байгаа ч сумын ерөнхий бэлчээр тийм ч муудаагүй учир нутгийн хүмүүс маргаан гарахад тайван хандаж, ширүүлхэдэггүй гэж хүмүүс хэлсэн юм.

Гэхдээ нутгийн иргэдийн түвшинд маргаан шийдвэрлэдэг сайн механизм дутмаг байгаа нь харагдсан. Ихэнх асуудлуудыг өрх айлууд хоорондоо ярьж шийддэг байна. 17-р хүснэгтэд харуулсанчлан манай суурь судалгааны бүх эмэгтэй хариулагчийн 43% (54 хүний 23), эрэгтэй хариулагчийн 38% (39-хүний 15) уурхайчид болон нутгийн иргэдийн хоорондын маргаан энэ нутагт асуудал болж байгаа гэж үзсэн бол цөөн хэдэн хүн хөрөнгө оруулагчид, тариаланчдын хооронд маргаан гарч байгаа нь асуудал болж байна гэж үзсэн. Гэхдээ 17-р хүснэгтэд хүмүүс газар, байгалийн нөөцийн маргааныг шийдвэрлэх орон нутгийн шүүх системд итгэх итгэл мүү байгааг харуулж байна. Эрэгтэй, эмэгтэй хариулагчдын хагас нь шийдвэрлүүлэх амаргүй байдаг гэж хариулсан байна.

Хүснэгт 17. Даланжаргалан сум, Орон нутаг дахь байгалийн нөөцийн маргааны талаарх ойлголт, хүйсээр

	Тийм (жендерээр ялгасан хувь)		Үгүй (жендерээр ялгасан хувь)		Мэдэхгүй (жендерээр ялгасан хувь)	
	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр
Танай энд уурхайчид болон нутгийн хүмүүсийн хоорондын маргаан асуудал биш.	28	36	43	38	30	26
Танай энд хөрөнгө оруулагчид, нутгийн хүмүүсийн хоорондын маргаан асуудал биш.	26	26	26	26	48	49
Танай энд газар тариаланчид болон малчдын хоорондын маргаан асуудал биш.	26	26	24	15	50	59
Танай нутагт газар болон байгалийн нөөцийн талаарх маргааныг зөвөөр шийдвэрлүүлэхэд амаргүй.	50	49	13	18	37	33

Эх үүсвэр: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Хүснэгтэд зориудаар нэмэлт судалгаа авсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, санамсаргүй түүврийн өрхийн аль аль нь багтсан. Эмэгтэй хариулагчдын түүврийн хэмжээ N = 54. Эрэгтэй хариулагчдын түүврийн хэмжээ N = 39.

Их Нартын байгалийн нөөц газар

Их Нартын байгалийн нөөц газар 1996 онд орон нутгийн тусгай хамгаалалттай газрын статустайгаар байгуулагдсан бөгөөд нийт 66, 000 га –г хамардаг. Нөөц газрын ойролцоогоор 60% нь Даланжаргалан сумын нутагт оршдог, Бичигт суманд 40,000 гаруй га буюу багын нийт газар нутгийн гуравны нэгийг хамардаг бөгөөд үлдсэн хэсэг нь Айраг сумын нутагт байдаг. Манай ЗБУ, ХХЯ-н зарим оролцогч Их Нартад өвөлжөөтэй гэж бидэнд хэлсэн бөгөөд цаашид хэдэн үеэрээ амьдарч ирсэн өвөлжөөгөө хадгалж үлдэнэ гэдэгтээ итгэлгүй байсан. Гэхдээ малчид хамгаалалттай газар дотор өвөлжөө, хаваржааны газар эзэмших гэрчилгээ авах эрхгүй ч улсын хуулийн дагуу Их Нартад амьдралаа үргэлжлүүлэн малаа хариулж, өвөлжөөгөө ашиглах эрхтэй хэвээр байна.

Их Нартын байгалийн нөөц газарт Бичигт багын малчдын байгаль хамгаалах хэд хэдэн нөхөрлөл байдаг бөгөөд нөөц газрын хамгаалалтын захиргаа ямар нэгэн асуудал гарахад малчидтай хамтдаа хэлэлцдэг бололтой байсан. Манай ЗБУ, ХХЯ-н оролцогчид 2010 оноос эхлэн НҮБ-ын “Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх нь” (СПАН) төслийн дэмжлэгтэйгээр 4 нөхөрлөл байгуулагдсан гэдгийг хэлж байв. Бидний 2016 оны ажлын үеэр СПАН төсөл дуусч байсан. Төслийн зүгээс нөөц газрын аялал жуулчлалын үйл ажиллагааг эхлүүлэхэд мөн дэмжлэг үзүүлсэн байлаа. Нөхөрлөлийн гишүүд ихэвчлэн эмэгтэйчүүд байдаг ба одоог хүртэл идэвхтэй ажиллаж, хамгаалалтын захиргаатай ойр ажилладаг гэж бидэнд хэлсэн юм. Хамгаалалтын захиргаанаас нөхөрлөлийн гишүүдийг олон янзын сургалтад хамруулдаг. Үүний нэг нь эмэгтэйчүүдийн манлайллын сургалт юм. Мөн Хил Хязгааргүй Алхам Монголын ТББ-аас Их нартн нөхөрлөлүүдийн зарим эмэгтэйтэй хамтран ажилласан. Айраг суманд 10 өрхийн бүрэлдэхүүнтэй нэг нөхөрлөл байгуулагдсан. Мөн нэг нь уул уурхайн нөхөн сэргээлт хийх, нөгөө нь ногоо тарих чиглэлээр 7 болон 11 өрхтэй хоёр нөхөрлөл Бичигт багт байгуулагдсан. Дөрөв дэхь нөхөрлөл Бичигт багын зөвхөн эмэгтэйчүүдийн бүлэг байсан. Бүх нөхөрлөл орон нутгийн байгаль хамгаалах янз бүрийн асуудлын хүрээнд гол үйл ажиллагаагаа төвлөрүүлэхээс гадна Их Нартад зундаа зочилдог жуулчдад худалдах зорилгоор эсгий эдлэл хийж бага хэмжээгээр орлого нэмэгдүүлэх ажиллагаа явуулдаг байна.

Бэлчээрийн менежмент

Амьжиргааны тухай хэсэг дээр өгүүлсэнчлэн манай суурь судалгааны санамсаргүй түүврийн өрхийн зөвхөн 26% судалгааны өмнөх сүүлийн 12 сарын хугацаанд мал аж ахуйгаас хамгийн их мөнгөн орлого олсон хэмээсэн. Гэтэл манай суурь судалгааны бүх эмэгтэй хариулагчийн 80% (43), бүх эрэгтэй хариулагчийн 85% (33) “Энэ нутгийн ихэнх хүмүүсийн амьжиргаа мал аж

ахуйгаас хамаардаг” гэсэн мэдэгдэлтэй санал нийлсэн байх юм. Үүнийг 18-р хүснэгтэд харуулав. Үүнийг сумын хэмжээнд мал маллах нь олон хүний хувьд маш хүчтэй соёлын чиг баримжааны нэг хэсэг болж байна гэсэн байдлаар тайлбарлаж болох юм. Иймд бэлчээргүйдэх, бэлчээрийн талхагдал сэтгэл зовоосон гол асуудал байсан. Бүх эмэгтэй хариулагчийн 59% (32), бүх эрэгтэй хариулагчийн 67% (26) “танай нутагт бэлчээрийн газар олж авах явдал асуудал дагуулж байна” гэсэн мэдэгдэлтэй санал нийлсэн юм.

Хүснэгт 18. Даланжаргалан сум, Бэлчээрийн мал аж ахуйн тухай ойлголт, хүйсээр


	Тийм (жендерээр ялгасан хувь)		Үгүй (жендерээр ялгасан хувь)		Мэдэхгүй (жендерээр ялгасан хувь)	
	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр
Энэ нутгийн хүмүүсийн ихэнхийн амьжиргаа мал аж ахуйгаас хамаардаг.	80	85	9	5	11	10
Танай нутагт бэлчээрийн газар тойрсон асуудал их байна.	59	67	9	23	31	10
Танай нутагт усны хүртээмжийн талаар асуудал их байна.	59	64	35	26	6	10

Эх үүсвэр: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Хүснэгтэд зориудаар нэмэлт судалгаа авсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, санамсаргүй түүврийн өрхийн аль аль нь багтсан. Эмэгтэй хариулагчдын түүврийн хэмжээ N = 54. Эрэгтэй хариулагчдын түүврийн хэмжээ N = 39.

Үүний адилаар 18-р хүснэгтэд үзүүлсэнчлэн усны хүртээмжийн асуудал Даланжаргалангийн хүмүүсийн сэтгэлийг зовоож байна. манай суурь судалгааны бүх эмэгтэй хариулагчийн 59% (32), бүх эрэгтэй хариулагчийн 64% (25) “Танай нутагт усны нөөцийн хүртээмжийн асуудал их байна” гэсэн мэдэгдэлтэй санал нийлсэн бана. Манай 2016 оны ажлын үеэр нутгийн малчдын хувьд усны эрхийн асуудал ихсэж байгаа, уул уурхайтай холбоотой усны хомсдол, бохирдлын асуудал их сөхөгдөж байгаа тухай дээр өгүүлсэн билээ. Мөн дээр үзүүлсэнчлэн зарим малчид хувийн худаг барьж эхэлсэн бөгөөд бусад хүмүүст төлбөртэйгээр өгдөг эсхүл бүр өгдөггүй гэсэн мэдээ байна. Мөн зарим газарт 20 хүртэлх өрх айлууд нэг нийтийн худгаас усаа авч байгаа учир маргаан их гардаг, малчдын ажлын ачааллыг нэмэгдүүлдэг байна. Хэдэн мянган малыг услах ажил нь цаг их зарцуулдаг, хүч их шаарддаг хянуур хийх ажил гэж бидэнд хэлсэн. Манай ЗБУ, ХХЯ-н оролцогчид мөн ийм худгийн ойролцоох бэлчээр их талхагддаг гэсэн юм. Усны нөөц нь нийтийн өмч хэвээр байгаа дүрэм, журам тодорхойгүй байдаг бололтой. Жишээ нь хэн нэгэн хүн нийтийн худгийг засаж янзлаад уламжлалт ёсыг зөрчин нийтэд ашиглуулахгүй цоожилчихож болж байгаа юм. Энэ нь малчдыг өөр газар хол нүүх аргагүйд хүргэж байгаа бололтой. Бэлчээрийн талхагдал, усны хомсдолд нөлөөлж буй гол хүчин зүйл бол уул уурхай юм гэж нийтээр үздэг байна. Том болон жижиг хэмжээний уул уурхайн аль аль нь малчдын амьжиргаанд янз бүрийн нөлөө үзүүлж байгаа бөгөөд уул уурхайн үүсгэсэн газар болон усны хомсдол, байгаль орчны доройтол нь малчдын хоорондын өвөлжөө, хаваржааны зөрчил үүсэх, уламжлалт нүүдлийн мал аж ахуйн нүүдлийн хэв маягыг өөрчлөх хувь нэмэр оруулж байна гэж хүмүүс үздэг байна. Энэ тухай үзье.

Манай суурь судалгааны мэдээллүүдээс дээрх хандлагуудыг баталж болно. Дараах 14-р зураглалд бүх өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн зөвхөн 28% (10), бүх эрэгтэй тэргүүнтэй өрхийн 49% (28) өөрсдөө малаа маллаж, бэлчээрлүүлдэг гэсэн байхад бүх өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн 19% (7), бүх эрэгтэй тэргүүнтэй өрхийн 11% (6) хамаатныдаа юмуу туслах малчин (төлбөрийг бэлэн мөнгөөр эсхүл өөр тохиролцоогоор) зэрэг бусдад малаа өгдөг гэсэн байна.

Зураглал 14. Даланжаргалан сум, Эмэгтэй (зүүн) эрэгтэй (баруун) тэргүүнтэй өрхийн мал бэлчээх хэв маяг



Эх үүсвэр: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Зураглалд зориудаар судалгаанд хамруулсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, санамсаргүй түүврийн өрхийн аль аль нь багтсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүвэр N = 36. Эрэгтэй тэргүүнтэй өрхийн түүвэр N = 57.


Өрх толгойлсон эмэгтэйтэй өрх малаа бэлчээхдээ харьцангуй илүүтэйгээр бусдаас тус авдаг байна. Гэхдээ зарим нь төвд амьдардаг мал бүхий иргэд байж болох ч манай суурь судалгаагаар малаа бусдад өгч маллуулж байгаа өрхүүд бүх 5 багт адил байгаа юм.

Манай мэдээллийн дагуу өрх толгойлсон эмэгтэйтэй өрх малаа маллах чадал багатай байдаг нь хөдөлмөр хүнд эсхүл бэлчээр олж авч чадахгүйд хүрдэгтэй холбоотой байна.

Гэхдээ илүү чухал зүйл нь манай суурь судалгааны санамсаргүй түүврийн өрхийн 43% (32) мал малладаггүй (малгүй) гэсэн байна. Санамсаргүй түүврийн өрхийн 52% (39) хэн ч ашиглаж болох нийтийн бэлчээр ашигладаг бөгөөд эрэгтэй тэргүүнтэй хоёр өрх орон сууцныхаа газрын ойролцоох газрыг бэлчээр болгож ашигладаг ба энэ газарт хувийн тусгай эрхтэй гэсэн байх юм. Гэхдээ бид ЗБУ, ХХЯ-аар энэ тухай илүү мэдээлэл авч чадаагүй бөгөөд суурь судалгааны үеэр гарсан алдаа бололтой байсан юм. Санамсаргүй түүврийн өрхөөс ингэж хариулсан өөр өрх байгаагүй.

Өрх толгойлсон эмэгтэйтэй бүх өрхийн 50% (18), эрэгтэй тэргүүнтэй бүх өрхийн 40% (23) ямар нэгэн мал малладаггүй гэж хариулсныг дараах 15-р зураглалд тодорхой харж болно. Түүнчлэн ахимаг насны тэргүүнтэй өрх илүүтэйгээр нийтийн бэлчээр ашиглаж, бусдаар малаа маллуулж байгаа нь харагдсан. Харин хөдөлмөрийн насны тэргүүнтэй өрх мал маллахгүй байх нь элбэг байна.

Зураглал 15. Даланжаргалан сум, судалгаанд хамрагдсан бүх өрхийн малаа бэлчээх арга хэлбэр



Эх үүсвэр: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Зураглалд зориудаар судалгаанд хамруулсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, санамсаргүй түүврийн өрхийн аль аль нь багтсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүвэр N = 36. Эрэгтэй тэргүүнтэй өрхийн түүвэр N = 57.

Отор нүүдэл ба нүүдлийн хэв маягын өөрчлөлт

Даланжаргалан суманд социализмын үед (түүнээс ч өмнө) олон малчид гэр бүлээрээ 3 удаа улирлын нүүдэл хийдэг байсан бол өнөө үед малчдын нүүдэл хаваржаа/зуншилгаа, өвөлжөөний хооронд болсон байна. Зарим хүмүүс малаа хамаатандаа өгч маллуулдаг мал бүхий иргэн болж хувирсан байна. Отор нүүдэл урьдын цагыг бодвол нийтлэг биш болжээ. Хаваржаа, зуншилгааны газар нэг болсон учир улирлын нүүдэл багасч нутгийн малчид тусдаа хаваржааны газаргүй болсон байна.

Олон малчид өвөлжөөний газрынхаа эзэмших гэрчилгээг авсан гэж бүртгүүлсэн ч манай ЗБУ, ХХЯ-ийн үеэр малчид өвөлжөөгөө уул уурхайн компанид алдахаас айдаг эсхүл өөр сумын малчдын мал өвөлжөөнийх нь бэлчээрийг идэхээс айдаг учир нүүх сонирхолгүй болсон гэж бидний ярилцсан олон малчид хэлсэн юм. Бүр зарим малчин бороо сайтай жил хаашаа ч нүүлгүй өвөлжөөндөө байдаг. Бусад сумын малчдаас өвөлжөөнийхөө бэлчээрийг хамгаалах хэрэгтэй байдаг, харин уур амьсгалын өөрчлөлт, уул уурхайгаас болж тэдний, хаваржаа зуншилгааны бэлчээр талхагдаж байна гэж гомдол мэдүүлсэн юм. Мөн Говьд мод хомс, өвөлжөөний модон хашаа саравч үнэ цэнэтэй материал учир малчид тэднийг нүүсэн хойгуур бусдад алдах эрсдэлтэй байдаг байна.

Манай ЗБУ, ХХЯ-н оролцогчид сүүлийн жилүүдэд нүүх зай мөн багассан гэсэн. Бид зарим ахмад малчдаас тэдний үед бэлчээрийн сайныг хайж 100 гаруй км нүүдэллэдэг байсан тухай сонссон юм. Гэхдээ энэ бол улсаа унаа тэргээр хангадаг байсан социализмын үе байлаа. Одоо малчид өвөлжөөнөөсөө 5-15 км зайд нүүдэг болсон. Олон хүмүүс энэ нь бэлчээрийн талхагдалаас сэргийлэхэд хангалтгүй гэж үздэг. Хуурай болон хагас хуурай газрын өвс ургамлыг нөхөн сэргээхийн тулд үүнээс илүү хол нүүх шаардлагатай.

Манай ЗБУ, ХХЯ-н оролцогчдын хэлснээр өрхийн нүүдэл суудал хийх шийдвэрийг өрхийн гишүүд ярилцаж гаргадаг боловч малаа хариулдаг учир эрэгтэй хүн голлож шийдвэр гаргадаг. Хэрэв малчин өрх өвөлжөөнөөсөө хол нүүхээр бол гурваас дөрвөн өрх хамтдаа нүүдэг, гэхдээ бас дангаараа ч нүүж болдог. Мөн бидэнд социализмаас хойш улирлын юмуу бэлчээр сэлгэх отор нүүдлийн талаар дүрэм журам байхгүй болсон гэсэн юм. Бидний 2016 оны ажлын үеэр Говьсүмбэр, Айраг, Бор-Өндөр зэрэг хөрш зэргэлдээх сумдын малчид Даланжаргалан суманд ирж тэдний бага хэмжээний отрын бэлчээрийг ашигладаг гэж олон хүмүүс хэлсэн юм. Заримдаа зэргэлдээх сумын малчид Даланжаргалангаар зөвхөн дайран өнгөрдөг ч мал нь бэлчээр идээд л явдаг. Энэ явдлыг зогсоох үүднээс албан ёсны арга хэмжээ авсан ч бүтээгүй бөгөөд холбогдох сумдын захиргаанаас сумдын хилийн дагуух малчдын нүүдлийг зохицуулах илүү их ажил хийх хэрэгтэй мэт санагдсан.

Баруун аймгийн малчид хүртэл сүүлийн жилүүдэд хүнд хэцүү нөхцөлөөс зугатаан Даланжаргалан суманд отороор ирдэг гэж яригдсан бөгөөд зарим нь Даланжаргаланд суурьшиж нутгийн бэлчээрийн хомсдлыг улам бүр ихэсгэж байна. Бидэнд хэлснээр орон нутгийн малчдын санаа зовниж буй бас нэгэн томоохон асуудал бол дайран өнгөрч байгаа малын өвчин халдах эрсдэл юм. Жишээ нь, хөрш зэргэлдээх сумдад малын шүлхий өвчин гарсан байсан.

Манай ЗБУ, ХХЯ-н оролцогчид 2015 онд эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд Даланжаргалан сумын засаг дарга бэлчээр ашиглалтын тухай шийдвэр гаргасан. Үүнд бусад сум, багаас Даланжаргалан сумын бэлчээрийг ашиглах зорилгоор ирж буй хүмүүсийн жижиг малд нэг сарын 5000 төгрөг, том малд 2500 төгрөгний бэлчээрийн татвар төлөхийг шаардсан юм. Энэ шийдвэрийн үрээр хэн ч татвар төлөхийг хүсээгүй учир өөр тийш нүүцгээж зэргэлдээх сумдын малчидтай хийх маргааныг бууруулахад дөхөм болсон гэж хүмүүс үздэг.

Мөн сүүлийн арав гаруй жил санхүү, хүн хүчний боломжтой малчид бэлчээрээ хамгаалж, нөөцөлж авахын тулд өвөл эхлэхэд өвөлжөөнийхөө ойр орчим томоохон газарт нүүдлийн

хашаа хатгадаг болсон тухай бидэнд хэлсэн юм. Гэхдээ бид энэ тухай ямар нэгэн орон нутгийн дүрэм, журам байгаа эсэхийг мэдэж чадаагүй юм.

Нөгөө талаар сүүлийн жилүүдэд бусад малчдын нүүдэл оторын бүс, өвөлжөөний бэлчээрийг нь ашиглахыг үзсэн Даланжаргалан сумын малчид өөрсдөө зэргэлдээх сумд руу нүүж шинэ бэлчээр хайх болсон байна. Мөн хаваржааны газрын эзэмших гэрчилгээгүй зарим малчид бусад сумд руу оторт явдаг, ингэхдээ нүүдлийн вагончик дотор амьдардаг, тэгээд өөр сумдын малчдад ихэвчлэн хөөгддөг гэж бидэнд хүмүүс ярьсан юм. Улмаар манай нэг ЗБУ-н оролцогчдын хэлснээр Даланжаргалан сумын зарим малчид нэг мөсөн нүүж өөр сумын хамаатныдаа амьдрах болсон гэсэн юм. Харин зарим нь өөр сумын бэлчээрийг ашиглах боломжтой болохын тулд “хуурамч” салалт үйлддэг тухай бид дээр үзсэн билээ.

Улирлын нүүдлийн хэв маягт гарсан эдгээр өөрчлөлт нь эдэлбэрийн эрхийг албан ёсны болгосноос гарсан шууд үр дагавар гэж үзэж болохоор байна. Учир нь малчид бууцныхаа гэрчилгээтэй болсноор эрхээ хамгаалахын тулд ойролцоох бэлчээртээ байж байх ёстой гэсэн бодолтой болсон. Манай ЗБУ, ХХЯ-н оролцогчдын хэлснээр 2008 оноос хойш малчдын хоорондын маргаан илүү түгээмэл болсон бөгөөд дээр өгүүлсэнчлэн энэ үеэр газар олгох, гэрчилгээжүүлэх ажил эхэлсэн юм. Хуулийн дагуу эзэмших гэрчилгээ авсан малчид өвөлжөө, хаваржааны бууцныхаа 500 метрийн радиус доторх хүртэлх бэлчээрийг ашиглах зөвшөөрөлтэй юм. Гэхдээ малчдын хоорондын маргаан нь нэг малчин өрх нөгөө малчин өрхийнхөө өвөлжөөний бууцны бэлчээрийн талбайд өвөлжөөгөө барьсан тохиолдолд ихэвчлэн үүсдэг. Мөн сумын захиргаанаас оторын бүсэд эзэмших гэрчилгээ олгохгүй шийдвэр гаргасан байтал зарим малчид отрын бүсэд өвөлжөө барьсан учир маргаан гардаг тухай бидэнд ярьсан юм. Зарим малчид тэнд барьсан өвөлжөөнийхөө газарт гэрчилгээ авахыг оролддог гэж бас хэлсэн юм.

Бэлчээрийн газрын маргаан түгээмэл болсон бололтой бөгөөд зарим тохиолдолд хэд хэдэн өрх айл нэг өвөлжөөний газрыг булаацалддаг байна. Манай ЗБУ, ХХЯ-н оролцогчид малчид өнөө үед хувийн өмч гэсэн утгаараа бэлчээрээ хувааж эзэмших сонирхолгүй болсон гэв. Түүнчлэн дээр өгүүлсэнчлэн маргаан шийдвэрлэх механизм хязгаарлагдмал бөгөөд хүмүүс өөр хоорондо зохицох эсхүл багын даргаас тусламж хүсдэг байна. Эдгээр бэрхшээлтэй байдал нь эрэгтэй хүн давамгайлсан малчдын орчин тойронд өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийг ойшоож үздэггүй тул тэдэнд илүү хүндээр тусдаг байна.

Эмэгтэй малчид, эмзэг бүлгийн хүмүүст учирч буй бэрхшээл

Бидний судалгааны туршид ажигласны дагуу Даланжаргалан сумын уламжлалт мал аж ахуйтай холбоотой эмэгтэйчүүдийн өмнө онцгой бэрхшээлүүд тулгарч байдаг. Хэдийгээр бидэнд туслах эрэгтэй хүнгүй эмэгтэйчүүд бэлчээрээс юмүү үс авахаас хөөгдсөн баримт олдоогүй ч өрх толгойлсон эмэгтэйтэй малчин өрхүүдийн амьдрал олон янзаар хэцүү байгааг харсан. Тэдний амьдрал эрэгтэй тэргүүнтэй малчин өрхүүдтэй харьцуулахад илүү ядуувтар байна. Жишээ нь тэдэнд мөнгөн аяга, морь цөөхөн байдаг ба ерөөсөө мал маллах нь ховор болсон. Мөн өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн сумын төв дээрх амьдрал амаргүй ялангуяа урьд нь малчин байсан бол тийм байдлыг бид харсан юм.

Гэхдээ бидний 2016 оны ажлын үеэр ажиглагдсан бүрэн зураглал бол жендерийн харилцааны цогц асуудлууд байсан ба эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн өмнө тулгамдаж буй маш олон янзын нөхцөл байдал үүссэн бөгөөд хамгийн эмзэг бүлгийг тодорхойлоход хэцүү байсан. Хөдөөгийн өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн амьдрал маш эмзэг байна. Жишээ нь тэд бэлэвсэрч хоцорвол мал маллах ажлаа үргэлжлүүлэхэд хүндрэлтэй болдог ба ядуурал, эдэлбэрийн баталгаагүй байдалд орох эрсдэлтэй байдаг. Гэхдээ салангид амьдарч байгаа өрхүүдийн өвлийн түрш хөдөө ганцаараа амьдарч нөхрүүдийг мөн боломжит эмзэг бүлэг гэж авч үзэх ёстой ба тэд эхнэр, хүүхдээсээ удаан хугацаагаар хол амьдарч гэрийн ажлаа амжуулахаас гадна уламжлалт мал ахуйн ахуйн хүнд хэцүү ажлыг гүйцэтгэдэг байна. Ер нь салангид амьдарч

байгаа гэр бүлийн амьдралын хэв маяг нь сэтгэл зүйн эрүүл мэндэд нөлөөлж буй асуудлыг харгалзаж үзэх хэрэгтэй.

Мөн бид дээр үзсэнчлэн салангид амьдарч буй өрхүүдийн эхнэрүүд илүү бие даасан, хүчтэй болж байгаа. Манай судалгааны ажилд оролцсон хүмүүс шүүд хэлж яриагүй ч Монгол орны өөр газар нутагт болж байгаа баримтуудыг түшиглэж үзвэл энэ маягын хүйсийн харилцааны өөрчлөлтүүд, ялангуяа уул уурхайтай холбоотой архидалт гэх мэт нийгмийн асуудлууд жендерт суурилсан хүчирхийлэл гарахад нөлөөлж болно. Түүнчлэн зарим оролцогчдын хэлснээр жендерийн харилцааны өөрчлөлтүүд салалтыг ихэсгэж байна. Ялангуяа отороор явж буй малчид, уул уурхайн компаниудад ажиллахаар ирж буй түр зуурын ажилчид, бусад сумдаас ирж буй хууль бус гар аргаар уурхай эрхлэгчид, Олон-Овоо, Цомог багын төмөр замтай холбоотой хөдөлгөөн гэх мэт суманд гадна, дотны хүмүүсийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой юм. Манай суурь судалгаагаар албан ёсын салалтын түвшин бага дүнтэй гарсан ч олон янзын албан бус харилцаатай гэр бүлийн тэргүүнтэй хэд хэдэн өрх байсан. Тэдний олонх нь шашин шүтлэггүй бөгөөд гэр бүлийн амьдрал нь тодорхой хэмжээгээр тогтворгүй гэдгийг бид мэдсэн юм. Мөн үүнд “хуурамч” салалтын асуудал багтаж байгаа бөгөөд өрхийн газар олж авах зөв стратеги гэж ойлгож болох ч нийгэмд гарах урт хугацааны үр дагаваруудыг тооцоолоход хэцүү юм. Хосууд нэгдсэн эдийн засагтай байдаг учир “хуурамч” салалтын улмаас өрхийн үндсэн бүтэц өөрчлөгдөдгүй. Гэхдээ энэ нь эмэгтэйчүүдийг өрх гэртээ туслах чухал үүрэгтэй, илүү хүчтэй болгож нэмэлт өвөлжөө, бэлчээр олж авч өөрсдийн нэр дээр эрхээ авч “хуурамч” салалт жинхэнэ болж хувирахыг үгүйсгэхгүй.

Нөгөө талаар эдгээр бүх нийгмийн өөрчлөлт, уламжлалт хэвшил нь ихэнх гэрлэсэн хосуудын сэтгэлийг зовоож буйг бид мөн олж харсан. Жишээ нь газрын баримт бичиг дээр эрэгтэй хүний нэрийг тавьж, өрхийн тэргүүн гэж үзэх гэх мэт. Энэ нь гэрлэсэн эмэгтэй бүрийг хэрэв салалт тохиолдвол хөрөнгөө алдах эрсдэлтэй, эмзэг болгож байгаа юм. Мөн салангид амьдарч буй амьдралын хэв маягт байдаг ачаалал, дарамтаас болж гэрлэлтэд ямар нэгэн хэцүү асуудал үүсэхэд гарах гарц хязгаарлагдмал болдог.

Манай ЗБУ, ХХЯ-н оролцогчид ерөнхийдөө суманд гарч буй эдгээр өөрчлөлтийн ихэнх нь эмэгтэйчүүдэд эерэг нөлөө үзүүлж байгаа гэдэгтэй санал нийлж байсан ба ялангуяа сумын төв дээр амьдарч байгаа гэрлэсэн эмэгтэйчүүдийн хувьд эсхүл албан ажилтай өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн хувьд. Эмэгтэйчүүд сумын нийгэм, эдийн засгийн амьдралд идэвхтэй оролцдог ба олон нутгийн манлайлагчид эмэгтэй хүн байсан. Суурин маягын амьдралын хэв маягыг илүүд үзэж мал маллахыг хүсэхгүй байгаа эмэгтэйчүүдэд бидний 2016 оны ажлын үеэр харсан эдгээр өөрчлөлт үнэхээр зөв зүйтэйд тооцогдож байж болох. Гэхдээ сумын төвийн өрх толгойлсон эмэгтэйтэй ядуу өрхийн төлөөллүүд засаг захиргаанаас эмзэг бүлгийн хүмүүсийг дэмжих хэрэгтэй гэж хэлж байсан ба жишээ нь Даланжаргалан суманд байгаа бүх өрх эхнэр, нөхөр гэсэн уламжлалт гэр бүлийн бүтэцгүй байгаа нөхцлийг харгалзан тэднийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэсэн юм.

Дүгнэлт

Даланжаргалан сумын амьдрал ардчилал гарснаас хойш сүүлийн 20 гаруй жилийн туршид нэлээдгүй өөрчлөгджээ. Бүхэлдээ уламжлалт мал аж ахуй эрхэлж байсан нийгмээс уул уурхай, аж үйлдвэрийн тэсрэлттэй уялдаад нийгмийн хурдацтай өөрчлөлтүүд гарчээ. 1990 ээд оноос хойш орон нутагт уул уурхайн салбар хөгжиж ирснээс хойш сумын газар, байгалийн нөөцийн талаар уурхайчид малчдын хооронд, мөн малчид өөрсөд дунд зөрчил, маргаан гарах нь элбэг болсон бололтой. Бидний 2016 оны ажлын үеэр уулзаж ярилцсан хүмүүс нийтээрээ уул уурхайгаас шалтгаалж бэлчээрийн доройтол, цэвэр усны хомсдолд орж байна гэж үзэж санал нэгдсэн юм. Хүмүүс бичил уурхай эрхлэгчид, бүх төрлийн хэмжээтэй уул уурхайн компаниудын аль альных нь үйл ажиллагаанд тийм ч таатай бус ханддаг ба нийгэм болон эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, мөн байгаль орчны асуудлуудын тухай санаа зовнисон сэтгэгдлээ хуваалцаж

байлаа. Уул уурхайн компаниудын үйл ажиллагааны тухай мэдлэг, мэдээлэл хомс байдгаас ийм байдалд хүрсэн байх магадлалтай. Мөн уул уурхайн компаниудын уурхайн газрыг нөхөн сэргээх, нутгийн байгаль орчин, малчдын бэлчээрийн газрын эдэлбэрийн эрхийг хамгаалахад орон нутгийн засаг захиргаанаас хяналт тавьж санаачлагатай оролцох ёстой гэдгийг ерөнхийдөө хүмүүс шаардаж байгааг бид анзаарсан юм. Харин нөгөө талаар орон нутгийн иргэд уул уурхай, үйлдвэрийн ажилчдад мах, хүнсний ногоо борлуулах, дэлгүүр ажиллуулах, үйлчилгээ явуулах зах зээлтэй болсон. Мөн тэдэнд уул уурхайн салбарт ажил эрхлэх боломж нээгдсэн.

Даланжаргалан дахь уул уурхайн хөгжил сайн бэлчээрийн хомсдолд хүргэж байгаа гэж иргэд үздэг, бидний ажигласнаар бэлчээрийн маргаан хэвийн зүйл болж байна. Орон сууц, өвөлжөө, хаваржааны газарт хувийн өмчлөлийн эрх олгож газар эдэлбэрийг албан ёсоор баталгаажуулсны улмаас хашаажуулах практик элбэгшиж, улирлын нүүдэл зэрэгцэж бүүрсан байна. Цаашлаад малчдын амьдрал илүү суурин тал руугаа болж байгаа энэ хандлага нутгийн бэлчээрийн тогтвортой байдалд дарамт учруулж байна. Ялангуяа 2008 оноос малчдын хэдэн үеэрээ нутаглан ирсэн бэлчээрийн уламжлалт эдэлбэрийн эрхийг баталгаатай болгох зорилгоор өвөлжөө, хаваржааны газрын гэрчилгээ олгох (эзэмших гэрчилгээ) ажил эхэлснээр малчдын дунд газраа алдах, гэрчилгээгүй газартай хоцрох вий гэсэн айдсаас үүдэлтэй газрын маргаан ихэссэн. Ингэснээр малчдын нүүдэл багасаж, уламжлалт газрын менежментийн практик өөрчлөгдөхөд нөлөөлж байгаа бөгөөд үүний үр дагавар одоогоор тодорхой болоогүй байна.

Даланжаргалан сумын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт бэлчээрийн мал аж ахуйн амьдралын хэв маяг, өрх болон нутгийн иргэдийн дунд жендерийн харилцаа өөрчлөгдөхөд нөлөөлсөн. Уламжлалт нүүдлээс холдож бэлчээрээ хувьдаа хаших хандлагатай болж буй бэлчээрийн менежментийн өөрчлөлтүүд малчин айл өрхийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хооронд өрхийн түвшинд гарч буй өөрчлөлтүүдтэй давхцаж байна. Хамгийн наад захын жишээ нь салангид амьдардаг айл өрхүүд буюу хүүхдээ боловсрол эзэмшүүлэхийн тулд жилийн ихэнх цагт хосууд тусдаа амьдардаг явдал юм. Сумын төв дээр хүүхдүүдтэйгээ байдаг эмэгтэйчүүд мэдээлэлд илүү ойртож, бие даасан байдлаа нэмэгдүүлж, зарим тохиолдолд албан ажил эрхлэх, арилжаа наймаа хийж байхад эрэгтэйчүүд өвөлжөөндөө хоцорч гэр орны ажил хийж, улам бүх асуудалтай болж байгаа мал маллах ажил хийдэг. Энэ амьдралын шинэ хэв маяг сумын төв дээр гишүүн нь амьдарч газрын гэрчилгээгээ хөөцөлдөх, зах зээлд ойртох боломжтой болох зэргээр айл өрхөд бүхэлдээ ашиг тустай байдаг ч жинхэнэ үр дагавар нь тодорхой болоогүй байна. Нөгөө талаар “хуурамч” салалт хийснээр эмэгтэйчүүд өөрсдийн нэр дээр өвөлжөө авах боломж олгож байгаа ч гэр бүлийн харилцаанд дарамт үүсгэж, яваандаа жинхэнэ салалтад хүргэж болзошгүй.

Социализмын үед өсч өндийж, ажиллаж байсантай нь харьцуулахад илүү хэцүү эдийн засгийн орчинд өрхийн үйлдвэрлэл эрхлэхийн тулд шургуу ажиллаж байгаа гэрлэсэн хосуудад бие биедээ итгэх итгэл их байдаг бололтой. Гэсэн хэдий ч ерөнхийдөө эмэгтэйчүүд ямар нэгэн байдлаар, ялангуяа зарим бүлгийн эмэгтэйчүүдийн (эрэгтэйчүүдийн) байдал дор байгаа нь ажиглагдаж байв. Жендерийн харилцааны асуудлууд, мөн уул уурхайн эргэн тойрон дахь асуудлуудыг шийдвэрлэхийн тулд илүү далайцтайгаар мэдээлэл солилцох арга зам олох, газар болон байгалийн нөөцийн засаглал, менежментэд нутгийн бүх хүмүүсийн, ялангуяа сумын ядуувтар, илүү эмзэг бүлгийн хүмүүсийн оролцоог нэмэгдүүлэх нь чухал байна.

